

MONGOLIAN ECONOMY

2015 оны 11 сар. №21 (100)

www.mongolianeconomy.mn

ОНЦЛОХ


Компанийг компани шиг л ажиллуулах хэрэгтэй

Орон нутгийн гэрээ олон талын тэнцвэрийг олох
учиртай

ЭДИЙН ЗАСАГ

Хятадад хангалттай өсөлт бий

ТОМ ӨӨРЧЛӨЛТИЙН ЭХЭНД



Дэлхийн эдийн засгийн замын зураг
бүтэн жилийн турш тантай хамт

Дэлхий 2016

Дэлхий нийтийн ирээдүйн таамаг

The Economist Таны ирэх
жилийн хөтөч

The Economist сэтгүүлийн
“THE WORLD IN 2016” жилийн
дугаарыг Монгол дахь албан ёсны тусгай
зөвшөөрөл эзэмшигч **“Mongolian Economy”**
сэтгүүл монгол хэлээр эрхлэн гаргах гэж
байна.

2016.01 сард танд хүрнэ



Утас 94092904, 94092905, 70115476, 70115477
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn



DX-2500N / 2000U

Digital Full Colour Multifunctional System

БИЧИГ ЦААСНЫ АЖЛАА ӨРТӨГ БАГАТАЙ **ӨНГӨТ А3**
ШИЙДЛЭЭР САЙЖРУУЛАХ ЦАГ НЬ БИШ ГЭЖ ҮҮ?




Copy

Network Print

Network Scan

Fax
OPTION



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.БЭХБАР / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.ҮҮРИЙНТУЯА

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.ТҮВШИН

ОРЧУУЛАГЧ:

Б.ЭНХМӨНХ

ВЭБ РЕДАКТОР:

Б.ЭНХЦЭЦЭГ

СЭТГҮҮЛЧИД:

Г.ОРХОН

Ц.ЭЛБЭГСАЙХАН

ДИЗАЙНЕР:

Б.СЭР-ОД

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904/

Э.ЗОРИГТ /9409 2905/

ХАЯГ

УЛААНБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ.

1 ХОРОО, ЭНХТАЙВНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ.

ЭКСПРЕСС ТАУЭР. 1101 ТООТ

15160 УЛААНБААТАР, ТӨВ ШУУДАН,

Ш/ Х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“УЛААНБААТАР ПРИНТ” ХХК-д хэвлэв

WWW.UBPRINT.MN

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

“ИНТЕР НОМ”

“ЦЭЦЭГ ТӨВ”

“МИНЖ ПЛАЗА”

“АЛТАНТҮЛХҮҮР” НОМЫН ДЭЛГҮҮР

“НОМИН” СУПЕРМАРКЕТИЙН БҮХ САЛБАР

“МАКС” СУПЕРМАРКЕТИЙН БҮХ САЛБАР

“ФРЕСКО” СУПЕРМАРКЕТ

BTSI СУПЕРМАРКЕТ

“АЗ ОРЧЛОН” НОМЫН ДЭЛГҮҮР

“БИЛЭГ” ИХ ДЭЛГҮҮРИЙН НОМЫН ТАСАГ

“ГРАНД ПЛАЗА” ДАХЬ СУПЕРМАРКЕТ

“МИР” НОМЫН ДЭЛГҮҮРИЙН

“GRAND PLAZA”

“METRO MALL”

“SKY” СУПЕРМАРКЕТ

“УЛААНБААТАР” ИХ ДЭЛГҮҮР

“MAX MALL” ДЭХ САЛБАРУУД

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм уншигчдадаа шинэхэн цастай, дангинасан жавартай, айсуу шинэ жилтэй сарын мэнд дэвшүүлье.

Манай сэтгүүл энэ удаагийн дугаартаа эдийн засаг, бизнесийн үндсэн сэдвүүдээс гадна төрийн өмчит компаниудын засаглалын асуудлыг онцоллоо. Компани ашигтай ажиллах учиртай. Гэтэл хувийн компаниуд шинээр үүсэж, хөгжиж хөл дээрээ зогсож, улмаар эрийн цээнд хүрдэг байхад төрийн нэртэй компаниуд яагаад аргамжаатай морь шиг зогсдог вэ. Тэд ашиг гэхээсээ алдагдал ярих нь их. Компанийн хөгжлөөс ангид байх учиртай

авлига хээл хахууль, арын хаалганы асуудал тэднийг аалзны тор мэт хэрэх нь амархан. Төсвийн алдагдал, өрийн дарамтад ороод буй Монгол Улс хэдий болтол төрийн өмчөөр далимдуулж ард түмний татварын мөнгөөр амар хялбар аргаар мөнгө олж, баяжиж цадахыг хүсэгчдийг хооллож, ундлах ёстой гэж.

Эдийн засгаа сайжруулъя гэвэл хэр хэмжээнээсээ хэтрээд он удаан жилийг үдэж буй дээрх асуудлыг таслан зогсоож, хөгжлийн зөв замд нь буюу зах зээлд даатгах цаг өнөөдрөөс цааш газар үгүй гэдэг болоод байна. Тиймээс асуудал юундаа буй, гарц нь юу байх вэ гэдэгт бид анхаарлаа хандууллаа. Төрийн өмчийн компанийн засаглал яагаад муу байдаг, засаглалыг хэрхэн сайжруулж болох талаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирал Б.Бямбасайханы ярилцлага танд нэгийг бодуулна. Түүнчлэн манай бусад нийтлэлүүдээс Төрийн өмчийн тухай хуулийн төслийн талаар мэдээлэл авч, мэргэжилтнүүдийн хийсэн төрийн компаниудын засаглалын судалгаатай танилцаж, Сингапурын төрийн өмчит корпораци Темасекийн туршлагыг ч судалж болно.

Мөн өнгөрсөн сард аж үйлдвэрийн яамнаас хийсэн “Made in Mongolia”, энэ сард болсон Компанийн нийгмийн хариуцлагын V үндэсний форумын үеэр юу хэлэлцсэнийг хүргэж байна.

АХБ-ны БНХАУ дахь Суурин төлөөлөгчийн газрын Эдийн засгийн асуудал хариуцсан нэгжийн дарга Юрген Конрад урд хөршийн эдийн засгийн талаар юу ярьсныг сонирхоорой.

Орлогч эрхлэгч И.ОТГОНЖАРГАЛ

“ P8



Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд тэр дундаа тэргүүлэх салбарын төрийн өмчит компаниудын засаглал тун чамлалттай байна. Үүнийг энэ талаарх судлаачдын үнэлгээний тайлангаас харж болно. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниудын засаглалын үнэлгээ өнгөрсөн оны байдлаар 28 хувьтай байна. Энэ нь Хонконг, Тайланд, Филиппин зэрэг улстай харьцуулахад 2-3 дахин муу үзүүлэлт бөгөөд эдгээр улсынх 72-77 хувь байгаа юм.

“ P28



Хөрөнгө оруулагчын талаас үзэхэд маш цөөн тооны айл өрхүүд л хувьцаанд хөрөнгө оруулдаг. Макро эдийн засгийн талаасаа хөрөнгийн зах зээлийн савалгаа үндсэндээ чухал үйл явдал байгаагүй...

ОНЦЛОХ

- 8 Төрийн компаниудын үнэн төрх
- 9 “Төмөр” суудлын эзэд
- 12 Б.Бямбасайхан:
Компанийг компани шиг л ажиллуулах хэрэгтэй
- 14 Төрийн өмчийг дахин хуваарилах нь
- 15 Б.Байлийхүү:
Төрд аж ахуйн нэгж байгуулах цөөхөн тохиолдол бий
- 18 Темасек ба төрийн өмчийн шинэ эрин
- 20 Орон нутгийн гэрээ олон талын тэнцвэрийг олох учиртай
- 24 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үндсэн үзүүлэлт

ЭДИЙН ЗАСАГ

- 28 Сонгуультай жилийн тооцоолол
- 29 С.Эрдэнэ ба Эрдэнэс-Таван толгой
- 31 10 тэрбум ам.долларын зорилт
- 33 Юрген Конрад:
Хятадад хангалттай өсөлт бий
- 35 Үйлдвэржилтийн шинэ зам
- 37 Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн гарц
- 39 Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудал сэтгэл зовоож байна
- 41 Нийгмийн Хөгжлийн Индекс 2015: ДНБ-ээс давж харах нь
- 44 Цуст баасан гараг

“ P44



Францын нийслэл Парис хотноо 2015 оны арваннэгдүгээр сарын 13-ны орой зохион байгуулалттай цуврал террорист халдлага болсон билээ.

МОНГОЛД ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ



Энэтхэг улсын Аж үйлдвэрийн холбоо, тус улсын Засгийн газар, Бичил, жижиг, дунд үйлдвэрийн яамтай хамтран ирэх сарын 7-8-нд "Олон улсын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дээд хэмжээний уулзалт 2015"-ыг Шинэ Дели хотын "Хабитат" төвд зохион байгуулах гэж байна. Тус дээд хэмжээний уулзалт "Энэтхэг улс, олон улсын ЖДҮ эрхлэгчдийн түншлэл" сэдвийн хүрээнд явагдах аж.

Энэхүү уулзалтын зорилго нь Энэтхэг болон олон улсын ЖДҮ эрхлэгчдийг холбох, харилцан туршлага солилцох, Энэтхэг улсын хөгжиж буй зах зээлийг судлах явдал аж. Мөн жижиг, дунд үйлдвэрийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх, хил дамнасан хамтын ажиллагааны зах зээлийг тодорхойлох, бизнесийн удирдагчид олон талт, олон улсын санхүүжүүлэгч байгууллагууд нь хүчтэй тавцан бий болгох чиглэлээр ажиллах юм байна. Чуулга уулзалтын үеэр салбарын өсөлт болон бизнесийн, технологийн давуу талуудыг таниулах уулзалт болох юм.

ЭРЧИМ ХҮЧ



Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатын ХБНГУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр "Баруун Монгол энержи" ХХК-ийн захирал Б.Алтангэрэл ХБНГУ дахь Монгол, Германы хамтарсан "Сакс энержи

Монголиа" ХХК-ийн захирал Франк Коккиш нар Улаангом хотноо 60 мВт-ын эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Энэхүү цахилгаан станц нь хабрид буюу нүүрснээс гадна сэргээгдэх эрчим хүчээр тэжээгдэхээрээ улсдаа анхдагч болох юм. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн энэ төрлийн цахилгаан станцтай болсноор баруун аймгууд дотоодоосоо эрчим хүчний хэрэглээгээ хангаж, ОХУ-аас эрчим хүч импортлох шаардлагагүй болно.

Төслийг төр, хувийн хэвшлийн хамтарсан концессийн гэрээгээр хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт 120 сая еврогийн зээлийг "Баруун Монгол энержи" ХХК-ийнхэн 40 жилийн дотор өөрийн хөрөнгөөр барагдуулахаар санамж бичигт заасан байна.

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ



Засгийн газрын ээлжит хуралдаанаар "Улаанбаатар хотод шинээр цэвэрлэх байгууламж барих-250 мянган шоо метр/хоног хүчин чадалтай төсөл"-ийг концессоор гүйцэтгэхээр шийдвэрлэлээ.

Техник тоног төхөөрөмж нь хуучирч муудсанаас байгууламжийн эрчим хүчний хэрэглээ өндөр, эрчим хүчний зардалд нэг сард 250 сая төгрөг зарцуулж байна. 1964 онд байгуулагдсан Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл, барилга байгууламжийн их засвар хийх, 250 мянган шоо метр /хоног хүчин чадал бүхий шинэ цэвэрлэх байгууламж барих зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар нарт даалгалаа.

ХУУЛЬ



Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Хуулийн төсөлд Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тус тус авч байгаад нас барсан иргэний 15 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр эсхүл нөхөр нь хамтын тэтгэвэр авах эрхтэй хэмээн тусгасан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна.

Мөн хамтын тэтгэвэр авах эрх үүссэн тэтгэвэр авагчид олгох хамтын тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, үнэ ханшийн өөрчлөлттэй уялдуулан Засгийн газар жил бүр тогтооно, хамтын тэтгэвэр нь Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээний 20 хувиас багагүй байна гэсэн саналууд мөн олонхын дэмжлэг авчээ. Ингээд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлээ.

АСЕМ



Монгол Улсын Гадаад хэргийн яам Ирэх оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 42 орны иргэдийг буцаан визтэй зорчуулах болсон талаар мэдэгдэв.

Улаанбаатар хотноо ирэх онд зохион байгуулагдах АСЕМ-ын 11 дэх Дээд түвшний уулзалтын бэлтгэл

ажлын хүрээнд Монгол Улс визийн нөхцөл болон хилийн хяналтаа чангатгах шаардлагатай болоод байгаа. Үүнтэй холбогдуулан дээрх орны иргэдийг 2014 оны зургадугаар сараас эхлэн Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчуулж ирсэн нөхцлийг үргэлжүүлэхгүй байх шийдвэрийг гаргасан байна.

Мөн “Дээд түвшний уулзалтын болон уулзалтад оролцохоор ирэх АСЕМ-ын гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нарын аюулгүй байдлыг хангахын тулд дотоодын аюулгүй байдлын холбогдох зохицуулалтуудыг боловсронгуй болгохоос гадна, шаардлагатай гэж үзвэл гадаадын улсуудтай байгуулсан иргэд харилцан визгүй зорчих хэлэлцээрүүдийн үйлчлэлийг түр хугацаагаар зогсоох хүртэлх арга хэмжээг авч магадгүй” хэмээн ГХЯ-наас мэдээлж байна.

ДЭЛХИЙД


ЭНЭТХЭГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСӨЛ



Бүх Энэтхэгийн анагаах ухааны хүрээлэнд (AIIMS) урд өмнө хэрэгжиж байгаагүй хорт хавдар болон титэм судасны хаалтын эсрэг эм бэлдмэл зэрэг өндөр үнэтэй эмчилгээний төлбөрийг багасгах хөтөлбөр хэрэгжиж эхэлжээ. Хямд эм болон Найдвартай шилжүүлэн суулгалт хөтөлбөрийн (AMRIT) хүрээнд хорт хавдар болон зүрх судасны өвчний эмчилгээнд хэрэглэдэг 202 төрлийн эм бэлдмэлийн үнэ 60-90 хувь буурах аж. Түүнчлэн, 148 төрлийн зүрхний суулгац зах зээл дээрх үнээс даруй 50-60 хувь хямд борлуулагдах юм. Уг төслийг Энэтхэгийн төрийн өмчит эм болон эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч "HLL Lifecare"-тай хамтран хэрэгжүүлэх аж. Уг туршилтын

хөтөлбөр тус улсын эрүүл мэндийн холбооны сайд Ж.П.Наддагийн санаачлагаар арваннэгдүгээр сарын 15 өдөр хэрэгжиж эхэлжээ.

ДЭЛХИЙН ХАНДИВЛАХ ИНДЕКС 2015



Энэрлийн тусламжийн сан дэлхийн хандивын индексийг зургаа дахь жилдээ дараалан гаргалаа. Тус индекс өгөөмөр, энэрэнгүй зан байдлыг хэмждэг бөгөөд судалгаанд дэлхийн нийт хүн амын 96 хувьтай тэнцэх 145 орныг хамруулдаг аж. Судалгааны үр дүнг улс тус бүрийн иргэдийн хандивласан мөнгө, сайн дурын ажил болон танихгүй хүнд тусалсан дундаж хувийг тооцоолсноор гаргадаг юм байна. Энэхүү жагсаалтыг Мьянмар улс тэргүүлсэн бөгөөд АНУ хоёрдугаарт оржээ. Уг жагсаалтаас үзэхэд хөрөнгө мөнгө хүний өгөөмөр байдалд тийм ч их нөлөөтэй биш гэдэг нь харагдаж байна. Жагсаалтын топ 20-д G20-ийн улсууд бөлөх хамгийн баян 20 орны зөвхөн таван улс багтжээ. Харин G20-ийн зургаан улс (үүнд БНХАУ, ОХУ болон Бразил улс) жагсаалтын топ 100-д багтаж чадсангүй. Монгол Улсын хувьд жагсаалтын 52-т бичигджээ. Судалгаагаар өнгөрсөн сар 2.2 тэрбум хүн танихгүй хүнд тусалсан бол 1.4 тэрбум хүн мөнгө хандивласан бөгөөд нэг тэрбум хүн сайн дурын ажил хийсэн байна.



ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН УНАЛТ

Арваннэгдүгээр сарын 19-ны пүрэв гаригт Япон улсын төв банк Япон улс эдийн засгийн уналтад орсон ч бодлогын хүүгээ тогтвортой барина гэж мэдэгдлээ. Хөгжиж буй зах зээлийн сул эрэлт Японы экспорт болон үйлдвэрлэлийг жилийн хугацаанд анх удаагаа буурахад хүргэв. Япон улсын төв банк засгийн газрын бонд болон эрсдэлтэй хөрөнгө худалдан авах замаар суурь мөнгийг (бэлэн мөнгө болон төв банк дахь хадгаламж) жилийн 80 их наяд иенийн (650 тэрбум ам.доллар) хурдацтайгаар нэмнэ гэж дахин амлалаа. Гэсэн хэдий ч, Ройтерс агентлагийн явуулсан санал асуулгад хамрагдсан шинжээчдийн тал нь Японы төв банк ирэх нэгдүгээр сараас эхэлж мөнгөний нийлүүлэлтээ нэмнэ гэж таамаглажээ. Газрын тосны үнийн уналтаас үүдэлтэй дифляци бодит асуудал болж байгаа ч илүү мөнгө хэвлэснээр бүх асуудлыг хараахан шийдэж чадаагүй байна.



ГРЕКИЙН СУНЖИРСАН АСУУДАЛ

Грек улс болон түүний олон улсын зээлдүүлэгчид дараагийн шатны эдийн засгийн арга хэмжээнд тохиролцсон нэмэлт 12 тэрбум еврогийн зээлийн тохиролцоонд хүрлээ. Грекийн албаныхан аравдугаар сард батлагдсан арга хэмжээг 86 тэрбум еврогийн тусламжийн хөтөлбөрийг авахад хангалттай гэж найдаж байсан ч Еврозоны санхүүгийн сайд нар авсан арга хэмжээг хангалтгүй гэж үзжээ. Энэ удаагийн гол асуудал асар их өрөнд унасан Грекийн орон сууц ээмшигчид барьцаанд тавьсан хөрөнгөө алдахаас хамгаалах арга хэмжээнд хамрагдах эсэх байлаа. Тохиролцоонд хүрч чадсан 12 тэрбум еврогийн 2 тэрбум нь Грекийн дотоодын хэрэгцээнд зориулагдах бол үлдсэн 10 тэрбум нь тус улсын банкуудыг санхүүжүүлэхэд зориулагдах аж. ■

Төрийн компаниудын үнэн төрх

Г.Орхон

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд тэр дундаа тэргүүлэх салбарын төрийн өмчит компаниудын засаглал тун чамлалттай байна. Үүнийг энэ талаарх судлаачдын үнэлгээний тайлангаас харж болно. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниудын засаглалын үнэлгээ өнгөрсөн оны байдлаар 28 хувьтай байна. Энэ нь Хонконг, Тайланд, Филиппин зэрэг улстай харьцуулахад 2-3 дахин муу үзүүлэлт бөгөөд эдгээр улсынх 72-77 хувь байгаа юм.

Хэдий уг ойлголт нь Монголын хувьд шинэлэг зүйл гэдэг үгээр өнөөгийн компаниудын тааруу засаглалыг хаацайлж болох ч угтаа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд ил тод, шударга байх ёстой. Нөгөөтэйгүүр, компанийн засаглал нь улсын төдийгүй дэлхийн эдийн засгийн тогтвортой байдалд ихээхэн эерэг нөлөө үзүүлдэг гэж судлаачид үздэг. Тиймээс өнөөдрийн муу засаглалтай компаниудын засаглалыг сайжруулах нь чухал асуудал.

ТЭРГҮҮЛЭХ САЛБАРЫН МУУ ЗАСАГЛАЛ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад компанийн засаглалын зохицуулалт сайжирч, холбогдох дүрэм журам гарч байгаа ч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалын дундаж үнэлгээ хангалтгүй байна. Уг үнэлгээ



эдийн засагч Д.Байлхүү ахлагчтай багийнхны өнгөрсөн онд хийсэн судалгаа харуулж байгаа юм. Тэд судалгаандаа олон улсын санхүүгийн корпорацийн боловсруулсан арга зүйг ашиглажээ.

Судалгаанд “Эрдэнэс Монгол” ХХК, “Оюутолгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК тэргүүтэй төрийн өмчит есөн компанийг оролцуулсан бөгөөд эдгээрийн дийлэнх нь авбал зохих онооны дөнгөж гуравны нэгийг л авсан байна. Харин “Оюутолгой”

ХХК арай өндөр үзүүлэлт буюу 48 хувийн үнэлгээ авсан байна. Гэвч энэ нь зуун хувийн талд хүрэхгүй буйг анхаарах хэрэгтэй. Эдгээр компанийн засаглалын дундаж үнэлгээ 28 хувь байгаа бөгөөд энэ нь Азийн орнуудтай харьцуулахад даруй 1.5-2.5 дахин бага дүн. Засаглалын үнэлгээ ийн тааруу гарсан нь мэдээллийн ил тод байдал, чухал хэлцэл хийж байгаа болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж буй байдал зэрэг нь чамлалттай буйгаас үүдэлтэй аж.

Компанийн засаглалын үнэлгээ



Төрийн өмчит уул уурхайн компаниудыг засаглалын нэгдсэн үнэлгээ (үзүүлэлтээр)

Үзүүлэлтүүд	Ерөнхий үнэлгээ
Хяналтын тогтолцоо	2.7
Дүрэм ба бусад эрхийн актууд, тэдгээрийн агуулга	2.6
ТУЗ	1.7
Гүйцэтгэх удирдлага	1.7
ХЭ-ийн эрхийн хамгаалалт	1.7
ХЭ-ийн хурал	1.2
Ногдол ашиг	1
Зарим чухал хэлцлийг хийж буй байдал	0.6
Мэдээллийн ил тод нээлттэй байдал	0.4
Ерөнхий дүн	1.4

Товчхондоо эдгээр компанийн дээрх чиглэлээр хийж буй ажил хуулийн дагуу бус, хамгийн доголдолтой байна гэлээ. Компанийн засаглал тэр дундаа, нийтийн өмчид суурилж бизнес эрхэлж буй төрийн өмчит уул уурхайн компанийн засаглал сайн байх нь тухайн байгууллагын үйл ажиллагаа сайжрах, нийтийн баялгийг үрэгдүүлэхээс сэргийлдэг. Нөгөө талаас, гадаад дотоодын зээл, хөрөнгө оруулалтыг татаж урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг нэмэгдүүлдгийг судалгааны багийнхан онцолжээ.

“Төрийн өмчит компанид төрийн төлөөллийн хэрэгжүүлэх эрх зүйн үндэс тодорхой бус байгаагаас эл асуудал тодорхой албан тушаалтны санаа, зоригын асуудал болсон байна гэж” эдийн засагч Д.Байлхүү хэлсэн. Үүнийг тэрбээр тайландаа “Төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьд төрийн төлөөллийн хэрэгжүүлэх ажиллагаа хангалтгүй, түүний хэрэгжүүлэх зохицуулалт нь нэг мөр болж цэгцрээгүй, энэ талын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмын заалтууд тодорхой бус ойлгомжгүй байна. Ийнхүү асуудал тодорхой бус байх нь албан тушаалтан өөрийн үзэмж, үзэл санаагаар асуудлыг шийдэх бололцоог бий болгодог” хэмээн тэмдэглэжээ.

Компанийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг нээлттэй болгох талаар гарсан хуулийн заалт хэрэгжихгүй байгааг судалгааны тайланд дурьдсан байв. Судалгаанд хамрагдсан бүх компани энэ асуудлаар доогуур /0-1/ үнэлгээ авсан ба “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монросцвет мет” ХХК зэрэг зарим компани “0” үнэлгээ авсан байна. Мөн эдгээр компанид чухал хэлцлийг шийдвэрлэж буй байдал буруу, түүний талаарх мэдээллийг санхүүгийн тайланд тусгайлан тусгах замаар нийтэд нээлттэй болгохгүй байгаа зэрэг дутагдал нь засаглалын үнэлгээг доош татжээ.

ТУЛГУУР САЛБАРЫН “ТАЛ” ЗАСАГЛАЛ

Төрийн өмчийн эрчим хүчний компаниудын засаглалын үнэлгээ доогуур түвшинд байна. Тодруулбал, 2014 оны эцсийн байдлаар манай

улсын ийм компаниудын засаглалын үнэлгээ 30-44 хувьтай байна. Гэтэл Азийн хөгжиж буй зарим орны компанийн засаглалын уг үзүүлэлт 48-77 хувь байх. Эл үзүүлэлт нь Монголын компаниуд түүний дотор, төрийн өмчит компаниудын хувьд засаглалаа сайжруулах талаар хийх ажил их буйг харуулж байгаа юм.

Нээлттэй нийгэм форумын санаачлагаар компаниудын засаглалын өнөөгийн түвшинг тодорхойлсон судалгааны дүн ийм муу дүнтэй гарсан бөгөөд үүнд, ДЦС-2, 3, 4 тэргүүтэй 13 компанийг хамруулжээ. Байлхүү ахлагчтай судалгааны багийнхны дүгнэж буйгаар төрийн өмчит компанид төрийн төлөөллийн хэрэгжүүлэх эрх зүйн үндэс тодорхой бус буйгаас энэ нь тодорхой албан тушаалтны дур зоргын асуудал болоод байгаа аж. Компаниудын үнэлгээг доош татаж буй “0” үнэлгээ авсан үзүүлэлтүүдийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлага зэрэг төрийн төлөөллийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд тэргүүнд бичигджээ.

Компанид сайн засаглалыг бий болгох чухал нөхцөл нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох явдал гэдэг. Гэтэл уг судалгаанд хамрагдсан компаниудын ихэнх нь энэ асуудлаар тодорхой ахиц гаргаагүй. Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуульд мэдээллийг ил тод болгох талаар заалтууд орсон ч хэрэгжилт тааруу буйг уг тайлан харуулж байгаа юм.

Эдгээр компанийн засаглалын үнэлгээг бууруулсан өөр нэг чухал үзүүлэлт бол тухайн компани дээр сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хийж байгаа явдал гэнэ. Эдгээр хэлцлийг хийх журам нь Компанийн тухай хуулиар бүрэн зохицуулагдсан ч компаниуд журмын дагуу хэлцэл хийхгүй байгаа аж. Энэхүү үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан компаниуд 0.5 оноо авчээ. Чухал хэлцлүүдийг зүй ёсоор хийх нь компанид ашигтайгаас гадна эрх бүхий албан тушаалтан болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн хувийн сонирхлоос компанийг хамгаалах чухал хэрэгсэл болох ёстойг Д.Байлхүү онцолсон.


Монгол Улсын гол салбарууд гэгдэх эрчим хүч, уул уурхайн салбар дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалын өнөөгийн дүр зураг нэг ийм муу дүнтэй. Түүнчлэн тэд компанийн засаглалын талаар гарсан хуулийн заалтууд болон энэ талаарх олон улсын байгууллагаас гаргасан нийтлэг зарчмыг хангалттай сайн хэрэгжүүлж хэвшил болгохгүй байгааг судлаачид онцолжээ.

Төрийн өмчийн компаниудын засаглалын үнэлгээг судалсан багийнхны зүгээс судалгаанд хамрагдсан компаниуд засаглалаа сайжруулах талаар хийх ажлыг нь тус бүрийнх нь тайланд дэлгэрэнгүй тусгаж өгсөн гэв. Энэхүү зөвлөмж нь угтаа энэ хоёр салбар дахь төрийн менежментийг оновчтой, ил тод нээлттэй болгох гол өгөөжийг агуулж байгаа аж. ■

Төрийн өмчит эрчим хүчний компаниудын мэдээллийн ил тод нээлттэй байдалд өгөх үнэлгээ

Компанийн нэр	Мэдээллийн ил, тод нээлттэй байдал	
	Оноогоор	Хувиар
ДЦС-4ТӨХК	1.6	32
ДЦС-3ТӨХК	1.9	38
ДЦС-2ТӨХК	2.1	42
ДДЦС ТӨХК	1.2	24
ЭДЦС ТӨХК	0.8	16
УБЦТС ТӨХК	2.4	48
ДБЭХС ТӨХК	2.2	42
БНЗӨБЦТС	2.5	50
УБДС ТӨХК	2.0	40
ЦДҮС ТӨХК	2.1	42
ЭБЦТС ТӨХК	0.8	16
ДҮТ ТӨХХК	2.9	58
ББЭХС ТӨХК	1.7	34
Компаниудын дундаж үнэлгээ	1.9	38
Авах ёстой дээд үнэлгээ	5.0	100

УДИРДЛАГА



“Төмөр” суудлын эзэд

Г.Түшээ

Төрийн компаниуд ашиггүй ажиллаж байна гэдэг. Угтаа тэд хэрхэн ашиггүй ажилласны язгуур асуудал юу байсан тухай хэн ч ярьж, хэлдэггүй. Тэгвэл тэднийг хоёрхон асуудал алдагдалтай ажиллахад хүргэж буй аж. Нийгмийн хариуцлага болон валютын ханшийн зөрүү. Харин үндсэн үйл ажиллагаа нь алдагдалтай ажиллаж буй компани байхгүйг Төрийн өмчийн хорооны Өмчийн удирдлагын газрын дарга В.Дарханбаатар яриу. Хэдий тодорхой компаниуд алдагдалтай ажиллаж байгаа ч алдагдал сүүлийн жилүүдэд буурч буй дүр зураг ажиглагдаж буй. Төрийн өмчийн компаниуд 2012 онд 69 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол 2013 оны гүйцэтгэлээр дээрх алдагдал зургаан тэрбум төгрөг болтлоо буурсан сайн мэдээлэл гарчээ.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой эрчим хүчний компаниудын хувьд төр үнэ барьдгаас тэд алдагдал хүлээх нь их. Мөн сүүлийн үед цөөнгүй компани хөрөнгө оруулалтын шинжтэй тодруулбал, валютын ханшийн зөрүүнээс болж нэлээд алдагдал хүлээжээ. Жишээлбэл, МИАТ компани өнгөрсөн онд “Боинг 737-800” онгоц худалдан авсан. Ингэхдээ тэд валютын ханшийн зөрүүнээс болж 50 гаруй тэрбум төгрөгийн алдагдал хүлээж. Үүний хариуцлагыг тус компанийн тухайн үеийн захирал үүрч, ажлаас чөлөөлөгдсөн тухай Төрийн өмчийн хорооны Өмчийн удирдлагын газрын дарга хэллээ. Ер нь Төрийн өмчийн хороо төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагатай энэ мэт асуудлыг шууд

тооцдог журамтай. Бусад орны ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага мөн л компанийн удирдлагуудад хяналт тавьж, тэдний ажил үүргийн биелэлтэд үнэлгээ өгдөг тухай судлаач Д.Байлхүү хэлсэн юм. Тэгэхээр төрийн компаниуд ашиггүй ажиллахад төдий хэмжээгээр захирлын суудал солигдох тухай яригддаг байна. Гэвч төрийн зарим компанийн төмөр суудал жинхэнэ эзэндээ эзлгүй ч, өөр нэгэнд тухтай байдаг тал бий.

Өдгөө Монгол Улсад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 75 хуулийн этгээд бий. Мөн төдий хэмжээний удирдлага сонгогдон тус тусын багаа удирдаж яваа гэсэн үг. 75 байгууллага нь төрийн өмчит хувьцаат компани, хязгаарлагдмал

хариуцлагатай компани, төрийн өмчийн үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой компаниудаас бүрддэг.

Төрийн үүргийг биелүүлэх даалгавартай “төмөр” суудалд суух удирдлагыг холбогдох бодлогын яамтай зөвшилцсөний үндсэн дээр Төрийн өмчийн хорооны хурлаар шийдвэрлэдэг аж. Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг Төрийн өмчийн хороо шууд томилж, нэг жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, тухайн жилд ажиллах эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг нь баталж өгдөг байна. Тэр зорилтот түвшинг биелүүлэхийн тулд захирал бүр өөрийн бүхий л нөөц бололцоогоо дайчилж ажиллах зарчимтай. Харин төрийн өмчит хувьцаат компанийн захирлыг Компанийн тухай хуулийн дагуу төлөөлөн удирдах зөвлөл / ТУЗ/ хуралдан томилдог. Гэхдээ Төрийн өмчийн хорооноос тухайн захирлын жилийн хугацаанд хийж гүйцэтгэх ажлын зорилт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж өгдөг журамтай. Ер нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагыг нэг жилийн хугацаатай томилж, тухайн жилдээ хүлээсэн үүргээ биелүүлж сайн ажилласан бол ТУЗ хуралдан гэрээг нь сунгадаг. Харин хангалтгүй бол баяртай гэдэг байна. Компаниудын удирдлагуудын үүрэгт ажлын биелэлтэд Төрийн өмчийн хороо ТУЗ-өөр дамжуулж хяналт тавьдаг аж. Хэрэв тухайн жилд батлагдснаас илүү хөрөнгө зарах зайлшгүй шаардлага гарвал ТУЗ хуралдаж шийддэг учир захирал дур мэдэх учиргүй юм. Тэгсэн хэрнээ бодит байдал дээр үүнээс арай өөр захирал цөөнгүй.

Зөвхөн захирал солигдсоноор компанийн ажил сайжрахгүй. Төрийн өмчит компанийн үйл ажиллагааг сайжруулахын тулд ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагаа сайн байх хэрэгтэй аж. Компанийн тухай хуульд зааснаар төрийн өмчийн компани том, жижгээс үл шалтгаалан ТУЗ гэсэн удирдлагын

бүтэцтэй байх ба түүний гишүүдийн тоо нь есөөс дээш байна гэж туссан. Гэвч өнөөдөр төрийн өмчит зарим компанийн ТУЗ-ийн бүтэц уг заалттай төдийлэн нийцэхгүй байгаа юм. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалын талаарх өнгөрсөн оны үнэлгээний тайланд “ТУЗ-ийн үндсэн үйл ажиллагаа холбогдох журмын дагуу явахгүй тухайлбал, компанийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс томилогдон түүнд үйл ажиллагаагаа тайлагнаж, түүгээр ажлын үр дүнгээ дүгнүүлж байх ёстой. Гэтэл Засгийн газар түүний байгууллагуудаас гүйцэтгэх захиралтай шууд харьцан үүрэг, даалгавар өгөх явдал судалгаанд хамрагдсан ихэнх компани дээр гарсан. Энэ нь компанийн ажиллагаанд ТУЗ-ийн үүргийг бууруулж буй хэрэг” хэмээн тодорхой үндэслэл бичсэн байх юм. В.Дарханбаатараас тодруулахад тэрбээр “Бид төрийн компаниудын захирлыг сонгон шалгаруулалтаар сонгож, ТУЗ-ийн гишүүдээ мөн ийм хэлбэрээр сонгон авч байгаа. Мөн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг өдөр тутмын сонинуудад нээлттэй зарлан сонгон шалгаруулж байна. Гэвч компанийн засаглалыг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд төвөгтэй зүйлс бий. Ерөнхий сайдын зөвлөмжөөр ТУЗ-д заавал ТӨХ, яамд гэлтгүй хөндлөнгөөс сонгон шалгаруулж хараат бус гишүүн сонгох гэж оролдсон. Гэтэл тэр хараат бус гишүүн “ийм жижиг компанийн ТУЗ-д ийм бага цалинтай ажиллаж юугаа хийх юм” гэх утгатай үг чулууддаг” гэв. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн гишүүн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр нугалсантай тэнцэх хэмжээний цалин авах ёстой аж.

Төрийн эрчим хүчний компаниуд толгой дараалан алдагдалтай ажилласан он жилүүд саяхан. Харин сүүлийн жилүүдэд Эрчим хүчний яам, Засгийн газраас тодорхой бодлогын хүрээнд үнийн өөрчлөлт хийснээс энэ салбарын компаниудын зарим нь ашигтай ажиллах, алдагдал нь буурах эерэг хандлага гарсан байна.

Тухайлбал, өнгөрсөн онд ДЦС-3, Улаанбаатар дулааны сүлжээ тэргүүтэй хэд хэдэн компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт ашигтай гарчээ. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын өнгөрсөн оны жилийн эцсийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтээс харахад ДЦС-3, 2.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Харин алдагдалтай ажиллаж байсан эрчим хүчний компаниудын захирлууд хэр зэрэг солигдсон талаар лавлахад Дарханбаатар “Ер нь 2012 оны сонгуулийн дараа бүх компанийн ихэнх удирдлага солигдсон” гэсэн юм.

Компанийн засаглалын талаарх 2014 оны үнэлгээний тайлангаас харахад, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд муу үнэлгээ авч. Ер нь төрийн компаниудын засаглал сул байна гэдэг. Компанийн засаглал гэх ойлголт нь тухайн компанийг засаглах юм шиг харагддаг ч угтаа компанийн удирдлагыг нээлттэй, ил тод болгох хэрэг гэдэг. Төрийн өмчийн хорооноос хэдий нээлттэй сонгон шалгаруулалтаар компанийн удирдлагыг сонгож буй гэж байгаа ч басхүү үүнд төрийн гар оролцох нь мэр сэр гэнэ.

Төрийн компанийн удирдлагуудын үүргийн тухайд ТУЗ гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулна. Харин захирал өөрийнхээ багийг удирдах үүрэгтэй. Товчхондоо, удирдлага сайн менежер байх ёстой. Аль болох бага зардлаар компанийн үндсэн ажлыг явуулах учиртай аж. Нөгөө талаас, компаниудын ТУЗ сард нэг удаа хуралдах ёстой. Цаашид төрийн өмчийн компанийн удирдлагуудыг сайжруулахын тулд тэдний сонгон шалгаруулалтыг илүү ил тод, нээлттэй болгох хэрэгтэйг Дарханбаатар хэлсэн юм.

Одоогийн байдлаар зарим тохиолдолд тэднийг шалгаруулах явц журмынхаа дагуу явахгүй байгаа аж. Харин алдагдалтай ажиллаж буй компаниудын тухайд компанийн засаглалаа сайжруулж чадвал ашигтай ажиллах боломж бийг мэргэжилтнүүд хэлдэг. ■

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Б.Бямбасайхан: Компанийг компани шиг л ажиллуулах хэрэгтэй

Д.Бэхээ



Бид том өөрчлөлтийн эхэнд байна гэж хэлж болно.

Төрийн өмчийн компаниудын өнөөдрийн байдал, цаашдын өөрчлөлт шинэчлэлийн талаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхантай ярилцлаа.

-Төрийн өмчийн компаниудын засаглалыг өөрчлөх чиглэлээр та нэлээд ажиллаж байгаа. Явц ямар байна вэ?

-Бид шинээр дугуй зохион бүтээхгүй. Монголд хэдийнэ нэвтэрсэн тэр системийг л төрийн өмчийн компаниудад мөрдүүлэх зорилготой. Маш энгийнээр тайлбарлавал, эзэн хэн байх нь хамаагүй, компанийг компани шиг ажиллуулъя гэж байгаа юм. Төрийн өмчит компаниудын эзэн нь Монгол Улсын иргэд. Гэтэл бидний өмч болсон компаниудын тухай ямар ойлголт нийгэмд явдаг билээ. Бүгд мэднэ.

Төрийн тодотголтой компаниудын ихэнх нь өнөөдөр ашиггүй ажиллаж байна. Эдгээр компани явал ашигтай ажиллах вэ гэвэл компани шиг ажилласан цагт л гэж би хэлнэ. Компанийн гол зорилго эзэндээ ашиг авчрах шүү дээ. Яагаад төрийн компаниуд ашиггүй ажиллаж, хувийнхан ашигтай, сайн менежменттэй байна вэ. Хувийн хэвшлийнхэн улсын эдийн засгийн 80 хувийг үйлдвэрлэж байна. Тэд компани шиг л ажилласан учраас улсынхаа хөгжлийг нуруундаа үүрээд явж байна. Харин төрийн өмчийн компаниуд яагаад ашиггүй ажилладаг

вэ гэвэл компани мөртлөө компани шиг ажиллаж чадахгүй байгаад л учир байна. Монголын хувийн компаниуд амжилттай ажиллаж болдог юм байна гэсэн компанийн хөгжлийн сайн загварууд манайд олон бий.

Тиймээс бид төрийн өмчийн компаниудыг ийм зарчмаар ажиллуулах зорилготой бэлтгэл ажлуудыг хийж байна. Үүний тулд эхлээд хаана яваагаа тодорхойлох, тухайлбал, санхүүгийн тайлан тооцоо олон улсын шаардлагын дагуу байна уу, стандартад хэр нийцсэн байна гэдэгт анхаарал хандуулж байна. Дэлхийн хамгийн том аудитын компаниудын нэгээр аудит хийлгэж байна. Үүгээр манай компаниудын санхүүгийн тайлан тооцооны байдал, хөгжил, дутагдал гарч ирж, хаана яваагаа тодорхойлох болно. Компани шиг хөгжихийн төлөө бүгд зорьж байна. Манайд маш сайн боловсруулсан Компанийн тухай хууль мөрдөгддөг. Хууль, эрх зүйн сайн орчин бүрдсэн гэсэн үг. Орчиндоо зохицож ажиллах ёстой. Хандлагын өөрчлөлт гарна. Компани ашигтай ажиллаад ирэхээр ажилтнууд ч эрч хүчтэй, зорилготой урамтай ажиллах нөхцөл бүрдэх юм.

-Манай төрийн компаниуд олон улсын хэмжээний компаниар санхүүгийн аудитаа хийлгэх нь ямар ач холбогдолтой вэ?

-Санхүүгийн аудит хийлгэх нь маш чухал. Олон улсын зах зээлээс хөрөнгө босгоход хамгийн түрүүнд сүүлийн гурван жилий нолон улсын

санхүүгийн аудитын компаниар хийлгэсэн санхүүгийн аудитын тайлан заавал шаардлагатай болдог. Энэхүү тайлангаас олон улсын санхүү бүртгэлийн стандартын дагуу санхүүгийн менежментүүдийг хэр явуулдгийг хардаг. Нөгөө талаас бид мөнгө босгохгүйгээр компаниудын үйл ажиллагааг томруулах, шинэ менежмент нэвтрүүлэх боломжгүй.

Төрийн өмчийн компаниуд хууль, эрх зүйн хязгаарлагдмал орчинд үйл ажиллагаа явуулдаг. Асуудал шийдэх, томоохон үйл ажиллагаа явуулахад олон хууль, дүрэм, журмын хүрээнд ажиллах шаардлагатай учраас цаг хугацаа алдаж, зардал ч их гардаг юм байна. Зарим хууль, дүрэм нь хоорондоо уялдаа холбоогүй, зөрчилтэй. Тэр зөрчилтэй орчны дундуур хэрхэн яаж гарах вэ гэж ажилласаар байтал цаг хугацаа яваад өгдөг. Үүнийг өөрийн биеэр мэдэрч байна. Өнөөгийн бизнес бол цаг хугацаатай уралддаг, мөн маш их өрсөлдөөнт орчин шүү дээ. Гэтэл төрийн компаниуд нэг талаас өрсөлдөөнт орчинд, нөгөө талаас хязгаарлагдмал нөхцөлд ажиллаж байна. Бид энэ байдлыг хуулийн хүрээнд, өөрчлөх бэлтгэл ажлуудыг хийгээд явж байна.

Манай улс нэгэнт зах зээлийн эдийн засгийг сонгосон, үүгээр замнаад явж байгаа, тэрхүү зах зээл нь олон улсынхтай холбогдчихсон компани олон зуун жилд хөгжин дэвшсээр өнөөдөр хамгийн боловсронгуй

хэлбэртэй ороод явж байгаа тул бид түүнийг нь аваад цааш хөгжье. Энэ тохиолдолд зардал хэмнэнэ, цаг хугацааг хожно, ашигтай ажиллана. Компани бол эдийн засгийн гол суурь хөгжил юм. Хувийн хэвшлийнхэн эдийн засгийн 80 хувийг үйлдвэрлэнэ гэдгийн цаана компани л байгаа шүү дээ.

-УИХ төрийн өмчийн компаниудын засаглалыг шинэчлэх сайжруулах хуулийн төслийг удахгүй хэлэлцэхээр байгаа. Хэдийд хэлэлцэх вэ?

-Энэхүү процессийг эрчимжүүлэх дэмжих төрөөс эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох хүлээлт байна. УИХ-аар удахгүй хэлэлцэж батлах байх аа.

Олон шатанд шинэчлэл хийх хэрэгтэй болно. Хамгийн эхлээд системээ шинэчлэх, мөн эрх зүйн орчноо боловсронгуй болгох, улс төрийн нөлөөллөөс ангид байх гэх мэт.

-Сингапурын Темасекийн загвараар Монголын төрийн компаниудыг хөгжүүлэхээр зорьж байгаа юу?

-Темасек бол компани компани шиг ажилласнаар амжилт авчирдагийн үлгэр загвар. Өмнө нь Сингапурын төрийн компаниуд мөн л ашиггүй ажилладаг, систем нь буруу явж, эзэндээ ашгаа өгдөггүй, төр нь ийм компаниудаа өөр нүдээр хардаг байсан байгаа юм. Харин засаг нь төрийн оролцоотой компаниудаа компани шиг ажиллуулах зорилго тавьж, төрийн өмчит компаниудын статусыг нь авч хаяснаар өнөөгийн хөгжлийн түвшинд хүрч. Мэдээж нэг сар, нэг жилийн дотор хийдэг процесс биш. Сингапур орны туршлагаар гараад ирсэн энэ загварыг л Монголынхоо хөрсөнд буулгаж, хөгжүүлэхийг зорьж байгаа. Түүнээс Темасекийг тэр чигээр нь хуулна гэсэн үг биш. Ер нь дэлхийд алдартай энэхүү загварын гол нууц нь боловсон хүчин, хүндээ байна гэдэг. Тухайн салбар, тухайн ажилд дэлхийн хамгийн чадварлаг хүмүүсийг авч ажиллуулж хөрөнгийн менежмент хийлгэдэг учир Темасек ашигтай, амжилттай ажиллаж, эзэн нь болох Сингапурын иргэдэд ашиг авчирдаг байна.

-Таны удирддаг компаниудад

энэ жишгээр хамгийн сайн менежер, ажилтнуудыг ажиллуулах боломжгүй юу?

-Байхгүй. Гэхдээ хүсвэл болно. Үнэнийг хэлэхэд хязгаарлагдмал орчинд чадварлаг менежерүүдийг авчирч, хангалттай цалин, урамшуулал болон компанийг ашигтай ажиллуулах хэмжээний бүрэн эрхийг нь өгөөд явахад боломж өнөөдөр хомс.

-Төрийн компаниудын удирдлагуудыг байсхийгээд л өөрчилдөг. Захирлуудыг солилоо гээд том өөрчлөлт гардаггүй. Таны ярьснаар засаглалыг сайжруулж, системээр нь өөрчлөхгүй бол хэчнээн дарга солиод дорвитой үр дүн харагдахгүй байна шүү дээ?

-Өнөөдөр төрийн өмчийн компаниудын захирлыг улстөрчид томилдог. Тухайлбал, "Эрдэнэс Монгол" компанийн гүйцэтгэх захирлыг Засгийн газраас томилдог. Үүнийг л өөрчилж шинэчлэе гэж байгаа. Уг нь компанийн эзэн ТУЗ-өөр дамжуулан үйл ажиллагааг удирддаг байх ёстой. Компанийн тухай хуулиар аливаа компанийн гүйцэтгэх захирал ТУЗ-тэй гэрээ хийж, хариуцлагаа ч хүлээж, компанийг ашигтай ажиллуулахын төлөө ажиллах ёстой. Манай хувийн компаниуд сүүлийн 25 жил хөгжлийн олон шат дамжлагаар яваад ирлээ. Тэд ийм л зарчмаар удирдлагаа сонгож, гүйцэтгэх захирал ТУЗ-ийн өмнө ажлаа тайлагнаж ирсэн. Төрийн компаниудын удирдлагуудыг ТУЗ томилж, ажлын хариуцлага тооцдог системийг л нэвтрүүлэхээр бид ажиллаж байна.

-Уг нь бол таныг Ерөнхий сайд биш ТУЗ дуудаж уулзах ёстой. Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн, сайд дарга нар таныг дуудах ёсгүй ийм л систем бол Темасек. Манайх болохоор эсрэгээр байна.

-Тиймээ.

-Таны хувьд дэлхийн стандартыг Монголд мөрдөж байж улс хөгжих тухай их ярьдаг хүн.

-Яагаад олон улсын стандарт шаардлагатай байна вэ? Өнөөдөр зөвхөн Монгол дотроо ажилладаг явдал өнгөрсөн байна. Манай эдийн засгийн өсөлт дэлхий дээр юу болж буйтай уялдчихсан байна шүү дээ.

Тухайлбал, дэлхийн эдийн засаг яаж байна, АНУ-ын Төвбанк ямар шийдвэр гаргав, Хятадын үйлдвэрлэл өсөв үү, буурав уу гэдэг нь бидэнд маш их хамаатай болж. Даяаршсан эдийн засгийн орчинд ажиллаж, амьдарч буй хүмүүс гэдгээ бид сайтар ойлгох хэрэгтэй. Ийм нөхцөлд зөвхөн дотоодын, өөрсдийн мэддэг стандартаа мөрдөөд яваад байж болохгүй биз дээ. Бусад орон олон улсын нэгдсэн ойлголт бүхий стандарт дүрмээр тоглож, дэлхийн зах зээлээс мөнгө босгож, үйл ажиллагаагаа тэлээд хөгжөөд байдаг, гэтэл бид дотроо л өөрсдийн дүрмээр яваад байвал яаж хөгжих вэ.

Тиймээс олон улсын стандартыг нэвтрүүлж мөрдөх шаардлагатай. Энэхүү стандартыг мөн дахин зохиох хэрэггүй. Хувийн компаниудын хувьд энэ дүрмийг аль дээрээс ойлгож ухаараад санхүүгийн тайлан балансаа олон улсын стандартын компаниудаар хийлгэж ирсэн. Олон улсын зах зээлээс хөрөнгө босгох болоход энэхүү тайлан баланс бэлэн байдаг. Үүнийг л төрийн өмчтэй компаниудад нэвтрүүлэхийг зорьж байгаа юм. Дэлхийн стандарт нь тийм хэцүү зүйл биш. Түүнийг авч хэрэглэхийн тулд бид ажлын арга барил, ойлголт, үйл ажиллагаагаа сайжруулах, шинэчлэл хийх ёстой.

-Сүүлийн үед төр ачааллаа хувийн хэвшил рүү шилжүүлэх бус харин төрийн өмчтэй компаниудын тоог нэмээд байгаа. Та энэ шийдвэрийг хэрхэн харж байна вэ?

-Буруу. Эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байгаа гол зүйлүүдийн нэг нь төр, засгаас бизнес рүү хэт орж байгаа явдал гэдэг нь ойлгомжтой. Өнөөдөр бизнес хийхэд хууль, дүрэм журам болоод өөр бусад зүйлс ойлгомжгүй, тодорхойгүй байх юм бол бизнесмэнүүд бизнесээ урт хугацаанд төлөвлөж чадахгүй. Урт хугацаанд бизнесээ төлөвлөх нь нь бизнесийн өрсөлдөх чадварын гол үзүүлэлт. Би 5,10 жилийн дараа компани тийм хэмжээнд хүргэнэ гээд орлого, зарлагаа тооцно. Гэтэл орчин тогтворгүй өөрчлөгдөөд байвал урт хугацааны төлөвлөлт байхгүй болно. Өрсөлдөх чадвараар дээгүүр ордог орнуудад хууль, журам нь тогтчихсон, огт өөрчлөгддөггүйгээрээ хурдацтай

хөгжлийг бий болгосон байдаг. Тус орнуудын. Энэ нь хувийн ч, төрийн ч компаниудад ялгаагүй мөрдөгддөг. Холыг харж бизнес хийх нь улсын хөгжилд тустай. Ойрын зайны тоглолт байнга хийхээр маргааш, дараа жил юу болохыг мэдэхгүй. Мөн компани чадавхжихгүй, хөгжихгүй.

–“Эрдэнэс Монгол” компанийн ажил өнөөдөр ямар явж байна вэ?

–Бидний гол зорилго үйл ажиллагаагаа олон улсын компанийн санхүүгийн менежментийн дагуу явуулахаар ажиллаж байна. Манай эдийн засагт том төслүүдийн үүрэг их учраас тэдгээр төслийг явуулах нь чухал байна. Оюутолгойн гүний уурхайн төсөл урагшилчихлаа. Багануур, Шивээ-Овоо компаниудын олон улсын зах зээлээс хөрөнгө

босгох ажлыг удирдаад явж байна. Тавантолгой төслийг яаж ашигтай ажиллуулах вэ гэсэн хувилбар дээр ажиллаж байна. Олон ажил байгаа ч холдинг компанийнхаа хувьд стратегия баримталж, зангидан гол ажлууд дээрээ төлөвлөгөөтэйгээр төвлөрч ажиллахыг хичээж байна. Бид том өөрчлөлтийн эхэнд байна гэж хэлж болно. ■

ХУУЛЬ



Төрийн өмчийг дахин хуваарилах нь

Ц.Элбэгсайхан

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” гэж заажээ. Гэвч өнгөрсөн хорин жилийн турш үндсэн хуулийнхаа заалтыг ч бүрэн гүйцэт мөрдөж чадалгүй явж ирсэн байх юм. Аймаг бүр, сум бүр нь, дүүргүүд нь хүртэл толгой толгойгоо мэдэх эрх дархыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиараа бий болгожээ. Хуулийн нэр томъёонд буй “орон нутгийн өмч гэдэг” ойлголтоос энэ зөрчил үүдэлтэй аж. Тодорхой хэлбэл, аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тус бүртээ өмчтэй, түүнийгээ хэнээс ч асуулгүйгээр захиран зарцуулж, түрээслэж, бэлэглэх, барьцаалах эрхтэй.

Өнгөрсөн есдүгээр сарын 28-нд Засгийн газраас “Төрийн өмчийн тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн. Уг хуулийн төсөлд дээрх нөхцөл байдлыг болон өнөөгийн хуулиар зохицуулж чадахгүй байгаа бусад алдаа дутагдлыг залруулах зүйл заалт, зохицуулалт тусгаж өгчээ. Ингэснээр улсын өмч нэгдмэл болж, захиран зарцуулах, ашиглах эрх бүхий

этгээд нь ойлгомжтой, хяналттай болно гэж Засгийн газар үзэж байгаа аж.

Төрийн байгууламжийн нэгдмэл тогтолцоотой улсын хувьд төрийн өмчийг Засгийн газар өмчилж, УИХ-аас баталсан хуулийн дагуу захиран зарцуулдаг байх, аймаг, нийслэл төрийн өмчийг зөвхөн эзэмших эрхтэй байх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, одоогийн орон нутгийн өмчийг төрийн өмч болгон бүртгэнэ гэсэн үг. Төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, хувьчлах эрх зөвхөн УИХ-д хадгалагдана. УИХ-ын зөвшөөрснөөр Засгийн газар, Засгийн газрын зөвшөөрснөөр аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал өөрчлөн байгуулах, хувьчлах эрхтэй байхаар төсөлд тусгажээ. Цаашлаад Засгийн газар энэ асуудлаар нарийвчилсан журам гаргах үүрэг хүлээж байгаа юм.

Хуулийн төсөлд орж байгаа чухал зохицуулалтын нэг нь төрийн өмчит компанийг байгуулах нөхцөл, шаардлагыг тогтоож өгсөн явдал. Одоогийн хуульд энэ талаар ямар

нэгэн зохицуулалт байхгүй. 20 жил явсны эцэст ямар нэгэн зохицуулалт хийх санаачлага гарч байгаа нь дэвшил. ТӨК байгуулахад үндэслэл шаардлага тавиад зогсохгүй байгуулсны дараагаар үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлэл нь олон нийтэд ил тод байх шаардлагыг давхар тавьж байгаа юм. Шилэн дансны тухай хууль бусад хууль тогтоомжоор ил тод, нээлттэй байхаар зааснаас гадна аудитын дүгнэлт бүхий санхүүгийн тайланг улирал тутам гаргаж байх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагад олгосон урамшуулал, шагналыг ил тод мэдээлж байх шаардлага тавьж байгаа. Компанийн үйл ажиллагааны талаар нэгдсэн мэдээллийг жилд хоёр удаа гаргаж, нийтэд мэдээлэх. Мэдээлэлд санхүүгийн болон санхүүгийн бус нийтэд зайлшгүй хүргэх мэдээллийг агуулсан байхыг онцгойлон тусгажээ. Энэ нь төрийн өмчит компанийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоог дэлхийн бусад оронд хэрэглэдэг нийтлэг жишигт нийцүүлж байгаа хэрэг.

Өнөөдөр төрийн өмчит компаниудын засаглал сэтгэл зовоосон асуудлуудын нэг юм. Шахааны томилгоо, шахааны бизнес гэдэг ойлголт үүнийг даган бий болсон. Компанийн засаглалын асуудлыг хуульчилж, журамлаагүй нь дээрх асуудлууд урган гарах үндэс болсон гэж үзжээ. Одоо мөрдөгдөж байгаа хуулиар төрийн төлөөлөл болж тухайн компанийг удирдаж байгаа этгээд дураараа шийдвэр гаргах бололцоо нээлттэй. Түүнд тавьж буй хяналт, хариуцлага тооцох зарчим хангалттай бус гэж Компанийн засаглалын хөгжлийн төвийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Байлийхүү үзэж байгаа юм. Хуулийн төсөлд энэ асуудлыг хэрхэн зохицуулахаар тусгасан бэ гэвэл “Төрийн аливаа байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн

оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаанд оролцохыг хориглоно”, “төлөөлөн удирдах зөвлөлд өөрийг нь төлөөлөх гишүүдийн нэрийг компанийн нэр дэвшүүлэх хороонд хүргүүлэн томилуулах” зэрэг хязгаар тогтоож, тогтолцоо бүрдүүлж байна. Энд дурдагдаж буй “нэр дэвшүүлэх хороо” ихээхэн чухал үүрэгтэй бөгөөд төрийн төлөөлөгчийг сонгох гол ажлыг нугалах юм. Өөрөөр хэлбэл, томилгоог дээрээс биш, доороос хийдэг тогтолцоо бий болгох аж. Нөгөөтэйгүүр тэдэнд хариуцлага тооцож байгаа байдал нь сул юм. Одоогийн нөхцөл байдлаар хууль зөрчсөн албан тушаалтныг дээд тал нь 60 мянган төгрөгөөр торгоно. Жишээ нь, “төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын

зөвшөөрөлгүйгээр хандивласан, бэлэглэсэн, барьцаалсан, зээлдүүлсэн, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулсан бол гэм буруутай албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх” шийтгэл ноогдуулна. Харин “Төрийн өмчийн тухай хууль” батлагдсанаар буруутай албан тушаалтан хохирлыг нөхөн төлөхөөс гадна ажлаас халагдах ёстойг хатуу хуульчилжээ.

Тэгвэл төрийг хэн төлөөлөх вэ... “Төрийг төлөөлөн хувьцаа эзэмших этгээд нь Засгийн газрын аль нэг, эсхүл хэд хэдэн байгууллага байж болно”. Мөн “шаардлагатай гэж үзвэл хувьцаа эзэмшигчээр хувийн өмчийн хуулийн этгээд болон төрийн бус байгууллагыг томилж болно” гэсэн заалтууд хуулийн төсөлд тусгагдсан байх юм. ■

МЭРГЭЖИЛТНИЙ ҮГ

Б.Байлийхүү: Төрд аж ахуйн нэгж байгуулах цөөхөн тохиолдол бий

Ц.Элбэгсайхан



Төрийн өмчийн тухай хуулийн төслийн талаар дэлгэрэнгүй тайлбар авахаар Төрийн өмчийн хорооны зөвлөх, Компанийн сайн засаглалын төвийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Байлийхүүтэй ярилцлаа.

-Хувийн хэвшил төрийг төлөөлөөд ирэхээр төрөөр бизнес хийх нь гэж олон хүн хардах байх. Хардах нь ч зөв болов уу?

-Үүнээс сэргийлэхийн тулд төрийн төлөөллийг томилох үе шатыг дээрээс биш, доороосоо хийдэг болгож байгаа.

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлж томилно. Дээд албан тушаалтан зөвхөн санал ирүүлэх эрхтэй. Санал ирүүлэх процедурыг нь бас тодорхой, нэр дэвших хүн нь хэн байж болох вэ гэдгийг бас зааж өгсөн. Үүнийг ёсоор

нь мөрдөх юм бол одоо ярьдагчлан шахааны хүн орох асуудал харьцангуй бага болох ёстой.

Мөн удирдлагын авч байгаа цалин урамшуулал, бусад санхүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй болгосноор нийтийн хяналтанд оруулж, нийгмээрээ бурууг жигших болно. Үүнийг өнгөрсөн туршлага, олон улсын нийтлэг жишиг харуулж байна. Компанийн засаглал үүсч хөгжөөд 400 гаруй жил болжээ. Энэ хугацаанд юу сайн, юу муу үр дагаварт хүргэдэг вэ гэдэг нь олон улсын туршлагаар тодорхой болсон. Тиймээс тэр сайн туршлагыг авах нь зүйтэй.

-Хуулийн төслийн гол агуулга, үндэслэл нь юу вэ?

-Гол өөрчлөлт нь төрийн өмчийн алийг нь Засгийн газар, алийг нь орон нутаг захиран зарцуулах вэ гэдгийг зааглаж өгсөн. Орон нутгийн өмчийг булаагаад авчихаж байгаа юм шиг харагдаж магадгүй. Гэхдээ тийм биш. Одоогийн хуулинд байгаа эрх бүгд хэвээрээ. Эзэн нь төр боловч эзэмших эрх нь орон нутагт үлдэнэ. Гагцхүү төрийн өмч эзэмшигч нь улсын нэгдсэн бодлоготой уялдаагүй, ямар нэгэн хууль бус шийдвэр гаргахад УИХ-аас хариуцлага тооцож шийдвэрийг хүчингүй болгох эрх нээгдэж байгаа. Одоо байгаа хуулиар орон нутаг өөрийн өмчийг яаж захиран зарцуулах нь дурын асуудал байгаа юм.

Хоёрдугаарт, төрийн байгууллагууд өөрийнхөө аж ахуйн үйл ажиллагааг өөрөө хийгээд байна. Төрийн байгууллага болгон өөрийн санхүүтэй, өөртөө аж ахуйтай. Үндсэн ажлаасаа гадна сандал ширээ засах, байшин барилга будах бүх ажлыг хийж байна. Үүнийг зааглаж, зохицуулж өгсөн. Төр татварын мөнгөөр шинэ байшин барьж байна.

Олон жил ингэж явсны үр дүнд төрийн байгууллага болгон өөрийн байртай болжээ. Зарим нь ашиглагдахгүй талбайгаа түрээслүүлж байна. Уг нь төр хувийн өмчийн байшин барилгыг түрээслэж ашиглах нь зүйд нийцнэ. Үүнийг зохицуулж өгсөн. Сайд, дарга нар бодлого боловсруулах үндсэн ажлаа л хийхээс биш, байшин сандал ширээтэй байна

уу, будах уу, үгүй юү гэдгийг анхаарах шаардлагагүй болж байгаа.

-Сүүлийн үед орон нутгийн удирдлагуудын эрх мэдлийг нэмэгдүүлэе, дотооддоо асуудлаа шийддэг болгоё гэсэн санал гарах болсон. Гэтэл хууль батлагдсанаар эсрэгээрээ эрх мэдлийг нь хумиж байгаа юм шиг санагдах юм?

-Нэгдсэн бүртгэлтэй болж, хяналт хариуцлагын механизм бий болгож байгаагаас биш Засаг дарга нарын эрх мэдлийг хасч байгаа хэрэг биш. Эзэмшигчийн захиран зарцуулах эрх, үүргийг тодорхой тусгасан байгаа. Холбооны улсад бол холбооны өмч гэж байдаг. Манай улс холбооны улс биш учраас төрийн өмч нэгдмэл байх нь зөв.



Сайд, дарга нар бодлого боловсруулах үндсэн ажлаа л хийхээс биш, байшин сандал ширээтэй байна уу, будах уу, үгүй юү гэдгийг анхаарах шаардлагагүй болж байгаа.



Хүмүүс ч орон нутгийн өмчийг төрийн өмчийн нэг хэсэг гэж ойлгодог. Гэтэл одоогийн хуулиар тийм биш. Орон нутагт гаргасан шийдвэр Монгол Улсын төрийн бодлоготой нийцэхгүй, харшиж байхад түүнийг хүчингүй болгох эрх УИХ-д байхгүй байна.

-Төр өмчийн харилцаанд хэрхэн оролцох ёстой юм. Төрийн өмч, хувийн өмч хэрхэн орших нь зөв бэ?

-Хувийн өмч, төрийн өмч яг адил түвшинд байх ёстой. Хуулиар хамгаалагдсан, нэг нь нөгөөгөөсөө дээр, доор гэсэн ойлголт байхгүй. Анх 1991 онд Улсын бага хурлын шийдвэрээр ингэж зохицуулж өгсний дагуу одоог хүртэл баримталж байгаа.

Тиймээс төр өмчийг хэлбэрээс нь хамаарахгүй хамгаалах үүрэгтэй. Хувийн өмч бий болохыг бодлогоор дэмжиж түүнд халдахыг хуулиар хамгаалж байх ёстой.

-Төрийн өмчит компани байгуулахад тодорхой шаардлага тавьж өгсөн. Тэгэхдээ бүр хязгаарлагдмал хариуцлагатай эсвэл хувьцаат компани байх ёстой гэж зааж өгчээ. Үүний ач холбогдол юу вэ?

-Чөлөөтэй байснаараа хэтэрхий олон аж ахуйн нэгж байгуулж байна. Гэтэл төрд аж ахуйн нэгж байгуулах цөөхөн хэдэн тохиолдол байгаа юм. Ер нь бол төр аж ахуйн ажилд оролцох ёсгүй.

Зөвхөн хувийнхны хийж чадахгүй байгаа орон зайг нөхөж ажиллах ёстой. Хоёр хүн хоорондох харилцаагаа зохицуулж чадахгүй үедээ төрөөс тусламж авдаг. Үүний төлөө тэд татвар төлдөг. Тэр төлсөн татвараар нь төр зохицуулалт хийх үүрэгтэй. Түүнээс биш, татвар төлөгчдийн мөнгөөр "талхны цех" байгуулж хувийн хэвшилтэй өрсөлдөөд байж болохгүй. Гарцаагүй нийгэмд дутагдаж байгаа нөхцөлд л зөвшөөрнө.

-Төрийн өмчийн хувьчлал бүрэн дуусаагүй байна. Энэ асуудлыг хуулийн төсөлд хэрхэн хөндсөн бол.

-Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй. Хэрэгцээ шаардлага нь байх юм бол хувьчилна ч, худалдаж ч авна. Дэлхийн аль ч оронд төрийн өмч бий. 2008 онд АНУ-ын Засгийн газар олон банкныг худалдан авч, төрийн өмч болгосон. Дэлхийн хамгийн том даатгалын компанийн 70-80 хувийг АНУ-ын засгийн газар шууд эзэмшиж байна. Хэрэв тэр даатгалын компани дампуурах юм бол маш олон иргэн хохирох учраас Засгийн газарт тэр хувьцааг худалдаж авах шаардлага, нөхцөл бий болсон гэсэн үг.

Төрийн өмчийг бий болох үедээ бий болгож, хувьчлах үед нь хувьчилж байх ёстой. Энэ бол нийгмийн харилцаа. Зарим хүн төр өмчгүй болох ёстой гэж ярьдаг. Тийм биш. Монгол Улс одоо энэ чиглэл рүү орох гэж байна. ■

Тус сэтгүүлд байршуулсан танай компанийн сурталчилгаа лидерүүдийн ажлын ширээн дээр бүтэн жилийн туршид байх болно.

“Манай уншигчид ирээдүйн чиг хандлагын талаар чиг баримжаа, ойлголттой болох сонирхолтой байдаг, тиймээс тэд жил бүр бидний таамаглалыг тунгаан бодохын тулд эргэн ирдэг.”

Даниел Франклин
“The Economist” сэтгүүлийн эрхлэгч

Манай сэтгүүл үүсгэн байгуулагдсаны тав дахь жилийнхээ ойн үеэр Монгол дахь албан ёсны онцгой зөвшөөрөлтэйгээр The Economist сэтгүүлийн “The World in 2016” жилийн дугаарыг монгол хэлээр гаргах гэж байгаадаа баяртай байна”

Д.Бэхбаяр
“Mongolian Economy” сэтгүүлийн Эрхлэгч

Энэхүү дугаарт "The World in 2016" дугаарын дэлхийн эдийн засаг, бизнесийн хөгжлийг урьдчилан зурагласан нийтлэлүүд хэвлэгдэхээс гадна “Mongolian Economy” сэтгүүлийн зүгээс бэлтгэсэн Монгол Улсын ирэх оны эдийн засаг, улс төр, санхүү, бизнесийн салбарын хөгжлийн таамаглалыг харуулсан судалгаа–анализ бүхий нийтлэлүүд орох юм. Нийтлэлүүдийг тухайн салбарыг дүгнэж, таамаглал дэвшүүлж чаддаг нэр нөлөө бүхий хүмүүс тус сэтгүүлд зориулж бичих юм.

Утас : 94092904, 88006228, 70115476, 70115477
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn

MONGOLIAN
ECONOMY

ТУРШЛАГА



Темасек ба төрийн өмчийн шинэ эрин

Ц.Буян

Темасек гэдэг нэр дэлхий ертөнцөд танигдсан нь 700 гаруй жилийн түүхтэй. Шри Три Буана гэх түүхэн хүн 1299 онд Темасекийн хаант улсыг байгуулжээ. 10 мянга орчим хүн амтай жижиг улсыг бид өнөөдөр Сингапур хэмээх 5.5 сая хүн амтай метро хот гэдгээр нь илүү мэднэ. Стратегийн ач холбогдол бүхий байршлаасаа болоод хаант улс харийн эзлэн түрэмгийлэлд өртөж 100 хүрэхгүй жил оршин тогтножээ. Далайн орнуудын худалдааны төв цэг болж байсны хувьд нэлээд хөгжингүй хот байсан нь хожим хийсэн архиологийн судалгаагаар тодорхой болсон юм. Сингапурын төрийн өмчит корпораци Темасекийн нэрний үүсэл гарвал ийм түүхтэй.

700 жилийн дараа Темасек эргэн сэргэн мандаж байна. Сенгапурын компанийн тухай хуулиар Темасек нь арилжааны хөрөнгө оруулалтын Компани. Төрийг төлөөлөн өмчийн харилцаанд оролцох бүрэн эрхтэй. Хөрөнгө оруулах, хувьчлах, худалдан авах гээд бизнесийн шийдвэр гаргах эрхтэй. Эзэмшиж буй хувьцааны нийт

үнэлгээ нь 194 тэрбум ам.доллар /2015 оны гуравдугаар сарын 31-ний байдлаар/. Санхүүгийн үйлчилгээ, харилцаа холбоо, мэдээллийн технологи, тээвэр аж үйлдвэр, шинжлэх ухаан, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, эрчим хүч, нөөц ашиглалт гээд бүхий л салбарт хөрөнгө оруулалт хийжээ. 1974 онд байгуулагдсанаасаа хойш эзэмшж буй хувьцаанаасаа жил бүр дунджаар 16 хувийн өгөөж хүртэж иржээ. Тус корпорацийн зээлжих зэрэглэлийг Moody's "Aaa", Standart & Poor's "AAA" гэж үнэлдэг. Тэд анх 2004 онд үнэлгээ тогтоолгосноос хойш өнөөдрийг хүртэл энэ үзүүлэлтээ хадгалж байгаа юм.

Энэ бүхэн төрийн өмчит компанийн тухай дэлхий нийтийн уламжлалт ойлголтыг 180 хэм өөрчилсөн билээ. Ерөнхийдөө түүхэн талаас авч үзвэл бизнест хоёр төрлийн тоглогч оролцож ирсэн. Нэгийг нь хувийн өмчийн компани гэдэг бол нөгөө нь төрийн өмчит. Төрийн өмчит компани нь ЗХУ, Хятадаас эхлэлтэй. Бүх удирдлагыг төр гартаа атгаж байдаг учир зах

зээлийг боогдуулж, өрсөлдөөн үүсдэггүй учир хөгждөггүй, дотроосоо ялзарч унадаг гэх мэтчилэнгээр барууныхан шүүмжилдэг. Зөвлөлт систем задран унаснаас хойш социализмаас капитализм руу шилжсэн орнуудын төрийн өмчит олон компани хувьд шилжсэн. Гэхдээ бүгдийг хувьчлаагүй. 1990-ээд онд хувьчлалын давалгаанаар төрийн өмчит компаниудын тоо цөөрсөн ч Засгийн газрууд стратегийн ач холбогдол бүхий салбараа авч үлдсэн. Тухайлбал, Саудын Араб "Aramco", Мексик "Pemex", Итали "ENI", Норвеги "Statoil", Хятад "Sinopec", Бразил "Petrobras", ОХУ "Gazprom" гэх мэтээр нэрлэж болно. Өнгөрсөн хугацаанд тэдгээр ТӨК-иудын бүтэц зохион байгуулалт нь шинэчлэгдэж, зах зээл дээр тоглох аргаа өөрчилжээ. Бирж дээр хувьцаагаа борлуулж, ТУЗ-тэй болж, гаднаас чадварлаг удирдлагуудыг авчирч томилдог болж. Томууд нь засаглал, үйл ажиллагааны хувьд хувийн өмчит корпорациудтай эн зэрэгцэж, тэдэнтэй өрсөлдөхүйц

түвшинд хүрээд байна.

Гэтэл хувийн өмчит компаниуд ямар хүчирхэг өрсөлдөгчтэй нүүр тулж буйгаа ухаараагүй байгааг Харвард Бизнесийн сургуулийн эрдэмтэн Алдо Мусаччио хэлж буй. Тэрбээр Бразилын Боловсрол, судалгааны хүрээлэнгийн судлаач Сержио Лаззаринитай хамтарч “Бизнес дэх аугаа хүчин зүйл: Төрийн капитализмын хувилбарууд ба түүний эдийн засаг дахь нөлөө” судалгааны бүтээл туурвисан юм. Түүний үзэж буйгаар төрийн өмчит компаниуд зах зээлд ихээхэн нөлөөтэй бөгөөд хүссэнээрээ “тоглож” чадах хүч юм. Ялангуяа хөгжингүй болон хөгжиж буй зах зээл дээрх Засгийн газрын өмчид харьяалагдах компани дэлхий дээрх нийт төрийн өмчит компаниудын дотор том орон зай эзэлж буй. Муугаар хэлбэл, хувийн хэвшлийнхэн зах зээлээ алдаж буй аж.

Уламжлалт ойлголтоор бол хувийн өмчийн компани болон төрийн өмчит компани нь “хар ба цагаан” гэсэн үг. Харин Алдо Мусаччио хэлэхдээ “АНУ эсвэл зөвлөлтөд байна уу гэдэг тийм ч сонин биш. Бодит ертөнцөд “саарал”-ын маш олон хувилбар бий” гэжээ. Төрийн өмчит компаниуд ахиу орлого олж, амжилттай яваа улсуудын жишээ цөөнгүй. Казахстаны “Самрук Казына”, Малайзын “Казанах Насионал” компанийг дурдаж болно. “Темасек

Холдинг”-ийг энд голчлон авч үзэж буй нь тус компани компанийн засаглалын шинжлэх ухаанд “Темасек загвар” гэгчийг бий болгосон юм. Уг загварын онцлог нь компанийн менежментэд хутгалдахгүй боловч эзний байр сууриа алдахгүй байх боломжийг төрд олгосон явдал.

Компанийн ТУЗ-ийн гишүүнийг шинээр томилох, татан буулгах эрх нь зөвхөн Сингапур улсын Ерөнхийлөгчид л байдаг. ТУЗ дахь 10 гишүүн нь санхүү, хөрөнгө оруулалт, бизнесийн удирдлагатай холбоотой салбаруудад хүлээн зөвшөөрөгдсөн, бие даасан хараат бус гишүүд байдгаараа онцлог. Жишээ нь, ТУЗ-ийн бүтцэд Төв банкны захирал, Ерөнхий сайд, Сангийн сайд зэрэг алба хашиж байсан лидерүүд 30 орчим хувийг, дэлхийн зах зээл дээр ноёрдог үндэсний топ компаниудын менежерүүд мөн адил хувийг эзэлдэг. Үлдсэнийг нь судалгааны хүрээлэнгийн шинжээч, их сургуулийн эрдэмтэн багш, зах зээл судлаач, банк санхүүгийн байгууллагад ажиллаж буй хүмүүс бүрдүүлдэг байна.

Гэхдээ ТУЗ Темасекийн, Темасек хараат компаниудынхаа өдөр тутмын ажилд оролцохоос зайлсхийж, зах зээлийн мэргэшсэн менежерүүдийг чөлөөтэй авч ажиллуулдаг. Темасекийн нөөц хөрөнгийг хамгаалах асуудлаас бусад тохиолдолд Сингапурын

Ерөнхийлөгч болон Засгийн газар үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэрт нөлөөлөх, оролцохыг хатуу хориглосон. Компани орлогоо бие даан захиран зарцуулах бүрэн эрхтэй. Үйл ажиллагаа нь зөвхөн ашигтай төсөлд хөрөнгө оруулахад чиглэдэг гэх мэт “хар”, “цагааны” давуу чанаруудыг нэгтгэжээ.

Компанийн орлого охин болон хараат компаниудын ногдол ашгаас бүрддэг байна. “Темасек идэвхтэй хөрөнгө оруулагч болж чадсан. Гэхдээ хамгийн идэвхтэй нь биш” гэж тус компанийн хэвлэл мэдээлэл хариуцсан захирал Стэфэн Форшав нэгэнтээ хэлжээ. Амжилт ололтын зэрэгцээ алдаа дутагдлыг ч ярих нь зөв. Шүүмжлэгчдийн зүгээс Темасекийн хувьцааг нь эзэмшдэг компаниудаас БНХАУ-ын эдийн засагт бодитой дэмжлэг үзүүлдэг компани нэг, хоёрхноор тоологдож байгаа нь хангалтгүй гэж үздэг. Одоогоор “Singapore Airlines”, “DBS bank” л олон улсад брэнд болж танигдсан нь юм. Гэтэл бүс нутагт “Самсун”, “LG” гэх мэт хувийн өмчийн корпорациуд улсынхаа эдийн засгийг хүчтэй дэмжиж буй. Гэхдээ л Хятадын бусад төрийн өмчит компанийн адил алдагдал хүлээж, өрөнд баригдаагүй. Эсрэгээрээ маш өндөр ашигтай ажиллаж байгаа билээ. ■

Редакцид захиалбал хүргэлт үнэгүй


Харилцах утас 94092904, 88006228,
70115476, 70115477

marketing@mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn



Орон нутгийн гэрээ олон талын тэнцвэрийг олох учиртай

И.Жаргал



Германы олон улсын хамтын ажиллагаа /GIZ/ байгууллагын Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрөөс компанийн нийгмийн хариуцлагын үндэсний форумыг тав дахь жилээ энэ сарын 11-нд хийлээ. Тус форумын энэ удаагийн хурлын онцлог, голлон хэлэлцсэн асуудлуудын талаар тус хөтөлбөрийн дэд захирал О.Батболдтой ярилцлаа.

-Компанийн нийгмийн хариуцлагыг таван жилийн өмнөхтэй харьцуулахад ямар үр дүн, өөрчлөлт гарч байна вэ?

-Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөр тав дахь жилдээ бусад монгол байгууллагатай хамтраад компанийн нийгмийн хариуцлага /КНХ/-ын форумыг зохион байгууллаа. Үндэсний форумыг таван жилийн өмнө Ерөнхийлөгчийн ивээл дор “Өрсөлдөх чадвар ба нийгмийн хариуцлага” гэсэн сэдэвтэйгээр эхэлж байсан. Тухайн үед хэлэлцэх асуудлын хувьд КНХ гэж

юу вэ, хэрхэн хэрэгжүүлдэг талаар олон улсын туршлагаас судалж, танилцах аяллыг зохион байгуулж байлаа. КНХ бол манай форумаас өмнө байсан сэдэв. Хэлэлцдэг, яригддаг, хэрэгжүүлдэг компаниуд ч байсан. Таван жилийн дараа харахад бол нэгдүгээрт, форумын хэлэлцэх сэдвүүдийн хувьд нэлээд нарийсч ирсэн.

Мөн монголчууд маань өөрсдөө энэ чиглэлээр мэргэшиж эхэлсэн байна. Гаднынхан ирээд туршлагаа хуваалцахад энэ асуудлын тухайд манайд ийм байна, тийм байна гээд жишээлээд ярих туршлагатай болсон нь энэ удаагийн форумаас харагдлаа. Нөгөө талаасаа таван жилийн өмнөхтэй харьцуулахад өнөөдөр эдийн засаг ямар байгаа билээ, ялангуяа компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх асуудал илүү тэдэнд хамаатай юм шиг ойлгодог уул уурхайн салбар ямар байгаа билээ. Энэ дээр компаниуд нийгмийн хариуцлагыг хэрхэн зардал багатай хийх вэ, хэрхэн хэрэгжүүлэх вэ, эндээс яаж үр ашиг олох вэ гэдэг ч юм уу сэдэв

рүүгээ нэлээд нарийсч орж байгаа нь таван жилийн өмнөхөөсөө ялгаатай байна. Мөн форумын нээлтийн үеэр Р. Амаржаргал гишүүн ч хэлсэн. Ерөнхийдөө КНХ гэдэг дээр ойлголтын зөрүү байсаар байна. Бүх талууд нийгмийн хариуцлага гэдэг ойлголтын үндсэн ухагдахуун бол компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шингэсэн, бусад талуудын эрх ашиг болон хүний эрх зэрэг асуудлыг хамарсан цогц үйл ажиллагаа гэдгийг ойлгох ойлголт дутуу дулимаг хэвээр байна гэж онцлон тэмдэглэсэн.

-Энэ удаагийн хэлэлцэх сэдвүүдийн хувьд ямар онцлогтой байсан бэ?

-Нийгмийн хариуцлагын сэдвүүдийг нэлээд нарийвчилж хэлэлцсэн гэж дээр хэлсэн. Тухайлбал, энэ жилийн үндсэн сэдэв орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байлаа. Дараагийн сэдэв хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй. Энэ бол нийгэмд чиглэсэн чухал асуудал. Осол гэмтэл гэдэг нэг хүнээр зогсохгүй гэр бүл цаашлаад нийгэм рүүгээ орохоор

тэтгэвэр тэтгэмжийн асуудал яригддаг. Манайх шиг ажиллах хүчний нөөц багатай орны хувьд энэ бол таагүй зүйл. Тиймээс энэ нь компаниуд зайлшгүй бодож хэрэгжүүлж байх ёстой сэдэв байдаг. Энэ тал дээр уул уурхайн томоохон компаниуд нэлээд үлгэр жишээ ажилладаг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сэдвийн хувьд энэ жил хууль эрх зүй, Ослыг бүртгэх дүрэм журам гээд нэлээд зүйл шинэчлэгдсэн. Энэ талаар мэдээлэл өглөө.

Мөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн өвчлөлийг хэрхэн багасгаж болох талаар Герман улсын туршлагыг хуваалцлаа. Гурав дахь үндсэн сэдэв Бизнесийн ёс зүй, шударга бизнесийн тухай байсан. Энэ талаар нийгмийн хариуцлагын форумын зүгээс “Транспэрэнси интернэшнл Монгол” байгууллагатай хамтраад олон улсын туршлага, бизнесийг авлигаас ангид байлгаж болох ямар олон улсын стандарт, зөвлөмжүүд байдаг. Мөн Монголд нөхцөл байдал ямар байгаа гэдэг сэдвээр дугуй ширээний ярилцлага зохион байгууллаа. Сэдвүүдийг нарийвчилж ярихдаа энэ салбарт ажиллаж байгаа мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан.

-Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл гэж байгуулагдсан талаар форумас мэдээлэл авсан. Тус зөвлөлийн үйл ажиллагааны талаар сонирхуулах уу?

-Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл гэж энэ онд байгуулагдсан. Тус зөвлөл энэ жилийн форумыг хамтарч зохион байгууллаа. Энэ зөвлөлийн талаар Р.Амаржаргал гишүүн ч гэсэн нээлтийн үеэр хэлсэн үгэндээ цохон тэмдэглэсэн. Мэргэшсэн хүмүүс нь ажлаа хийдэг, салбараа ярьдаг, дагнадаг болъё. Үүнийг нийгмийн хариуцлагын салбарт гарч ирж байгаа өөрчлөлт гэж онцолсон. 2012 онд манай байгууллагаас зохион байгуулж байсан компаниудын дугуй ширээний уулзалтад оролцож байсан уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлага, орон нутаг, байгаль орчин хариуцдаг байсан мэргэжлтнүүд нэгдэж уг зөвлөлийг

байгуулсан. Салбараа хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулъя гэдэг үүднээс ийнхүү байгуулагдаж байгаа. Үүнийг бол манай үндэсний форумын нэг үр дүн гэж харж байна.

-Зөвлөлийн хийх ажил юу байх вэ?

-Уул уурхайн салбарт нийгмийн хариуцлагын тогтвортой хөгжлийн хэм жэмжээг тодорхойлж гаргах, түүнийг танилцуулах, бодлогын үйл ажиллагаанд нь оролцох, мэргэшүүлэх, орон нутагт ажиллахад ямар бэрхшээлүүд тулгардаг, үүнийг хэрхэн давж болох олон улсын ямар стандарт дүрэм журам байдаг. Монголын ямар сайн туршлага байгаа. Юун дээр алдаад байдаг гэх мэт асуудлаар компаниудыг чадавхижуулах, мэдээлэл өгөх. Нэг удаагийн хандив тусламжаас илүү тодорхой төсөл хөтөлбөр дээр компаниуд ажилладаг болох, эрчим хүч болон бусад хэмнэлтийг компани дотооддоо хэрхэн хийж болох. Тэр дундаа үүнийг жижиг, дунд компаниудад хэрэгжүүлэхэд анхаарах. Томоохон компаниудад бол хэрэгжүүлж болдог.

Жижиг, дунд компаниудад хэрэгжүүлэх боломж байдаг. Үүнийг хэрэгжүүлснээр компанийн үйл ажиллагаа тогтвортой урт хугацаанд явах, цаашлаад үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж гарч ирэх юм гэдгийг зөвлөх үйлчилгээ, дэмжлэг болоод бусад зүйлээр хийхээр төлөвлөсөн. Бодлогын зөвлөлдөө мэргэжлийн хүмүүс болон судлаачдыг багтаасан байдлаар ажиллахаар үйл ажиллагаагаа эхлээд байна.

-Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний асуудал. Энэ бол өмнө нь олон сонсогддог ч хийх хэрэгжүүлэх дээрээ шинэ зүйл юм. Ямар ажил хийж байна вэ, цаашаа ямар томоохон зүйл хийхээр төлөвлөсөн бэ?

-Орон нутагтай хамтран ажиллах гэрээ, хамтын ажиллагааны гэрээ, Олон талт хамтын ажиллагааны гэрээ гээд олон янзаар нэрлээд байгаа. Ашигт малтмалын тухай хуульд Орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж туссан /Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д/. Энэ өөрчлөлтийг

өнгөрсөн жил долоодугаар сард өөрчлөлт хийхдээ оруулж өгсөн. Уул уурхайн компани нь орон нутагтай, орон нутгийн засаг захиргаатай Орон нутгийн хамтран ажиллах гэрээ байгуулна гэж оруулсан. Тиймээс гэрээний загвар гаргах шаардлагатай болсон. Гэрээг хэрхэн амьдралд нийцсэн байдлаар талуудад тэнцвэртэй байдлыг хангасан загвар гаргах вэ гэдэг амар хийх ажил биш. Энд бол маш олон талын ашиг сонирхол байдаг.

-Яагаад заавал гэрээ хийх ёстой вэ?

-Тодорхой шаардлага байгаа. Уул уурхайн нэр хүнд унасан, иргэдийн эсэргүүцэл нэмэгдсэн гэдэг ч юм уу. Нөгөө талаар уул уурхайгаас олж байгаа орлого тухайн сум орон нутагтай үлдэх асуудал байгаа.

Орон нутгийн иргэдийн аж амьдрал дээшлэх гээд олон давуу талтай.

-Гэрээг хийхдээ гол нь юу анхаарах вэ?

-Хуульд уул уурхайн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон дэд бүтэц, түүнтэй холбоотой байгаль орчны асуудал. Мөн ажлын байрыг дэмжих гэсэн гурван үндсэн чиглэлээр уул уурхайн компани Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулна гэж заасан. Манайд өмнө нь энэ чиглэлээр компаниудын хийсэн гэрээ байдаг. "Оюутолгой" компанид том хэмжээний гэрээ байдаг. "Мон Епсо" компани сумтай, аймагтай хийж байсан. "Энержи ресурс" ч гэсэн хийж байсан. Гэхдээ хуулиар гэрээ хийгдэхээр байгаа учраас загвар гаргахаар ажиллаж байна.

Үүн дээр манай зүгээс батлагдахаас нь өмнө талуудын оролцоог нь хангая, гарсан саналуудыг цаашид төсөлд оруулах чиглэлээр дэмжлэг үзүүлье. Мөн олон улсад ийм хуульчилсан загвар байдаг юм уу, байвал энэ нь хэр үр дүнтэй хэрэгждэг юм бэ гэдгээр гаднын судлаачдыг авчирч, үгийг нь сонслоо.

-Олон улсад хуульчилсан загвар байдаг юм байна уу?

-Форумд Independent Social Performance Pte.ltd компанийн захирал,

ахлах зөвлөх Ж. Кушмаиндер “Орон нутгийн хөгжлийн гэрээг цогцоор хийхэд олон улсын аргууд –сайн муу жишээ” гэсэн сэдвээр танилцуулга хийсэн. Тэрбээр хэлэхдээ ийм гэрээ ихэвчлэн Африкийн арваад оронд байдаг гэсэн. Бид өндөр хөгжсөн орнуудаас туршлага судлах дуртай. Канад, Австралид бол ийм гэрээ байдаггүй юм байна.

-Олон талын оролцоо байх учраас их л зөв хийх хэрэгтэй байх. Талуудад зөрчил үүсгэхгүй байх нөхцөлийг хангасан байдлаар хийх загвар ямархуу байдлаар гарч ирнэ



гэж та урьдчилан төсөөлж байгаа вэ?

-Зөрчил үүсэхгүй байх нэг зүйл нь дээр хэлсэн хуульд заасан гурван асуудал дээр байгаа. Жижиг хайгуулын компани том гадаадын хөрөнгө оруулалттай компани хоёр яг ижил байх юм уу гэдэг асуудал тавигдана. Жижиг тэр дундаа хайгуул хийж байгаа компани шууд орлого байхгүй үед үүнийг хэрхэн зохицуулах вэ гэдэг. Үүн дээр суурь зарчмууд байх юм уу гэдэг дээр компаниуд өөрсдөө илүү ярилцах болж байгаа.

Нэгэнт загвар гаргаад өгчихвөл орон нутгийн зүгээс компанитай яг л тэр загварын дагуу та нар бидэнтэй ингэж ажиллах ёстой гэнэ. Тэгэхээр нөгөө талаасаа уул уурхайгаа дэмжих

бус хаах нэг шалтгаан руу түлхэж ч болзошгүй асуудал үүсч болзошгүй. Тэгэхээр Засгийн газар гэрээг батлахдаа нэлээд олон талаас нь харж үзэх байх.

-Хэлэлцээрт оролцох талуудын бэлтгэл хэр хангагдсан байна вэ гэдэг асуудал бас гарна байх.

-Тийн, энэ асуудал гарна. Хуульд гэрээг сумын түвшинд хийнэ гэсэн байгаа. Өмнө нь уул уурхайн үйл ажиллагаа явж байсан сум орон нутгийн иргэдийн хувьд бага зэрэг ойлголттой байна уу гэхээс огт уул уурхайн талаар ойлголтгүй сумын удирдлагууд гэрээний хэлэлцээрт

үед санаа бодлоо хэлэх юм. Үүнийг бас сайн тодотгож оруулж өгөх. Хоёр тал гэрээ хийчихдэг. Гурав дахь тал үүнийг эсэргүүцээд үйл ажиллагааг нь зогсоогоод унавал яах вэ гэдэг ч юм уу. Энэ мэт олон асуудал дээр маш няхуур хандаж, талуудын зөрчил маргааныг үүсгэхгүй байх дээр нэлээд анхаарч хийх хэрэгтэй. Компанийн болон нөлөөллийн хэмжээ гээд олон асуудлын тэнцвэрийг олж харах гэдэг маш чухал.

-Олон удаа уулзалт, хурал хийх хэрэгтэй юм байна. Өнөөдрийн байдлаар энэ талаар хэр олон хуралдсан бол.

-Уул уурхайн яам хэлэхдээ долоон ч удаа ямар нэгэн байдлаар хурал зохион байгуулсан гэсэн. Хурлыг ихэнхдээ хотод хийж байгаа. Зарим тохиолдолд орон нутгийн төлөөлөл ирж оролцдог. Уул уурхайн гэрээ хийгдэх бүх сумдад чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааг хийхгүй бол болохгүй. Мэдээлэл дутмагаас гэрээ байгуулаад л мөнгөтэй болчих юм байна гэсэн чинь уул уурхайн сөрөг нөлөөллийг нь сүүлд нь хараад асуудал үүсэхийг үгүйсгэхгүй.

Нөгөө талаасаа аймаг, орон нутгийн засаг захиргааны удирдлагуудад хэлэлцээр хийх ур чадвар ямар байх вэ гээд бодох асуудал багагүй. Мэдээж бүх тал хүлээн зөвшөөрсөн гэрээний төсөл гарна гэж бүтэхгүй.

-Танайх энд яагаад оролцож байгаа вэ?

-Манай төсөл дөрвөн аймагт үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр аймагт уул уурхайн үйл ажиллагаа явагдана. Бид жижиг, дунд үйлдвэрлэлийг чадавхижуулах тал дээр анхаарч ажиллаж байна. Жижиг, дунд үйлдвэрлэгчид орон нутгийн иргэд байдаг.

Нөгөө талаас тэд уул уурхайн ханган нийлүүлэгч учраас Орон нутгийн цогц хөгжил -Түншлэлд дөрөв дэх тал болж оролцох ёстой юм гэж үзэж байгаа. Тиймээс талуудын эрх ашгийг тэнцвэржүүлсэн гэрээний төсөл байгаасай гэдэг үүднээс дэмжин ажиллаж байна. ■

ДАВХАР ДААТГАЛ



Ард Даатгал компани нь давхар даатгалын үйл ажиллагааг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, СЗХ-ны дүрэм журамтай нийцүүлэн олон улсад мөрдөгддөг хэм хэмжээнийн дагуу явуулдаг ба энэ талаар олон жилийн ихээхэн туршлага хуримтлуулсан бөгөөд олон улсын давхар даатгалын зах зээл нэр хүндтэй дотоодын даатгагч юм. Ийм ч учраас дэлхийн томоохон давхар даатгалын нэг болох ХБНГУ-д төвтэй Европын Холбооны хамгийн том даатгалын групп Allianz нь Ард Даатгал компанийг Монгол дахь стратегийн түншээр (strategic partner) албан ёсоор сонгож ажиллаж байгаа юм.

Манай компанийн төлөөлөгчид Азийн давхар даатгалын зах зээлийн оролцогчдын зохион байгуулдаг даатгалын салбарын ээлжит хурлуудад (EAIC-East Asian Insurance Conference-2012, 2014 болон Singapore International Reinsurance Conference 2013-(SIRC)) тогтмол оролцсоор ирсэн бөгөөд энэ нь манай компанийн олон улс дахь нэр хүндэд эерэг үр дүн авчирсан юм.

Шууд даатгагчийн хувьд бид ихэвчлэн барилга угсралтын ажил, агаарын хөлөг, хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал, гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын хэлбэрүүдээр өндөр даатгалын үнэлгээтэй гэрээнүүдийг давхар даатгуулж байна.

Бид даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн хариуцлагаа бүтнээр болон хэсэгчлэн нэр хүнд бүхий давхар даатгалын брокеруудаар дамжуулан олон улсын даатгалын (ихэвчлэн Лондон, Ллойдсийн синдикатууд, Сингапурын) зах зээл дээр давхар даатгал нарт даатгалын гэрээг баталгаатай, бодит үнээр, түргэн шуурхай борлуулан, хамгаалалт олж авдаг билээ. Мөн гадаад хамтын ажиллагааны хүрээнд манай компани ОХУ-ын Ингострах болон дэлхийн 33 оронд салбартай эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч компани болох Францын Европ ассистанс компанитай хамтран гадаадад аялагчдын иж бүрэн даатгалын үйлчилгээг санал болгож байна.

ТООН МЭДЭЭЛЭЛ

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үндсэн үзүүлэлт

/2014.12.31-ний байдлаар/

д/д	Компанийн нэрс	Төрийн эзэмшлийн хувь	Нийт хөрөнгө	Нийт өр төлбөр	Өөрийн хөрөнгө	Ашиг/алдагдал
1	ДЦС-2	100	13,560.90	3,807.70	9,753.20	(545.10)
2	ДЦС-3	100	137,653.70	34,571.80	103,081.90	2,302.20
3	ДЦС-4	100	436,675.80	116,485.70	320,190.10	(4,595.05)
4	Дарханы ДЦС	100	80,910.80	31,176.90	49,733.90	(154.50)
5	Эрдэнэтийн ДЦС	100	42,612.60	3,184.20	39,428.40	(1,096.70)
6	Даланзадгадын ДЦС	100	9,888.10	7,083.90	2,804.20	(1,073.90)
7	Улаанбаатар ЦТСүлжээ	100	125,036.40	54,668.30	70,368.10	89.80
8	Эрдэнэт-Булганы ЦТС	100	39,030.80	5,017.30	34,013.50	511.50
9	БЗӨмнөд Бүсийн ЦТС	100	38,370.40	4,448.30	33,922.10	(1,325.80)
10	ЦДҮСүлжээ	100	289,804.10	27,859.10	261,945.00	(2,389.00)
11	Баруун Бүсийн ЭХС	100	29,374.30	2,664.90	26,709.40	(2,203.30)
12	Дорнод Бүсийн ЭХС	100	51,202.10	13,372.00	37,830.10	(0.60)
13	Өмнөд Бүсийн ЦТС	100	8,001.30	1,023.70	6,977.60	22.90
14	Улаанбаатар ДС	100	127,590.80	27,074.20	100,516.60	1,071.80
15	Дарханы ДС	100	11,607.20	1,131.70	10,475.50	(268.50)
16	Багануурын ДС	100	7,634.40	2,878.70	4,755.70	(838.30)
17	Налайхын ДС	100	3,381.40	1,810.70	1,570.70	(635.80)
18	Дулаан Шарын гол	100	2,184.70	1,016.80	1,167.90	(62.80)
19	Алтай-Улиастай ЭХС	100	108,589.00	45,147.10	63,441.90	(4,055.20)
20	Баянчандмань АЗЗА	100	1,571.10	680.50	890.60	49.80
21	Налайх АЗЗА	100	1,364.50	257.70	1,106.80	14.70
22	Төв АЗЗА	100	1,621.00	963.90	657.10	(218.30)
23	Хөвсгөл АЗЗА	100	1,031.60	142.20	889.40	5.50
24	Дархан АЗЗА	100	2,643.40	1,769.00	874.40	23.50
25	Өвөрхангай АЗЗА	100	1,234.70	317.10	917.60	14.60
26	Архангай АЗЗА	100	1,076.30	202.00	874.30	80.80
27	Говь-Алтай АЗЗА	100	835.80	315.10	520.70	3.00
28	Дорноговь АЗЗА	100	1,819.80	438.70	1,381.10	78.20
29	Булган АЗЗА	100	1,945.60	982.70	962.90	50.80
30	Завхан АЗЗА	100	1,738.50	462.20	1,276.30	6.50
31	Орхон АЗЗА	100	1,182.00	637.60	544.40	95.80
32	Сэлэнгэ АЗЗА	100	1,534.90	467.60	1,067.30	106.10
33	Хархорин АЗЗА	100	819.00	241.70	577.30	(37.30)
34	Увс АЗЗА	100	1,027.10	440.20	586.90	171.50
35	Ховд АЗЗА	100	1,321.10	522.40	798.70	7.80
36	Авто замын ТТТ	100	2,178.90	360.40	1,818.50	(179.20)
37	Багануур АЗЗА	100	2,501.30	582.90	1,918.40	(345.20)
38	Эрдэнэсант АЗЗА	100	858.90	213.20	645.70	20.00
39	Харгуй	100	4,415.30	6.50	4,408.80	245.90
40	Талын -Зам	100	483.70	54.50	429.20	(63.80)

д/д	Компанийн нэрс	Төрийн эзэмшлийн хувь	Нийт хөрөнгө	Нийт өр төлбөр	Өөрийн хөрөнгө	Ашиг/алдагдал
41	Дархан Төмөрлөгийн үйлдвэр	100	205,573.50	169,798.20	35,775.30	(1,435.10)
42	МИАТ	100	234,569.10	310,108.20	(75,539.10)	(50,518.90)
43	Хөтөлийн Цемент- Шохой	100	212,405.50	202,212.70	10,192.80	175.50
44	Оргил рашаан сувилал	100	5,691.20	26.80	5,664.40	487.20
45	Монголын Төмөр зам	100	468,550.60	71,801.20	396,749.40	(7,319.50)
46	Эрдэнэс МГЛ:		394,510.30	411,989.70	(17,479.40)	(15,369.60)
	Эрдэнэс Таван толгой		740,198.20	853,290.60	(113,092.40)	(64,704.10)
47	МХСүлжээ	100	90,236.30	50,653.90	39,582.40	3,815.40
48	Монгол шуудан	100	15,076.30	2,182.40	12,893.90	459.70
49	Диспетчерийн ҮТөв	100	14,430.40	13,888.10	542.30	(510.10)
50	Хөдөө аж ахуйн бирж	100	1,258.80	145.20	1,113.60	(256.30)
51	Мон-Атом	100	2,919.80	5,167.20	(2,247.40)	(802.00)
52	Төрийн банк	100			150,929.00	18,739.80
53	Хөгжлийн банк	100			263,666.90	119,787.40
54	Биокомбинат	100	7,087.40	8.50	7,078.90	237.90
55	Монгол кино нэгтгэл	100	1,815.30	20.70	1,794.60	(77.30)
56	Геологийн судалгааны төв	100	892.10	173.90	718.20	50.50
57	Геологийн төв лаборатори	100	7,448.80	1,022.60	6,426.20	39.60
58	Сэргээгдэх ЭХ-ний ҮТөв	100	947.30	157.40	789.90	50.10
59	ШТШАБайгууламж	100	5,233.30	-	5,233.30	187.70
60	Аялал жуулчлалын ҮТ	100	72.50	140.50	(68.00)	(150.00)
61	Цагаан шонхор	100	146.60	98.70	47.90	(45.30)
62	Монгол тамга	100	347.00	47.90	299.10	40.20
63	Төрийн үйлчилгээ	100	2,062.70	1.70	2,061.00	30.60
64	Барилгын хөгжлийн төв	100	6,814.90	4,349.60	2,465.30	1,854.60
65	Эрчим хүчний ЭЗХүрээлэн		774.20	268.50	505.70	13.60
66	Монгол-Ус	100	1,311.00	134.60	1,176.40	123.00
67	МТҮПарк	100	2,054.10	145.30	1,908.80	(140.30)
68	Автотээврийн үндэсний Төв	100	18,083.90	6,484.20	11,599.70	558.50
69	Шивээ-Овоо	90	89,046.30	81,465.60	7,580.70	(5,044.60)
70	ИНЕГазар		270,180.70	9,171.60	261,009.10	20,670.10
71	Армоно корпораци	100	1,093.80	68.60	1,025.20	(66.70)
72	Багануур	75	101,236.10	94,860.40	6,375.70	(6,383.40)
73	Автоимпекс	51	2,931.00	6,184.20	(3,253.20)	0.30
74	Кино урлагийн ДС	40	1,441.60	488.50	953.10	25.50
75	Эрдэнэт үйлдвэр	51		511,251.40	1,007,273.90	187,514.50
76	Монросцветмет нэгдэл	51	62,517.80	59,673.50	2,844.30	(9,099.40)
77	Улаанбаатар төмөр зам	50	791,647.20	186,539.50	605,107.70	528.90
78	МЦХ	54.7	40,583.20	8,249.10	32,334.10	522.90
79	Монсам ХХК	80	1,169.60	5,649.70	(4,480.10)	(39.10)
80	Сайншанд АҮЦ	100	4,747.50	846.50	3,901.00	(639.90)
81	Монголын хөрөнгийн бирж	100	8,302.10	6,773.90	1,528.20	(874.80)
82	ҮЦТТТХТ	100	12,994.20	10,701.60	2,292.60	309.20

БЗӨмнөд Бүсийн ЦТС - Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ

ЦДҮС - Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ

МХСүлжээ - Мэдээлэл холбооны сүлжээ

ИНЕГ - Иргэний нисэхийн ерөнхий газар

ШТШАБайгууламж - Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж

МТҮПарк - Мэдээлэл технологийн үндэсний парк

МЦХ - Монголын цахилгаан холбоо

ҮЦТТТХТ- Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв



Бидний харилцдаг давхар даагчид нь үнэлгээ хийж, зэрэглэл тогтоодог эрх бүхий S&P, A.M. Best Company зэрэг байгууллагуудаас өндөр зэрэглэл авсан олон жилийн түүхтэй, олон улсын даатгалын зах зээл дээр нэр хүндтэй давхар даагч нар байдаг юм. (Жич: Hannover Re, (Standard & Poor's AA- "Very Strong" and A.M. Best A+ "Superior") гэх мэт)

Манай гэрээнд түгээмэл оролцож буй давхар даагч нарын заримыг дурьдвал, Munich Re, Swiss Re, Hannover Re, Catlin, Starr underwriting, QBE, Lloyd's syndicates, Chartis, ACR, Kiln, Allianz AIG Europe, Zurich Re, AWAC, Royal & Sun Alliance, Tokio Marine Europe, Unity Re, Ingosstrakh, Russian Re, PICC, China Re, Best Re, Mapfre, Beazley Singapore, түүнчлэн давхар даатгалын зарим брокеруудыг дурьдал AON, Marsh, JLT, Willis, UIB, JB Boda, Faber, SAG, Malakut гэх мэт компаниудыг дурьдаж болно.

Ард даатгал компанийн давхар даатгалын гэрээнүүд нь факультатив (facultative), гэрээт (treaty) болон фронтингийн (fronting) гэрээний төрлүүдээр хийгддэг бөгөөд дээр дурьдсан давхар даагч нар оролцдог. Цаашид бид бүх төрлийн давхар даатгалын гэрээний гэрээт (treaty) төрлийн гэрээг байгуулах бэлтгэл ажилдаа орж үүнтэй холбоотой судалгаа, харьцуулалт, үнэлгээний ажлуудыг давхар даагч компани, олон улсын брокер компанитай хамтран гүйцэтгэж байна.

Бидний үйлчилгээ нь гадаад, дотоодын бүхий л харилцагч даатгуулагчиддаа даатгалын үйлчилгээг олон улсын стандарт, нөхцөлөөр Монгол Улсад дотооддоо шууд хүргэж чадах хэмжээнд хэдийнээ хүрсэн нь өнөөдрийн бидний ажлын ур чадвар, туршлага, хамтрагч түншүүдтэй маань холбоотойг мэдээлэхэд таатай байна.



СЭРЭЛТ
ТАКС ТМЗ ХХК

ТАНИЛЦУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан "Сэрэлт" ХХК нь "Сэрэлттакс ТМЗ" ХХК-ийг үүсгэн байгуулж Сангийн сайдын 2015 оны хоёрдугаар сарын 16-ны өдрийн 37 тоот тушаалын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчиддаа татвараа хуулийн дагуу үнэн зөв тодорхойлоход нь туслах үндсэн үүрэгтэй манай хамт олон татварын эрх зүйн орчныг тасралтгүй судалж шинжлэн, харилцагчдынхаа үйл ажиллагаанд учирч болох татварын аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлгүй ажиллуулах үндсэн зорилт тавин ажиллаж байна.

Бид харилцагчдаа шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр цаг тухайд нь бүрэн хангах, аливаа эрсдлийг богино хугацаанд арилгах, заавар зөвлөмжийг хууль тогтоомжын хүрээнд хамгийн энгийн ойлгомжтой хувилбараар хүргэхийг зорьж, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлүүдийг анхааралтай судалж мэдээллэн ажиллаж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ
- Татварын зөвлөх үйлчилгээ
- Бусад зөвлөх үйлчилгээ

Хаяг: Чингэлтэй дүүрэг 1-р хороо
Энхтайваны гудамж, Denver оффис, 304 тоот
Утас/Факс: 99093541, 88002321



Сонгуультай жилийн ТООЦООЛОЛ

Ц.Сайхан

Цалин хасахгүй, цомхтгохгүй гэдэг төсвийн байгууллагын ажилтнуудад сайн мэдээ. Харин хувийн хэвшлийнхэнд тийм ч таатай зүйл биш. ДНБ-ий 3.3 хувьтай тэнцэх алдагдал бүхий төсвийн төсөл өргөн барихтай зэрэгцэн хариуцлагатай он жилүүд айсуу учир төсвийг алдагдалгүй батлах ёстой гэж олон эдийн засагч, бизнесмэнүүд санаа бодлоо илэрхийлж байв. Төсөв хэлэлцэн батлах сар гаруйн хугацаанд алдагдлыг тэглэх боломж бий гэж тэд харж байлаа. Ийм эрх нь УИХ-ын гишүүдэд бий. Гэвч эцсийн дүнд төсвийн алдагдал 0.1 хувиар өсч ДНБ-ий 3.4 хувьтай тэнцэх болов.

Нэгдсэн дүнтй чих өөрчлөгдөөгүй боловч орлого зарлагын бүтцийн хувьд нэлээд хөдөлгөөн орсон. Ирэх оны хагас жилээс Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор зардал хэмнэхээр тусгасан байсныг УИХ-ын гишүүд “хийх гэж байгаа юм бол бүтцийн өөрчлөлтөө оны эхнээс хий” гэсэн шахалт үзүүлснээр энэ саналаа татсан. Засгийн газраас зарим байгууллагыг татан буулгах нэгтгэн зохион байгуулах санал оруулсныг УИХ-ын ажлын хэсгийн шийдвэрээр Улсын бүртгэлийн газрыг Үндэсний статистикийн хороотой, Гаалийн ерөнхий газрыг Татварын ерөнхий газартай нэгтгэж, үлдсэнийг нь өөрчлөхгүй байхаар тогтсон. Үүнтэй холбоотойгоор 130 тэрбум төгрөгийг цалингийн зардалд нэмж суутгаж байгаа юм.

Гэхдээ л бүх шатны төсөвт байгууллагад хэмнэлтийн горим мөрдөх эхнээсээ тодорхой байсан бөгөөд төсвийг эцэслэн батлахад ч онцын өөрчлөгдөөгүй билээ. Цалин хасахгүй гэж амласан ч нэмэхгүй гэдгээ шулуухан илэрхийлж байгаа. Урсгал зардал талаас гадаад, дотоод албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт, семинар, ном хэвлэлийн зардал зэрэг тэвчиж болох зардлыг 16.4 тэрбум төгрөгөөр, Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын дүнг бууруулж үүнтэй холбогдуулан зээлийн хүүгийн төлбөрийг 26.6 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан байна. Мөн төрийн захиргааны албан хаагчдын цалингийн санг 10 хувиар бууруулсан. Гэхдээ төсвийн ерөнхийлөн захирагч нарт урсгал зардал дотроо зохицуулалт хийж болох эрх нь хуулиар нээлттэй байгааг УИХ-ын дарга З.Энхболд хэлж буй. Цомхтгол хийх үү, бусад урсгал зардлаа тэвчих үү гэдэг сонголт хийх мэдэл яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт бий аж. Тухайлбал, УИХ-ын Тамгын газар хууль санаачлах зардлын 10 сая төгрөгийг энэ жил үгүй болгосноороо 43 орон тоог цомхтгох шаардлагагүй болжээ.

Урсгал зардлын өсөлтийг дагаад төсөвт ачаалал үүссэн учир хөрөнгийн зардлаа танахаас өөр арга байгаагүй. Энэ жил хоёр ч удаа төсвийн тодотголыг хийж, хөрөнгө оруулалтын зардал 50 хувь буурсан. Үндсэндээ

концессын хэдэн гэрээгээр хийсэн ажлуудыг эс тооцвол төр шинэ бүтээн байгуулалт хийгээгүй. Ирэх жил ч мөн шинээр сургууль, цэцэрлэг, эмнэлэг барихгүй гэдэгт УИХ-ын гишүүд санал нэгдлээ. Ингээд хөрөнгө оруулалтын зардлыг 94 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан. Тэгэхдээ 149.9 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг хасч, оронд нь тусгагдаагүй байсан 79.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг нэмжээ. Сангийн сайд Б.Болор хоёр дахь хэлэлцүүлгийн дараа “зардал нэмэгдсэнээр санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй төсвийн алдагдал бий боллоо. Өмнө нь алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь тодорхой байсан. Засгийн газрын үнэт цаасны хүү өнөөдөр ямар байгаа билээ” хэмээн ярьсан.

Нэмэгдсэн зардлуудыг сөхөж үзвэл УИХ-ын компьютер, техник, тоног төхөөрөмжид 667 сая, улсын хэмжээнд сумдад цагдаагийн хэлтсийн байр, кобанд 1.7 тэрбум, суманд МСҮТ барихад хоёр тэрбум төгрөг гэх мэтчилэнгийн зардал нэмэгдэж, 2017 онд дуусгавар болох зарим төслүүдийг заавал ирэх жил амжуулахаар хугацааг нааш татсан зүйлүүд бий. Түүнчлэн шинэ хөрөнгө оруулалтын зардалд зөвхөн 2016 онд багтаан хэрэгжүүлэхээр иргэдийн ажлын байрыг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтад таван тэрбум төгрөг, Хөдөлмөрийн салбарын тоног төхөөрөмжид хоёр тэрбум, Хилийн цэргийн ангид 24

машины граж, халуун усны барилга барихад 2.1 тэрбум төгрөгийн төслийг нэмж тусгасан байна. Харин Ерөнхий сайдын зүгээс газар дээр нь очиж танилцан хотын Төв цэвэрлэх байгууламжийн хуримтлагдсан лагийг боловсруулах дамжлага нэмэхэд зориулж 8.1 тэрбум төгрөгийг төсөвт нэмж суулган батлуулсныг олон нийтийн зүгээс дэмжиж буй.

Харин нөгөө талд хасагдсан төслүүдээс дурьдвал говийн бүсийн газрын тос боловсруулах үйдвэрийн дэд бүтцийн инженерийн зураг төсөл боловсруулах, ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх /нийт таван тэрбум төгрөг/, Алтанбулаг сумыг шинэ цэвэр усны эх үүсвэртэй болгох /400 сая төгрөг/, Сумдыг өндөр хурдны шилэн кабельд холбох /900 сая төгрөг/, НӨАТ-ын буцаан олголт тогтолцоо бий болж буйтай холбоотой татварын систем программ хангамж /

хоёр тэрбум төгрөг/ нэвтрүүлэх төслүүд багтаж байна. Төсөв хэлэлцэх явцад гарч байсан зөрчил бол эдийн засгийн төсөөлөл. Монголбанк, Сангийн яамны мэргэжилтнүүдийн тооцоолсноор ирэх онд эдийн засаг 4.1 хувь өсөх бөгөөд 2017 онд 4.6, 2018 онд 8.9 хувь өснө хэмээн тооцоолжээ. Өнгөрсөн жил дотоодын мэргэжилтнүүд эдийн засаг 2015 онд 5.4 хувь өснө гэж таамаглаж байсан бол олон улсын байгууллагууд 3-4 хувь орчим байна гэсэн таамаг дэвшүүлсэн. Гэвч энэ оны эцэст эдийн засаг ердөө 2.3 хувь болохоор байгааг Дэлхийн банкны сүүлийн судалгаанд дурьджээ. Уул уурхайн түүхий эдийн үнийн уналттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засгийн өсөлт ирэх жил дахин саарах магадлалтай гэж үзэж буй. Ямартай ч, УИХ-ын ажлын хэсэг дотоодын шинжээч нартаа итгэж төсөөлөлд ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй.

Эдийн засгийн өсөлтийг 20 хувь хүрнэ гэж “итгэж” байсан үе саяхан. Ирэх жилийн төсвийн хувьд хаа хаанаа хүлээн зөвшөөрч буй нэг зүйл нь өмнөх жилүүдээс зарим талаар давуу талтай болсон хэмээж буй. Халамжийн бодлогыг хавтгайд нь олгохоос татгалзаж эхэлж байна. Хүний хөгжил сангаас олгодог хүүхдийн мөнгийг амьжиргааны түвшин дунд болон дундаас доогуур өрхийн хүүхдүүдэд олгохоор болсон. Ойролцоогоор 823 мянга орчим хүүхэд байгаа аж. Сонгуультай жилийн төсөв гэхэд хийрхэл багатай болсон гэлцэж буй. Төсвийг алдагдалгүй баталж чадаагүй ч бага тоонд барьсан, барих гэж хичээсэн. Хойтон жилээс орлого, зарлагаа тэнцүүлэх Сангийн яамны төлөвлөгөөг Парламентаар баталсан хэмээн УИХ-ын дарга З.Энхболд ярьсан. Энэ нь бондын төлөлтөд эерэг нөлөө үзүүлэх юм.■

14 ХОНОГИЙН СЭДЭВ

С.Эрдэнэ ба Эрдэнэс-Таван толгой

Ц.Бадрал

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн “Эв санааны нэгдэл” үйлдвэрчний эвлэлийн дарга С.Эрдэнэ гэгч өөрийгөө галдан шатаасан нь олон нийтийг цочирдуулсан хэрэг боллоо. Тэрбээр Эрдэнэс-Таван толгой ХК болон “ТТJVCO” компанийн хооронд хийсэн “Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээ”-г эсэргүүцэн мэдээлэл хийхээр хэвлэлийн бага хурал зарласан байв. Өөрийгөө шатаахаас өмнө Засгийн газрын бодлого, буруу, үйл ажиллагаанаас болж Эрдэнэс-Таван толгой ХК цаасан дээр л үлдлээ, “Шатах ёстой бол шатъя” гэжээ.

Түүний амьсгалын зам түлэгдсэн, 30-40 хувийн түлэгдэлтэй гэсэн онош тавьсан байна. Тэрбээр одоо ГССҮТ-д



“Эрдэнэс-Таван толгойн” үйлдвэрчний эвлэлийн гишүүд суулт зарласан. Харин компанийн зүгээс ажилтнуудтайгаа зөвшилцөд хүрч, асуудлыг шийдвэрлэлээ.

хэвтэн эмчлүүлж байгаа. Биеийн байдал нь дээрдэж, сэтгэл санаа хэвийн байгаа аж.

Асуудал хаанаас эхэлсэн бэ?

Өнгөрсөн аравдугаар сарын 12-нд тус компанийн ажилчид “ТТJVCo” компанийн удирдлагад шилжиж байгаага мэджээ. Уг нь “Эрдэнэс-Таван толгой” ХК-тай гэрээ байгуулан ажиллаж байсан тэд ажлын байраа алдаж мэдэх нь гэж айх болсон байна. Үйлдвэрчний эвлэлийн зүгээс компанийн удирдлагууд ажилчдаа Хятадын хөрөнгө оруулалттай компанид худалдлаа, энэ бол хөдөлмөрийн хуулийг ноцтой зөрчиж байгаа хэрэг хэмээн үзэж байгаа юм.

Хоёр компанийн хооронд байгуулсан гэрээгээр Тавантолгойн ордын Зүүн Цанхид олборлолтын ажилд оролцож байгаа 203 ажилтныг “ТТJVCo” компанид шилжүүлж байгаа аж. Ингэснээр тэдгээр ажилчид тус компанитай хөдөлмөрийн гэрээ байгуулж, тэндээс цалинжих юм. Ийнхүү ажилчдаа шилжүүлэх болсон шалтгаанаа “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн удирдлагууд эдийн засгийн нөхцөл байдалтай холбон тайлбарлаж буй. Дэлхийн зах зээл дээр нүүрсний үнийн уналт үргэлжилсэн хэвээр байна. “Эрдэнэс-Таван толгой” ХК одоогоор 14 сарын зогсолт хийгээд буй. Зүүн Цанхийн уурхайгаас Хятадын “Чалко” компанид нүүрс нийлүүлэх үүрэгтэй. Урьдчилгаа төлбөрөө барагдуулж дуусаагүй тул нүүрсээ нийлүүлээч гэсэн шаардлага тавих болжээ. Нэгэнт авчихсан мөнгөө төлж барагдуулахгүй удах тусам хүү, торгууль, алданги гэсэн том эрсдэлд орох тул “ТТJVCo” компанитай удаан хугацаанд хэлэлцээр хийсний эцэст дээрх тохиролцоонд хүрчээ.

Ажлын байр нь баталгаагүй болсон гэж үзэж байгаа ажилчдын хувьд хоёр компанийн хооронд хийсэн гэрээг Монгол хэл дээр унших боломжгүй байсан нь хардалтыг улам нэмэгдүүлж байжээ. Ямартай ч өнгөрсөн хугацаанд үйлдвэрчний эвлэлээс компанийн удирдлагууд шаардлага тавьснаар гэрээг Монгол хэлээр авч, “ТТJVCo” компанитай нэг жилийн хөдөлмөрийн гэрээ байгуулахаар байсныг 33 сарын хугацаатай болгох тохиролцоонд

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн удирдлагууд хүрээд буй аж. Гэрээний хугацаанд цалин хөлс хасах, орон тоо, бүтцийн өөрчлөлтөөр хөдөлмөрийн гэрээг цуцлахгүй байх тохиролцоо хийснийг ажилчдад мэдэгсэн байсан аж.

“ТТJVCo” компанийн тухай

“Эрдэнэс-Таван толгой” ХК Таван толгой ордын Зүүн Цанхийн уурхайд 2011 онд сонгон шалгаруулалт зарлахад Австралийн “Макмахон” компани оператороор шалгарчээ. Энэ компани Монголд бүртгэлтэй “ТТJVCo” гэдэг компаниараа дамжуулж үйл ажиллагаагаа явуулдаг, техник хэрэгсэл, менежментийг хариуцаж ажилладаг байна. Тус компанид олборлолтын өртгийг нь “Эрдэнэс-Таван толгой” ХК төлдөг байсан аж.

“ТТJVCo” компанийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл интернэт орчинд лав үгүй. “Макмахон” компанийн цахим хуудаснаас ч “ТТJVCo” гэх үгийг олж уншихгүй. “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн зүгээс өгч буй мэдээллээр бол уг компанид Хятадын төрийн болон, хувийн хэвшлийн ямар нэгэн оролцоо байхгүй гэлээ.

Хэрхэн өрнөв?

С.Эрдэнэ өөрийгөө шатаасантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг үйл явдлын дараахан холбогдох албан тушаалтнуудыг цуглуулж үүрэг даалгавар өгсөн. С.Эрдэнийн эрүүл мэнд, эмчилгээний зардлыг “Эрдэнэс-Таван толгой” ХК-иас гаргуулахаар тогтож, компанийн гүйцэтгэх захирал Б.Батбилэгийг албан тушаалаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан юм. Шинэ гүйцэтгэх удирдлага томилогдтол “Эрдэнэс Монгол” ХК-ийн Хууль эрх зүйн асуудал эрхэлсэн захирал Т.Билгээг түр орлон гүйцэтгэгчээр томилсон.

Хэрэг болсон өдөр буюу 13-ны 15:00 цагт Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас мэдээлэл хийв. Тус компанийн Гадаад харилцаа, орон нутаг, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Т.Гэрэлтсансар “С.Эрдэнийн хийсэн үйлдэлд харамсаж байна. Бид ажилчдаа сул зогсолт хийлгэхгүй ажилтай байлгах үүднээс 33 сарын

турш өөр компанид ажиллуулахаар шийдвэрлэсэн” гэж мэдэгдсэн юм.

Үйлдвэрчний эвлэлийн зүгээс одоо тавьж байгаа шаардлага нь “байнгын ажлын байран дээр хугацаатай гэрээ байгуулах гэж байна” гэдэг аж. Хөдөлмөрийн хуулиар “ТТJVCo” компани ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулах учиртайг “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Билгээ хэлж буй. Тэрбээр мөн “Гэрээн дотор хугацаатай хамаатай ийм зүйлийг тодотгож оруулна гэсэн заалт хуульд байхгүй. Ямар ч бизнес эрхлэгч орлогогүй болчихвол ажилчдаа цомхтохоос аргагүйд хүрдэг. Эдийн засаг таагүй байгаа сүүлийн хоёр жилд яг ийм шалтгаанаар цомхотголд орсон өчнөөн хүн бий. Харин бид хэцүү байсан ч энэ хүмүүсийг ямар ч цомхотголд оруулахгүй байж, тогтвортой ажлын байраар ажилчдыг хангахын тулд зарим шаардлагыг “ТТJVCo”-д тавьж, зөвшөөрүүлсэн” хэмээжээ. Түүний хэлж буйгаар бүх ажилтан “ТТJVCo” компанитай хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд 33 сарын хугацаанд бүтэц орон тооны өөрчлөлт зэрэг шалтгаанаар халахгүй гэсэн заалт оруулах аж.

С.Эрдэнэ өөрийгөө шатаасан хэрэгтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 95.1 дүгээр заалтыг үндэслэн түүнийг амиа хорлоход хүргэсэн шалтгааныг тогтоохоор эрүүгийн хэрэг үүсгэсэн тухай мэдээлэл гарав. Тодруулбал С.Эрдэнэ нь өөрийгөө шатаан эрүүл мэндээрээ хохирсон тул түүнийг хохирогчоор тогтоосон бөгөөд энэ үйлдлийг хийхэд хүргэсэн учир шалтгааныг тогтоохоор шалгаж байгаа аж. “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн удирдлагуудын зүгээс С.Эрдэнийг хууль шүүхийн байгууллагад хандаж болох байсан гэдэг байр суурь илэрхийлж байгаа юм.

Үйл явдлын эргэн тойронд

Хэргийн талаар “Иргэдийн шударга шүүх” ТББ, “Хөх Монгол” бүлгэм, “Эрдэнэс-Таван толгой” компанийн Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл өөрсдийн байр сууриа илэрхийлсэн. Тухайн үед цахим мэдээллийн хэрэгслүүдээр “С.Эрдэнэд эрүү үүсгэн

шалгаж эхэллээ” гэсэн гарчигтай мэдээ их цацагдсанаас тэд ийн мэдэгдэхэд хүрчээ. “Төр засгийн зүгээс өөрийгөө шатаасан хэрэг нь олон нийтийг өдөөн хатгасан, хүчирхийлэлд уриалан дуудсан шинжтэй үйлдэл байсан гэж үзсэн бол иргэний нийгмийн байгууллагууд эсрэг байр суурьтай байна” гэж ярьсан аж.

Хэрэг явдал болсны дараагаар “Монголын ардчилсан холбоо”-ноос мөн мэдэгдэл гаргасан юм. Мэдэгдэлд “С.Эрдэнийн хийсэн үйлдэл нь асар эрсдэлтэй, цочмог, монгол хүний сэтгэл зүйд хүнд тусахаар хэлбэрийг сонгосноороо оновчгүй гэж бид үзэж байгаа ч түүний тэмцлийн агуулга, хандлага нь эх орныхоо төлөө, монгол хүн бүрийн эрх ашгийн төлөө байсныг бид сэтгэл зүрхээрээ мэдэрч, дэмжиж байна. Өндөр дээд эрх мэдэлд хүрсэн ганц нэг улс төрчийн

улс үндэстнийхээ эрх ашгаас урван цөөн хэдэн олигархийг дампуурлаас аврахыг илүүд үзсэн хандлага ийм эрс шийдэлд иргэдийг түлхэж байгаагийн нэгээхэн илрэл нь С.Эрдэнэ өөрийгөө шатаасан явдал боллоо” гэсэн байна.

Гадаадын хэвлэлүүд Монголын үйлдвэрчний эвлэлийн дарга Хятадын компанийн нүүрс олборлолтыг эсэргүүцэж өөрийгөө шатаалаа гэсэн утгатай мэдээ цацагдаж сошиал хуудсуудаар нэлээд тархаад байна. Түүнчлэн С.Эрдэнэ өөрийгөө шатааж эрүүл мэндээ хохироосны дараагаар Монголын зарим иргэн Засгийн газрыг эсэргүүцэж буйгаа илэрхийлж эд эрхтнээ огтлох, хөрөнгөө шатааж эсэргүүцлийн хүнд хэлбэрийг сонгоход бэлэн байгаагаа сошиал хуудсаар дамжуулан мэдэгдээд байна.

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан

тушаалаа өгсний дараа Б.Батбилэг өгсөн ярилцлагадаа үйл явдлын гол зангилаа болсон асуудалд дараах тайлбарыг хийжээ. “Чалько компанийн зүгээс шүүх хяналтын байгууллагад хандана. Нүүрсээ, эсвэл мөнгөө авмаар байна, хурдан ажлаа эхлүүл гэдэг шаардлагыг бичгээр бидэнд тавьж байсан. Өөрөөр хэлбэл, давхар хоёр компани “Эрдэнэс-Таван толгой”-г Арбирт өгөхөд бэлэн, тэвчээр нь туйлдаа хүрсэн нөхцөлд гэрээг хэрэгжүүлж эхэлсэн. Ажилчдаа шилжүүлэх процесс явагдахад ихэнх ажилчид үүссэн асуудлыг зөв өнцгөөс харж, компанийн болон өөрийнхөө, цаашлаад улс орны эрх ашгийг бодолцож хүлээн зөвшөөрч байгаагаа хэлж байсан. Хэрвээ үүссэн асуудлаар Арбитр дээр очсон бол өнөөдөр 203 хүн шууд ажилгүй болох байсан” хэмээн ярьсан байна.■

АЙЛЧЛАЛ



10 тэрбум ам.долларын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж БНХАУ-ын дарга Си Зиньпиний урилгаар энэ сарын 9-11нд БНХАУ-д төрийн айлчлал хийв. Энэхүү айлчлал нь хоёр улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосноос хойш хийгдэж буй анхны төрийн айлчлал гэдгээрээ онцлогтой.

Айлчлалын үеэр хоёр орны төрийн тэргүүний хэлсэн үгнээс дурдахад, **БНХАУ-ын дарга Си Зиньпин** “Өнөөдөр Хятад, Монголын харилцаа түүхийн хамгийн таатай үедээ явж байна. Өнгөрсөн жил миний бие танай улсад айлчлал

хийсэн нь хоёр тал Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосноо хамтдаа тунхаглаж, хоёр талын харилцааны шинэ үеийг нээсэн түүхэн ач холбогдолтой болсон гэж үздэг. Хятад, Монголын харилцаа нь хоёр улсын хамтын хүчин чармайлтын амжилт, хоёр талын нийтлэг эрх ашигт нийцэж, мөн хоёр талын ард түмний дэмжлэгийг авч амжилттай хөгжиж буйд бид сэтгэл хангалуун байдаг юм. Хятад, Монгол хоёр улс нь сайн хөрш, сайн найз, сайн түнш бөгөөд бид хоёр улсын харилцаандаа өндөр ач холбогдол өгч, цаашид харилцаагаа хөгжүүлэхийг гадаад бодлогынхоо

тэргүүлэх чиглэл гэж үздэг юм” гэлээ. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хариу хэлсэн үгэндээ “Хоёр улсын хооронд өндөр, дээд түвшний харилцан айлчлал, ажил хэргийн уулзалтын давтамж нэмэгдэж буй нь улс төрийн харилцан итгэлцлэлийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм. Худалдаа, эдийн засгийн салбар нь хоёр

улсын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг байсаар ирсэн бөгөөд цаашид худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх нөөц боломж байгаа төдийгүй, хоёр талын худалдааны хэмжээг 2020 онд 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтод хүрэх боломжтой юм” хэмээв.

Айлчлалын хүрээнд хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны дараах баримт бичгүүдийг үзэглэснийг сонирхуулж байна.

1.Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр

2.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын 2016 онд олгох 300 сая юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн солилцох захидал

3.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын 2016 онд олгох 300 сая юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн солилцох захидал Худалдаа, эдийн засгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Аж үйлдвэрийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яам хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг

4.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт Импорт банк хоорондын 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээр

5.Шивээ-Овоо төслийн ТЭЗҮ-ийн судалгааны ажлыг хамтран гүйцэтгэх тухай Монгол Улсын Эрчим хүчний яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний цахилгаан дамжуулах сүлжээ корпораци хоорондын гэрээ

6.Гүүрэн гарц барих төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээр

7.Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээр

8.Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны махыг Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улсад экспортлох, импортлох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хоорондын санамж бичиг

9.Иргэний агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах ажиллагааг зохицуулах тухай Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар, БНХАУ-ын Иргэний нисэхийн удирдах газар хоорондын хэлэлцээр

10.Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Худалдаа хөгжлийн банк болон Хятадын хөгжлийн банк хоорондын хэлэлцээр зэрэг баримт бичигт гарын үсэг зурлаа.

АЙЛЧЛАЛЫН ДӨРӨӨ ЖИЙСЭН ДАРААГИЙН УЛС

Мөн Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн айлчлалын дөрөө жийсэн дараагийн улс тэвдүүхэн байгаа Франц байлаа. Тэрбээр энэ сарын 11-19-нд Франц Улсын ерөнхийлөгч Франсуа Олландын урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийсэн юм. Айлчлалын үеэр хоёр улсын ерөнхийлөгч нар хэлэлцээ хийж улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, эрчим хүч, хөдөө аж ахуй, хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, соёл, боловсрол, шинжлэх ухаан, спортын салбарт харилцаа хамтын ажиллагаагаа түлхүү хөгжүүлэхээр тохиролцлоо. Францын их, дээд сургуулиудад суралцах Монгол залуу оюутнуудад олгодог тэтгэлгийн тоог нэмэгдүүлэх боломжийг судлахаар тохиролцож, Монгол-Францын археологийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэхээр тогтжээ.

Түүнчлэн ирэх онд Монгол Улсад зохион байгуулах АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана гэдгээ Франц Улсын Ерөнхийлөгч хэлжээ. Айлчлалын хүрээнд хоёр улсын төрийн тэргүүн дараах гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр;

-Францын хүнсний тусламжийн сангийн хөрөнгийг ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр;

-Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Гадаад хэрэг, олон улсын хөгжлийн яам хооронд сургалтын хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлэлцээр;

-Кино урлагийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон Бүгд Найрамдах Франц Улсын Кино дүрсний үндэсний төв хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;

-Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Бүгд Найрамдах Франц Улсын Гадаад хэрэг, олон улсын хөгжлийн яам хоорондын хэлэлцээр;

-Үхрийн үүлдэр угсаа сайжруулах чиглэлээр Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам, Бүгд Найрамдах Франц Улсын Хөдөө аж ахуй, хүнс, ойн яам хоорондын хамтын ажиллагааны эрмэлзэх бичиг.

Франц Улсын Ерөнхий сайдын 2016 онд Монгол Улсад хийх айлчлал нь энэхүү хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд түлхэц өгөх, улмаар хоёр орны харилцааг шинэ шатанд гаргах боломж олгоно хэмээн үзэж буй юм. ■

ХӨРШ

Юрген Конрад: Хятадад хангалттай өсөлт бий

О.Түвшин



Азийн Хөгжлийн Банкны Хятад дахь суурин төлөөлөгчийн газрын эдийн засгийн асуудал хариуцсан нэгжийн дарга Юрген Конрад арваннэгдүгээр сарын 13-нд Улаанбаатар хотноо АХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газраас зохион байгуулсан байгаа "Insight Mongolia" семинарт Хятадын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал болон худалдааны талаар лекц тавихаар ирсэн юм. Энэ үеэр манай сэтгүүл түүнтэй ярилцлаа. Тэрбээр улсын болон хувийн санхүүгийн байгууллагад 24 жил ажилласан туршлагатай нэгэн бөгөөд 2013 оноос АХБ-ны Бээжин дэх эдийн засгийн багийг удирдах болсон юм. Тэдний баг эдийн засгийн шинжилгээ болон бодлогын хэлэлцүүлэгт төвлөрч ажилладаг аж.

-Өнөөгийн бараг бүх л мэдээнээс харахад, БНХАУ-ын эдийн засаг таагүй байх хандлагатай гэж байна. Харин АХБ тус улсын өсөлтийг 2015 онд 6.9 хувьтай байна гэж таамагласан. Байдал үнэндээ ямархуу байна. Мөн та Хятадын эдийн засгийн нөхцөл байдлыг "уналт" эсвэл "гацаа" гэх үг ашиглан тодорхойлж байгааг хэр зүйтэй гэж үзэж байна вэ?

-Үгүй ээ, бид үүнийг зүйтэй гэж бодохгүй байна. Мэдээж хэрэг ДНБ-ий өсөлт удааширч байгааг харж байна. Өсөлт 10 хувиар барахгүй дэлхийн санхүүгийн хямралаас өмнө 10-аас дээш хувьтай байдаг байсан бол харин

одоо долоогоос доош хувь руу орсон. Гэсэн хэдий ч энэ хугацаанд Хятад улс өссөн. Хятад бол одоо маш том эдийн засаг болсон бөгөөд дэлхийн ДНБ-ий 13 хувийг эзэлж байна. Тиймээс тус улсын эдийн засаг одоо ч гэсэн долоон хувьтай өсөж байгаа учраас үүнийг уналт гэж үзэхэд бэрх юм.

-Өнгөрсөн зун маш хүнд хөрөнгийн зах зээлийн уналт болсон. "The Guardian" сонин үүнийг 1929 оны Уолл Стритийн уналттай зүйрлэсэн. Хятадын хар даваа гаригийн нийт эдийн засагт үзүүлсэн нөлөө юу байсан бэ?

-Зургаадугаар сараас эхэлж наймдугаар сарын үед дууссан зах зээлийн үнэлгээний томоохон засвар буюу бодит түвшиндээ лүүгээ ойртсон өөрчлөлт юм. Энэ нь өнгөрсөн жилийн сүүлээс эхэлсэн хувьцааны үнэлгээний хэтэрхий их, огцом өсөлтийн дараа тохиолдож байгаа юм. Тиймээс үнийн засвар гэж би үзэж байгаа. Наймдугаар сараас эхлэн үнэлгээ бараг 25 хувиар сэргэсэн. Бид тодорхой хэмжээний савалгааг мэдэрсэн боловч яг хөрөнгийн зах зээлийн уналт биш юм. Хөрөнгийн зах зээл БНХАУ-ын эдийн засгийн хувьд АНУ-тай харьцуулахад харьцангуй ач холбогдол багатай байдаг. Цөөн тооны аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлээр дамжуулан хөрөнгө босгодог. Хөрөнгө болон зээлийн дийлэнх нь хуучинтай адил банкны системээс бүрддэг. Хөрөнгө оруулагчын талаас үзэхэд маш цөөн тооны айл өрхүүд л хувьцаанд хөрөнгө оруулдаг. Макро

эдийн засгийн талаасаа хөрөнгийн зах зээлийн савалгаа үндсэндээ чухал үйл явдал байгаагүй.

Тавдугаар сард ОУВС юанийн үнэлгээ хэт өндөр байхаа больсон хэмээн зарласан. Наймдугаар сард БНХАУ өөрийн валютын ханшаа хоёр ч удаа бууруулсан. Харин АНУ Хятад улсыг удаан хугацааны турш валютын арга заль хэрэглэдэг гэж буруутгасаар ирсэн. АХБ энэ асуудалд албан ёсны байр суурийг баримталж байна уу, хэрэв үгүй бол та өөрийн саналаасаа хуваалцаж болох уу?

Бидэнд өөрсдийн албан ёсны байр суурь байдаг. Бусад олон байгууллагын адилаар 1990-ээд оны болон 2000-гаад ондбид юанийн ханшийн үнэлгээг бодитоос доогуур байна гэж үзэж байсан. Үүнийг ч ОУВС болон зарим Засгийн газартай бодлогын хүрээнд авч хэлэлцсэн. Гэвч энэ асуудал зогсонги байдалд хүрсэн. Одоогийн байдлаар бид, ОУВС болон ихэнх зах зээлийн оролцогчид юанийг бодитой үнэлэгдэж байгаа гэж үзэж байгаа. Мөн Хятадын Засгийн газар наймдугаар сард ханшийг албаар унагасан гэж бодохгүй байна. Ердөө л тэгж ойлгогдохоор байгаа юм. Тус улсын засгийн газар үнэндээ өдөр тутмын валютын ханш тогтох үйл ажиллагааг илүү зах зээлд суурилсан болгохыг хүссэн. Өөрөөр хэлбэл, брокерууд болон хөрөнгө оруулагчдад ирэх өдрийн валютын ханшийг ямар байхыг шийдвэрлэх эрхийг олгохын тулд шүү дээ. Гэсэн

хэдий ч үүнийг ханшийг үнэгүйдүүлж, гадаад өрсөлдөх чадвараа нэмэх хүчин чармайлт гэж буруу ойлголт төрүүлсэн. Харин Хятадын Засгийн газар ийм зүйлийг удаан хугацааны турш хийгээгүй бөгөөд тэр дундаа хямралын үед яавч хийхгүй. Дэлхийн санхүүгийн хямралын үеэр ч, Азийн хямралын үеэр ч тэр. Тиймээс яагаад тэд заавал одоо хийнэ гэж.

-АНУ-аар тэргүүлүүлсэн, дэлхийн эдийн засгийн 40 хувьд хамааралтай Транс-Номхон далайн орнуудын түншлэл бэлэн боллоо. Хятад улстай худалдаа ихээр хийдэг Вьетнам, Япон, Малайз, Сингапур болон АНУ зэрэг улс гарын үсэг зурсан. Хятадын засгийн газар энэхүү гэрээг хэрхэн хүлээн авч байна вэ, цаашлаад Хятадын тэргүүлж буй бүс нутгийн эдийн засгийн түншлэлд хэрхэн нөлөөлөх вэ?

-БНХАУ бараг хоёр жилийн өмнөөс Транс-Номхон далайн түншлэлийг сонирхож эхэлсэн бөгөөд хэлэлцээрийн үйл явцад оролцохоор зэхэж байсан. Гэвч ингээгүй, би дүгнэлт хийхийг хүсэхгүй байгаа ч Транс-Номхон далайн түншлэл гэж юу вэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ нь зөвхөн барааны худалдааны талаар биш харин Дэлхийн худалдааны байгууллагын хамарч чаддаггүй үйлчилгээний худалдааг мөн хамаардаг бөгөөд энэ нь маш шинэлэг юм. Энэ нь мөн төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой бөгөөд олон худалдааны бус хоригуудтай холбоотой. Энэ нь их өндөр хүлээлттэй гэрээ бөгөөд Хятад улсын хувьд гэрээнд хамрагдсан бол эхэн үедээ маш хэцүү байх байсан. Учир нь үйлчилгээний салбар эсвэл төрийн худалдан авах ажиллагааг гадны компаниудад нээлттэй болгох шаардлагатай тулгарах байсан бөгөөд үүнд Хятад улсад тийм сонирхол бага байна. Өөрөөр хэлбэл, бүгд л Хятад улсыг нэгдээсэй гэж хүсч байгаа, эцсийн эцэст Хятад нэгдэх мөч ирнэ. Гэхдээ яг одоо биш.

-Олон улсын зах зээл дээрх түүхий эд болон таваарын үнэ хамгийн доод цэгтээ хүрлээ. Хятадын импорт багасах төлөвтэй байна. Хятадын аж үйлдвэржилт

удааширч байгаа ч жижиглэн худалдаа харьцангуй хурдацтай өсөж байна. Хятадын "шинэ хэвийн байдал"-тай дасан зохицохын тулд тус улс руу чиглэх экспортод түшиглэсэн улс орнууд яах ёстой вэ?

-БНХАУ-тай худалдаа арилжаа хийдэг орнууд яалтч үгүй дасан зохицох хэрэгтэй. Учир нь Хятадын бүтцийн өөрчлөлт маш хурдан хэрэгждэг. Хятад улс шинэ өсөлтийн загварыг хайж байна, мөн Хятадтай бизнес хийж байгаа хүмүүст зөвлөхөд өөрийн улсын бүтцийн өөрчлөлт хийх, шинэ загварыг хайх хэрэгтэй гэж хэлэх байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр та Хятад руу юу экспортолдог эсвэл импортолдогос хамаарна гэсэн үг. Түүхий эд, таваарын экспортлогчид нэг өөр хэрэг, машин механизм болон өргөн хэрэглээний барааны экспортлогчид ч өөр. "Шинэ хэвийн байдал" гэдэг нь өсөлт өмнөхөөс доогуур байна гэсэн үг, гэхдээ энэ нь ирэх 15 жилд Хятадыг өндөр орлоготой улс болж өсөхөд хангалттай юм. Өөрөөр хэлбэл, Хятад улсад хангалттай зах зээлийн өсөлт байгаа бөгөөд экспортлогч орнуудад ч олон боломж байна, заавал уналтад орж буй хүнд аж үйлдвэр биш, харин шинээр гарч ирж буй илүү хэрэглээнд чиглэсэн үйлдвэрлэл болон үйлчилгээнд боломж байна.

-Узбекистан, Казахстан магадгүй Монгол зэрэг оронд үйлчилгээ болон хэрэглээнд чиглэсэн эдийн засагт хүрэхээр зэхэж буй Хятадын "Шинэ хэвийн байдал"-аас олж авах давуу талууд байна уу?

Түүхий эд үйлдвэрлэгч орнуудын дунд эдийн засгаа төрөлжүүлэх асуудал маш их яригдаж байна. Үүнийг АХБ дэмжиж байгаа. Гэвч түүхий эддээ анхаарлаа хандуулж илүү өрсөлдөх чадвар бүхий түүхий эдийн зах зээл болох нь бас нэг ашигтай хувилбар юм, ялангуяа жижиг орнуудад. Жишээ нь Хятад улсын зэсийн эрэлт хэрэгцээ буурлаа ч жижиг экспортлогч эдийн засаг өөрийн зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлж болно. Монгол, Казахстан болон бусад Хятадтай хөрш орон Австрали эсвэл Канад зэрэг улсаас Хятад улстай илүү ойрхон шүү дээ. Эдгээр улс өөрийн орон зайг бий

болгож, түүхий эдийн зах зээлд амжилттай байж болохгүй гэх зүйлгүй. Хэрвээ тэд үйлдвэрлэл болон дэд бүтцээ сайжруулахад илүү хөрөнгө оруулалт хийвэл Хятад улстай удаан хагацааны турш амжилттай бизнесийг хийж чадна.

-Монгол Улсад үндэсний үзэл нь улс төрийн болон эдийн засгийн бодлого боловсруулалтад гол хүчин зүйл байдаг. Харин Хятад улсад үндсэрхэг үзэл эдгээр бодлогын шийдвэрүүдэд нь ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

-Би үндсэрхэг үзлийг тодорхойлж хэлж чадна гэдэгтээ итгэлтэй биш байна. Гэвч аливаа улсын иргэд өөрийн үндэс угсааг чухалд үзэж, бахархах нь байдаг л зүйл. Энэ нь тэр дундаа том улсууд гэхээс илүүтэй жижиг оронд илүү чухал байдаг гэж боддог. Хятад улсын хувьд энэ нь бусдаас арай өвөрмөц, яагаад гэвэл бид бүгд тус улсыг ямар хүнд хэцүү түүхтэйг мэднэ. Олонхи үнэлэмж нь их дарамтад орсон байсан. Хятадын засгийн газар болон Хятад улсад Хятад хүн байх ухамсар болон ололт амжилтынхаа бахархалыг сэргээх гэж хичээж байгаа гэж ойлгож байна. Бусад улс үндэстнүүдийн эсрэг мэт ойлголт л төрүүлэхгүй байх хэрэгтэй. Хятад улс хоёр маш чухал улс төрийн уриатай. Эхнийх нь "Хятад мөрөөдөл" бөгөөд үүнийг зарим гадны улсууд үндсэрхэг үзэл гэж ойлгож магадгүй. Нөгөөх нь "Үндэсний сэргэлт". Үүний санаа нь 150-200 жилийн өмнө Хятад улс бүс нутгийн төдийгүй дэлхийн хэмжээнд зонхилох том улс байсан бөгөөд тэд одоо энэ байр сууриа эргүүлэн олж авахыг хүсэж байна гэсэн үг юм. Дахин хэлэхэд энэ нь холоос харахад заналхийлсэн аюултай мэт санагдах боловч бүх л улсад байх ёстой зүйл бөгөөд үүнийг нь хүлээн зөвшөөрөх ёстой. Хятад бол маш том бөгөөд өсөж буй эдийн засаг. Бид бүгд худалдаа, хөрөнгө оруулалт хийх болон татах боломжуудыг Хятад улсаас хайх хэрэгтэй. Би шудрага зөвшилцөл болон ашигтай төсөл хийх нь л чухал гэж боддог. Харин үндсэрхэг эсэх, бардам эсэх зэрэг бусад асуудлыг эдийн засагчид, банкирууд магадгүй улс төрчид хойш тавих хэрэгтэй. ■

АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэржилтийн шинэ зам

Г.Орхон



Фотос Б.Бямба-Очир

500 мянган шувуутай “Мон-Эгг” тахианы фэрм

Монгол Улсын Аж үйлдвэрийн салбарыг хүүхдийн өсөлттэй зүйрлэвэл дөнгөж мөлхөж явна. Үйлдвэржилтийн хөгжлийг ийм түвшинд явж буйг улсдаа анх удаа зохион байгуулагдсан Аж үйлдвэрийн чуулганы оролцогчид хэлж байв. Нэг үгээр, эл салбар ДНБ-ий дөнгөж 10-хан хувийг үйлдвэрлэж байгаа юм. Харин үйлдвэржилтийн хөгжлийн эцсийн шатанд хүрч хэдийнэ “хөлд орсон” Япон, Солонгос, Тайвань тэргүүтэй орнууд өнөөдөр хөгжлийн шинэ үе болох инновацид суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дахин “толгой цохиж” явна. Гэвч бидэнд эдгээр улсын түвшинд богино хугацаанд очих боломж буйг салбарынхан төдийгүй төрийн өндөрлөгүүд онцолж байна. Үйлдвэржилтээ эрчимжүүлэхийн тулд гаргасан төрийн бодлого эдгээр улсын араас нь хөөх биш “амдан гүйцэж хөгжих бодлого” гэдгийг салбарын сайд онцоллоо. Тиймээс Аж үйлдвэрийн яам инноваци, өндөр технологид суурилсан, өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ гэдэг бодлогоо үйлдвэрлэгчдэд зарлалаа. Гэвч бидний өмнө олон сорилт хүлээж байгаа нь тодорхой. Харин “Бид эрсдэлээс айдаг улс орон мөхөхийн тавилантай гэдгийг мартаж болохгүй. Учир нь монголчууд гарааны зурхайн дээр зогсч байна” гэдгийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат “Монголд Үйлдвэрлэв” нэртэй өнгөрсөн сарын 16-нд болсон Аж үйлдвэрийн чуулганы хаалтын үеэр хэлсэн нь

үйлдвэрлэл эрхлэгчдэд урам өгч байв.

Манай улсын бизнесийн орчин хийгээд үйлдвэржилтийн талаар олон улсын байгууллагуудын судалгааны дүн тааруу үзүүлэлттэй гарч байгаа ч үүнийг сайжруулахад төр хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудын оролцоо чухал гэгддэг. Нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулагчид Монголыг гэх бизнесийн мэлмийгээ үл цавчин, тэдгээр үзүүлэлт, дүгнэлтийг үргэлж ажиж суудаг гэнэ. Тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форумын тайлангаас үзэхэд манай орны өрсөлдөх чадвар 133 орноос 109 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Нийт боловсруулах үйлдвэрлэл дунд өндөр технологи дөнгөж 5.3 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь ОХУ-аас дөрөв дахин, БНХАУ-аас найм дахин доогуур байна гэсэн үг. Түүнчлэн дэлхийн эдийн засгийн эерэг шалгуур үзүүлэлтээр боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 20 хувь байдаг бол манай улсынх үүнээс хоёр дахин бага буюу 8-9 хувьтай байна.

Харин Дэлхийн банкнаас гаргадаг бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр энэ жил Монгол нийт 189 орноос 72 дугаарт эрэмбэлэгджээ. Энэ нь өмнө жилүүдтэй харьцуулахад багагүй урагшилсан үзүүлэлт боловч гадаад худалдаагаар сүүл мушгиж байна. Тиймээс бид энэ чиглэлд анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байгаа юм. Үйлдвэржилтийн талаарх төрийн бодлого гадаад худалдааг дэмжиж буй

бөгөөд тэр дундаа, экспортыг дэмжих бодлогоор үйлдвэрийн салбарыг дэмжинэ гэж байна. Улсын эдийн засагт учирч буй бэрхшээл, цаашид эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд экспортыг дэмжих үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх нь зүйтэйг Монгол Улсын Ерөнхийлөгч Аж үйлдвэрийн чуулганы мэндчилгээндээ онцолсон. Мөн тэрбээр “2015 онд ерөнхийлөгчийн зарлигаар экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг нэн даруй бүрдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, шинээр эрчимтэй хөгжиж буй мэдээллийн технологи, кластер, инновацийг аж үйлдвэрийн салбарт оруулах нь зүйтэй” гэсэн юм.

Салбарын яамны зүгээс импортыг орлох, экспортыг дэмжих үйлдвэрлэлийг дэмжинэ гэж буй. Гэхдээ импортыг орлох бодлогын хүрээнд дотоодын бизнес эрхлэгчдийг хамгаалах бодлогыг хязгаартай хэрэгжүүлэх хэрэгтэйг мэргэжилтнүүд хэлж байна. Тухайлбал, дотоодод үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүний импортыг “сааруулах” үүднээс импортоор орж ирж буй хэд хэдэн нэр төрлийн барааны гаалийн албан татварын хувь хэмжээг нэмэхээр болсон. Нэг талаар дотоодын үйлдвэрлэгчдийг зах зээлийн өрсөлдөөнөөс хэт хамгаалах бодлого явуулбал тэднийг зах зээлд өрсөлдөх чадваргүй болгоно гэж үзэж байна. Монгол Улсын 14 дэх Ерөнхий сайд

Д.Содном “Өрсөлдөөн байх ёстой. Экспортоо дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлэх хэрэгтэй. Аль аль нь хэрэгтэй” гэв.

Экспортод чиглэсэн, олон улсын чанар стандартыг хангасан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлага бидэнд бий юу гэвэл тийм. Ингэхийн тулд энэ хэмжээний технологи, үйлдвэр шаардлагатай. Үүнийг хийсэн тохиолдолд бид бусад зүйлээ зохицуулж чадна гэх саналыг чуулганд оролцогчид хэлж байв. Төрийн бодлого яг үүн рүү чиглэж байгаа бөгөөд ерөөсөө экспортоо түлхүү дэмжих ёстойг Аж үйлдвэрийн сайд энэ үеэр сэтгүүлчдэд дуулгасан. Гагцхүү экспортыг дэмжих ажил удааширч буйн шалтгаан нь бид өөрөө өөрсдийгөө цэгцлэх асуудлаас үүдэлтэйг тэрбээр ярилаа. Тиймээс салбарын яамны зүгээс Аж үйлдвэрийн чуулганыг зохион байгуулж төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагынхан нийтлэг ойлголттой болох боломж гэж үзжээ.

Тэгэхээр манай улсад үйлдвэрлэсэн бүхий л зүйлээ экспортлох нь чухал асуудал биш. Гагцхүү боловсруулсан бүтээгдэхүүнээ экспортлох нь чухал болоод байна. Ингэвээс одоогийнхоос илүү ашиг олох боломж бий аж. Яамны зүгээс ч мөн бүгдийг нь бус инновацид тулгуурласан, өрсөлдөх чадвартай, өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, экспортлоно гэж байна.

Чуулганд оролцсон хувийн хэвшлийнхнийг төлөөлж “Дархан нэхий” ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Батсайхан “Төр дэмжсэн. Одоо бидний хувьд хариуцлага чухал байна. Экспорт бол том хариуцлага. Арьс шир нь эцсийн бүтээгдэхүүн гаргаснаар нэлээд орлого олох боломжтой том салбар. Одоогийн байдлаар энэ салбарт 2-3 мянган хүн ажиллаж байна. Гэтэл үүнээс 10 дахин их хүн ажиллах боломжтой. Бидэнд зах зээл байна. Хоёр хөршийг дурьдаж болно. Гол нь Монголоос экспортлож

захирал Г.Майцэцэгийн ярьж буйгаар оёмол бүтээгдэхүүний түүхий эд болон туслах материалуудыг хөнгөлөлттэй орж ирэх гаалын татвараас хасчихаж. Мөн бизнес эрхлэгчид импортолж буй түүхий эдийнхээ гаалийн албан татвараас хөнгөлөлт эдэлдэг байсан журам энэ оноор дуусгавар болж байгаа аж.

Үүнийг сунгах эсэх нь одоог хүртэл тодорхойгүй байгааг “Urban jeans” компанийн төлөөлөгч төрийн төлөөллүүдээс лавласан юм. Харин УИХ-ын гишүүн Д.Ганхуяг “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиар импорт, экспорттой холбоотой татварын зохицуулалтын асуудлыг Засгийн газарт өгсөн. Импортын гаалийн татварыг хөнгөлөх, нэмэх эсэх асуудлыг Засгийн газар дээр шийдэх боломжтой гэж үзэж байгаа. Худалдааны хууль УИХ дээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа. Нэлээд цаг хугацаа, тэвчээр, хөдөлмөр шаардсан ажлууд. Бид үүнийг давах



Фотос Б.Бямба-Очир

Монгол Улс “эдийн засаг” гэх нэр томъёотой болсон цагаас л бараа, бүтээгдэхүүн экспортолж байсныг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Да.Ганболд чуулганы индрээс олонд хэлсэн. Түүний онцолсноор бид Хубилай, Чингис хааны үед одоогийн экспортолж буй ноос, ноолуур, арьс шир юуныг л гадагшаа зөөдөг байж. Гэтэл өнөөдөр бид дээрх барааны төрлөө бүрэн өргөжүүлж үл чадан зуун жилээр энэ хэдийгээ л тээвэрлэсээр.

байгаа бараа, бүтээгдэхүүний чанар стандарт гаднынхны шаардлагад нийцэхгүй, нөгөө талаас үнэ өндөр байгааг гаднынхан хэлж байна. Худалдааны бодлогоо цэгцлэхгүй бол болохгүй нь” хэмээв.

Үйлдвэрлэл эрхлэгчид уг салбарт төрийн дэмжлэг чухлыг онцолж байсан ч зарим төрлийн үйлдвэрлэлд төр тусламжийн гараа сунгахгүй, эсвэл сунгасан гараа татаж байна гэж байлаа. Жишээлбэл, “Exclusive” компанийн

ёстой” гэх “бүүдгэр” хариулт өгсөн юм.

Оролцогчдын зүгээс энэ салбарт судалгаа эрдэм шинжилгээнд хөрөнгө зарцуулахгүй байгаа, яамны зүгээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах тал дээр анхаарал сул буйг сануулсан. Учир нь манай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн гаднын зах зээл өрсөлдөх чадвар тун сул гэдгийг мэргэжилтнүүд хэлдэг. Хэдий яамны зүгээс үйлдвэрүүдийг томруулахын

тулд “жижиг”, “дунд”, “бичил” гэж илүү нарийн ангилж тус бүрт нь чиглэсэн бодлого хэрэгжүүлэхийг зэхэж байгаа ч энэ нь өрсөлдөх чадвар сул “жижиг” үйлдвэрлэлийг төрүүлж буйг хувийн хэвшлийнхэн анхааруулж байна. Тиймээс эл салбарыг жижигрүүлж болохгүйг “Мон Ланс” компанийн захирал Д.Баасан манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа дурьдсан байлаа. Тэрбээр “Бүр жижгэрчих гээд байгаа. Тодорхой үйлдвэрүүдийг бодлогоор томруулж бусад жижиг үйлдвэрээ кластераар хөгжүүлээд аваад явах хэмжээний жишиг томоохон үйлдвэрүүдийг бий болгох хэрэгтэй” гэсэн. Яамны зүгээс кластерийг хөгжүүлэх бодлого барьж байгаа ч нөгөө талаас, дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид хэтэрхий хувиа хэчээсэн

байдалтай байна гэдэг. Учир нь тэд нэгдэн нийлж үйлдвэрлэл эрхлэж, бизнес эрхлэх сонирхол, түүний шимийн талаарх мэдлэг хомс байгаа юм. Угтаа бол кластер нь зардал хэмнэхээс эхлээд давуу тал олонтой.

Бизнес эрхлэгчдэд өрсөлдөх чадвар байхгүйг илтгэж буй өөр нэг жишээ нь тэд авсан зээлээ эргэн төлж чадахгүй байгаа явдал. Нөгөө талаас тэдний үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанар тааруу гэх үнэлгээг хэрэглэгчдээс багагүй сонсдог. Тиймээс яам, холбогдох газрууд энэ чиглэлд анхаарч ажиллахыг сануулсан.

Аж үйлдвэрийн чуулганы хамгийн олон хүний хэлийг загатнуулсан хуралдаан “Экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн

үйлдвэрлэл” сэдэвт хуралдаан байсныг энд тэмдэглэе.

Хэдий улсын экспортын 80 гаруй хувь нь уул уурхайн салбараас хамааралтай гэж байгаа ч ойрын хугацаанд эл салбараас санхүүжиж, үйлдвэржилтийг хөгжүүлэх боломжтойг эдийн засагчид дуулгаж байна. Өнөөдөр эдийн засгийн төрөлжилт байхгүйг олон тоо баримт харуулж буй. Харин өнөө цагаас эхлэн түүхий эдийн экспортын хараат орноос түүхий эдийн нөөцдөө тулгуурласан аж үйлдвэрийн хөгжлийн гараанд гарахаар зэхэж сууна. Гагцхүү ингэхдээ үйлдвэржилтийн гараанаас бидэнтэй хамт гарсан ч хэдийнэ үйлдвэржсэн Солонгос, Тайвань зэрэг улсын араас бид хөөх бус хөгжлийн шинэ замаар түүчээлэх нь.■

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн гарц

Э.Уранбилэг /Актурч/



Монгол улсын санхүүгийн зах зээлийн 95 хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байгаа нь уг тогтолцооны гажуудал, нэг салбараас хэт хамааралтай байдлыг харуулж байна. Энэ нь цаанаа маш том эрсдэл дагуулж байгааг бас онцлох нь зүйтэй. Санхүүгийн тогтолцооны гурван багана болох банк, даатгал, хөрөнгийн зах зээл тэнцвэртэй хөгжсөнөөр санхүүгийн салбар төдий чинээгээр тогтвортой, ашигтай байж цаашлаад энэ нь эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, дархлаа нь болж өгдгийг хөгжингүй орнуудын жишгээс харж болно.

Манай орны даатгалын болон хөрөнгийн зах зээлийн хөгжил маш удаашралтай явагдаж байгаа нь төрөөс бодлогоор дэмжих зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна. Уг байдлаас гарах нэг гарц нь Институциональ хөрөнгө оруулагчид (ИХО)-ыг байгуулан дэмжих юм. ИХО гэдэг нь даатгал, хувийн тэтгэврийн сан болон төрөл бүрийн хөрөнгө оруулалтын сангуудыг хэлж буй бөгөөд эдгээр

нь татан төвлөрүүлсэн их хэмжээний мөнгөн хөрөнгийг мэргэжлийн түвшинд санхүүгийн хэрэгслүүдэд хуваарилан байршуулж үнэ цэнийг өсгөх замаар хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлж байдаг бүтэц юм. Үүнд хөрвөх чадвар нь санхүүгийн тогтолцооны гол механизм болох мөнгөний илүүдлийг дутагдалтай газар руу шилжүүлэх урсгалын хэр урсамтгай байгаагийн үзүүлэлт.

ИХО-ын ажилладаг гол механизм нь мэргэжлийн баг нарийн эрсдэлийн шинжилгээ хийсний үр дүнд бүх төрлийн (Засгийн газрын, компанийн гэх мэт) үнэт цаас, бонд, компанийн хувьцаа болон зарим тохиолдолд үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийж үнэ цэнэ болон өгөөжийг өсгөдөг гэж хэлж болно. Тухайлбал, хөрөнгийн тодорхой хэсгийг харьцангуй эрсдэл болон өгөөж багатай Засгийн газрын бондод, мөн үлдсэн хэсгийг хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагдаж буй компаниудын бонд болон хувьцаанд хуваарилж тодорхой хугацаанд дундаас

нь өгөөж хүртэж ажилладаг. Хэр их хөрөнгийг хааш нь ямар хугацаатайгаар хийхийг мэргэжилтнүүд нарийн тооцоолол хийсний дүнд шийдвэрлэдэг ба энэ нь тухайн санг эрсдэл багатайгаар өндөр өгөөжтэй байлгах гол ноён нуруу нь болдог байна.

Уг мэргэжлийн тоглогчид санхүүгийн зах зээлд гарч ирснээр үүсэх давуу талуудыг салбар салбараар нь дор дэлгэрэнгүй тайлбарлая.

ДААТГАЛЫН САН

Даатгалын компаниудын ашигтай ажиллаж урт хугацаанд тогтвортой өсөлт хийх арга зам нь татан төвлөрүүлсэн хураамжийн орлогын тодорхой хувиас бүрдэж буй даатгалын нөөц сангийн хөрөнгийг үр бүтээлтэй санхүүгийн хэрэгслүүдэд байршуулж түүнээс ашиг хүртэх. Энэ жишгээр ажиллаж үсрэнгүй өсөлт хийсэн гадаадын даатгалууд Allianz, ING, Traveler's Group гэх мэт цөөнгүй. Харин манай улсад Санхүүгийн Зохицуулах Хороо даатгалын нөөц сангаас хийх хөрөнгө оруулалтыг 2013 онд батлагдан гарсан, 2015 онд шинэчлэн найруулсан журмаар хөрөнгийн ангилал бүрт дээд хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг ба энэ нь нэг талаар даатгагчдын эрх ашгийг хамгаалж байгаа боловч нөгөө талаар хөрөнгийн зах зээлд орох мөнгийг хязгаарлаж байдаг. Тухайлбал, МХБ дээр нээлттэй арилжаалагдаж буй компанийн хувьцаанд нөөц сангийн 15 хүртэлх хувийг, хөрөнгө оруулалтын санд 20 хүртэлх хувийг оруулна гэж журамд заасан байдаг.

ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САН (ХТС)

ХТС нь төрийн оролцоогүйгээр ажил олгогч болон ажилтан сайн дураар тэтгэврийн хуримтлалаа байршуулдаг сан. Энэ бүтэц нь хөгжингүй орнуудад маш өргөн хүрээнд ашиглагддаг бөгөөд ИХО-ын томоохон хувийг энэ сан эзэлдэг байна. Нийгмийн даатгалын сангийн тогтолцооны шинэчлэлийг яаралтай хийх шаардлага үүссэн өнөө үед төрийн ачааллыг багасгаж төрөөс тогтоосон тэтгэврээс гадна иргэдийг нэмэлт орлогын эх үүсвэртэй болгох гарц бол яах аргагүй хувийн тэтгэврийн сан юм. Харамсалтай нь ХТС-г зохицуулах хууль одоогоор батлагдан гараагүй байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголын хөрөнгийн бирж (МХБ) дэх хувьцааны арилжаа сүүлийн жилүүдэд буурсаар байгаа бөгөөд үүнийг эдийн засгийн удаашралтай бас холбож ойлгож болох юм. ИХО хөрөнгийн бирж дээрх хувьцааны хөрвөх чадвар сайжирах, компанийн үнэ цэнийн өсөлтийн өгөөж дотооддоо үлдэх бололцоо зэрэг олон зэрэг өөрчлөлтүүдийг авчирна. Мөн

байгууллагууд санхүүгийн бусад хэрэгслүүд болох опцион, ипотекийн зээлээр баталгаажсан бонд, дериватив зэргийг гаргахад худалдан авагч байдгүйгээс гацаанд ордог аж. Эдгээрийн худалдан авагч нь бас л ИХО байх боломжтой. Үүнээс гадна компаниудад учирдаг томоохон асуудлын нэг болох санхүүжилт босгох арга замуудын хязгаарлагдмал байдал багасна. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 2013 онд батлагдсан бөгөөд уг санг тусгай зөвшөөрөлтэй менежментийн компани эрхлэх, хөрөнгөө кастодиан банкинд хадгалах зохицуулалттай байдаг. Энэ сангийн үйл ажиллагаа эдийн засгийн тогтворгүй байдал болон санхүүгийн хэрэгслүүдийн эрсдэлтэй байдал зэргээс шалтгаалан өргөжих боломж хомос байна.

БУСАД

Сайн хөгжсөн хувьцааны зах зээл нь улс орны инновацийн эх үүсвэр болсон шинэ старт-апуудад санхүүжилт хийх нэг гүүр болсноор улс орны урт хугацаат стратегийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд нэг алхмаар ойртох юм. Өөр нэг давуу тал бол ИХО-ын хөрөнгө оруулсан компаниудын хувьцааны үнэ өсөж, олон нийтэд хүрэх мэдээллийн тэгш бус байдал багасаж компанийн засаглал сайжрахад томоохон түлхэц болдог.

Хэдийгээр ИХО-дын хөгжил маш олон давуу талыг үүсгэх боловч, энэхүү бүтцийн хууль, хяналтыг анхнаас нь ул суурьтай нарийн шийдэхгүй бол маш том эрсдэлийг дагуулж байдгийг анхаарах нь бас зүйтэй. АНУ-ын 2008 оны оны эдийн засгийн их хямрал олон хүчин зүйлсээс шалтгаалан эхэлсэн боловч түүний нэг нь санхүүгийн хэрэгслүүдийн, тухайлбал, ипотекийн зээлээр баталгаажсан бондын хяналтгүй худалдаанаас болсон байдаг.

ИХО-чдыг үүсгэн байгуулж үйл ажиллагааг дэмжихэд хууль эрх зүйн орчныг оновчтойгоор, олон улсын жишигт нийцүүлэн гаргах нь хамгийн эхний алхам бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) үүнийг бодлогын түвшинд дэмжин Люксембургийн Вант улсын “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх” MON/004 төсөлтэй энэ оноос хамтран ажиллаж байна. Уг төслийн хүрээнд СЗХ хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах, зохицуулах байгууллагын хяналтын чадавхийг сайжруулах, төсвийн болон төсвийн гадуурх сангуудын сул чөлөөтэй хөрөнгийг үнэт цаасны зах зээлд татан оруулах ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн хөрөнгө оруулалтын зах зээлийн хөгжилтэй уялдуулан оюутан залуус маань энэ салбарт түлхүү судалгаа хийн өндөр түвшинд бэтгэгдэх нь бас чухал. ■



ХҮҮХДИЙН ЭРХ



НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч Роберт Бэнес

"Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудал сэтгэл зовоож байна"

И.Отгон

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсны 25 жилийн ойн өдөр эл өдрүүдэд тохиож байгаа билээ. Тиймээс Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын нэг болох НҮБ-ын Хүүхдийн сангийн Суурин төлөөлөгч Роберт Бэнесийн үгийг уншигчдадаа хүргэхийг зорилгоо. Тус байгууллага Монголд хүүхдийн эрхийн асуудлаар сайн судалгаанууд хийж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна холбогдох төрийн байгууллагуудад санал, зөвлөмж өгч бодлогын түвшинд нэлээд хамтарч ажилладаг билээ.

-Юуны өмнө танд болон танай хамт олонд Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсны ойн баярын мэнд хүргэе. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд Монголд хүүхдийн эрх хэрхэн хангагдсан гэж та үзэх вэ. Хамгийн гол алдаа, оноо юу байсан талаар товчхон дүгнэж хэлэхгүй юү?

Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсноос хойш Монгол Улсад

хүүхдийн төлөө гарсан дэвшил үлэмж их гэдэг нь маргаангүй. Тухайлбал, 1990-2013 оны хооронд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 35-79 хувь болтол өссөн. 1990 оноос хойш тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2/3-аар, тураалтай хүүхдийн тархалт 90 гаруй хувиар буурсан. Бага боловсролын дүүргэлт 1990-ээд оны дунд үед 75 хувьтай байсан бол 2000 оноос хойш 98 хувь болж өссөн. Үүнээс гадна хүүхэд хамгаалал зэрэг салбарт ч ахиц дэвшил гарсан. 2006 онд хүүхдийг сургуулийн орчинд зодож шийтгэхийг хуулиар хориглосон. Энэ бүх амжилт бол Монгол Улсын Засгийн газар хүүхдийн асуудлыг бодлогын түвшинд тэргүүн эгнээнд тавьж ирсний гавьяа. Үүнийг НҮБ-ын Хүүхдийн сан ч байнга дэмжиж ирсэн. Бид энэ хугацаанд Монголын Засгийн газрын ойрын түнш, хамтрагч байсан. Бидний хамтын ажиллагаа 50 гаруй жилийн түүхтэй шүү дээ.

Тэгвэл энэ бүх амжилт зөвхөн үндэсний дундаж тоо баримтыг илтэх бус аймаг, сум, дүүрэг бүрт ийм өндөр байлгах нь өнөөдөр бидний нэн тэргүүний зорилт юм. Гаргасан ахиц дэвшил хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй

хүрч чадахгүй байгаагийн дээр нийгэм, эдийн засгийн хувьд тэгш бус байдал улам нэмэгдэж, эмзэг бүлгийн хүүхдүүд маань хөгжлийн ард хоцорч байна. Тиймээс энэ тэгш бус байдлыг арилгахын төлөө ажиллах нь нэн чухал. Тухайлбал, баруун аймгуудад төрсөн хүүхэд Улаанбаатарт төрсөн хүүхэдтэй харьцуулахад таван нас хүрэхээсээ өмнө эндэх эрсдэл дөрөв дахин их. Хүүхдийн эндэгдэл ядуу өрхөд чинээлэг өрхөөс дөрөв дахин их байх жишээтэй. Хөдөө орон нутагт өсөлт хоцролтын түвшин хот суурин газартай харьцуулахад хоёр дахин их байгаа бол ядуу айлын хүүхдүүд чинээлэг айлын хүүхэдтэй харьцуулахад өсөлт хоцролттой байх эрсдэл гурав дахин их байна. Ийм тэгш бус байдал улс орны хөгжлийг сааруулж байгаа юм. Учир нь эдийн засаг өслөө гээд нийгмийн бүхий л салбар шууд өсөлт бий болно гэсэн үг биш. Иймээс НҮБ-ын Хүүхдийн сан нь Монгол Улсын өнцөг булан бүрт байгаа бүх хүүхдийг адил тэгш боломжоор хангагдаж, нийгмийн үйлчилгээ, хамгаалалд тэгш хамруулахын төлөө ажилладаг. Гэвч энэ амар ажил биш. Тэгш бус байдал нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

Ядуурал, жендэр, үндэс угсаа, гарал үүсэл, шашны болон бусад соёлын хамаарал, хөгжлийн бэрхшээл, оршин суугаа газар зүйн байршил зэрэг олон зүйлээс шалтгаалж байна.

Энэ асуудлыг одоо л шийдвэрлэхгүй бол тэгш бус байдлын сөрөг үр дагавар хүүхдэд бүхий л амьдралынх нь турш нөлөөлж, өв тэгш өсч хүмүүжих боломжийг нь хязгаарлаж, ядуурлыг бууруулж үл чадна.

Тэгш бус байдлыг ёс суртахууны хувьд хүлээн зөвшөөрч үл болно. Хүний эрхийн байгууллагын хувьд бид үүн дээр хатуу байр суурьтай байдаг. Тэгш бус байдал нь улс орны хөгжил, ирээдүйн потенциалд ч сөрөг муу нөлөөтэй. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) судалгааны дүнгээр орлогын тэгш бус байдал нэмэгдэхэд эдийн засгийн өсөлт унадаг гэсэн байна. Тэгш бус байдлыг арилгаснаар бидний нийгэм илүү шударга, эдийн засаг илүү хүчтэй болох юм. Тийм ч учраас Монголын ирээдүйн хөгжлийн стратегийг тодорхойлох улс төрийн чухал шийдвэр гаргах үед тэгш байдлыг үндэсний тэргүүлэх асуудал болгох хэрэгтэй. Тэгш байдал нь Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн үйл ажиллагааны нэн тэргүүний зорилт байгаа, байх ч болно. Учир нь зөвхөн энэ л улс орны маргаашийг тодорхойлно.

-Өнөөдөр манайд хүүхдийн эрхийн асуудал дээр болохгүй байгаа зүйл бишгүй бий. Таны хувьд хамгийн санаа зовоосон тулгамдсан асуудал нь юуг гэж харж байна вэ. Яагаад?

Сүүлийн 25 жилийн хугацаанд хүүхдийн асуудлаар гаргасан амжилт их ч зарим нэг салбарт ахиц дэвшил сул буюу зогсонги байна. Сэтгэл зовоосон нэг асуудлыг сонго гэвэл би ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудал гэнэ. Энэ салбарт Монгол Улс их удаан урагшилж байгаа бөгөөд Төв болон Зүүн Хойд Азийн ихэнх орнуудын ард хоцорч яваа. Сайжруулсан ундны усны хэрэглээ үндэсний хэмжээнд 64 хувьтай, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээ 59 хувь байгаа ч энэ тоог задлаад үзвэл газар зүйн байршил, орлогын түвшингээс хамаарч ялгаатай байна. Тухайлбал,

хотод 73 хувь нь сайжруулсан ундны ус хэрэглэж байхад хөдөө орон нутагт энэ тоо дөнгөж 58 хувь байна. Энэ үзүүлэлт орлогын түвшингээс хамаарч бүр ч их ялгаатай. Ядуу айл өрхийн ердөө 41 хувь сайжруулсан ундны ус хэрэглэж байхад чинээлэг өрхийнх 99,9 хувь байх жишээтэй.

Цаашлаад сайжруулсан ариун цэврийн байгууламж буюу боловсон жорлонгийн хэрэглээ хотод 69 хувь байхад хөдөөд дөнгөж 39 хувь байна. Энэ үзүүлэлт ядуу өрхөд 19 хувь, чинээлэг өрхөд 99 хувь байна. Ус, ариун цэврийн байгууламжийн үзүүлэлт ийм муу байгаа нь хүүхдүүдийн маань ирээдүйд сөргөөр нөлөөлж байгаа юм. Учир нь ундны ус, ариун цэвэр муу байгаа нь хүүхдийн олон төрлийн өвчлөлийн голлох шалтгаан болж байгаа, улмаар улс орны хувьд ч сөрөг үр дагавартай. Ариун цэвэр, эрүүл ахуй муу байгаагаас Монголын эдийн засагт жилд 35.5 тэрбум төгрөг буюу 26 сая ам.долларын хохирол учирдаг гэсэн тооцоо бий. Энэ нь ДНБ-ий 0,5 хувьтай тэнцэнэ.

-Тэгвэл дэвшил гаргах боломжтой нь юу байх вэ?

-Дэвшил гарах боломжтой бас нэг салбар бол сургуулийн өмнөх боловсрол. Энэ үзүүлэлт Монголд 68 хувьтай байгаа ч хот, хөдөө, гэр хороолол хоорондоо болон өрхийн орлогын түвшингээс шалтгаалан нэлээд ялгаатай. НҮБ-ын Хүүхдийн сангаас сургуулийн өмнөх боловсрол, хөгжлийн асуудлыг үр өгөөж хамгийн ихтэй гэдгээр нь нэн чухалчлан авч үздэг. Хүүхдийн бага нас гэдэг оюун ухаан, хувь хүн, зан чанар, сурах болон ирээдүйд өөрийгөө авч явах зэрэг чухал чадвар, чадамжууд төлөвшдөг үе юм. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхэд сургуульд ороод, сайн сурах магадлал өндөр байдаг. Том болсон хойноо ч цэцэрлэгт яваагүй хүүхэдтэй харьцуулахад сайн ажилд орох, өндөр орлого олох, эрүүл саруул байх магадлалтай, улмаар нийгмийн халамжаас хамаарах, гэмт хэрэгт холбогдох магадлал бага байдаг. Сургуулийн өмнөх боловсролд оруулсан нэг ам.долларын хөрөнгө оруулалт тутамд 12.90 ам.долларын ашиг ирдэг.

-Хүүхэд бүр хуулиар заасан

үндсэн эрхүүдээ бүрэн эдэлж чаддаг болохын тулд манай улс бодлогын түвшинд цаашид юу хийх шаардлагатай вэ. Мөн НҮБ-ын Хүүхдийн сан голлон юунд анхаарч ажиллахаар байгаа вэ?

Өнөөдөр Монгол Улсад байгалийн баялаг, өсөн дэвшиж буй хувийн хэвшил, эрч хүчтэй удирдагч нар, залуу, идэвхтэй ард иргэд гээд хаана ч байхгүй их нөөц боломж байна. Эдгээр боломжийн үр өгөөжийг хүртэхийн тулд хүүхдийн төлөө холыг харсан, зөв шийдвэрийг цаг алдалгүй гаргах ёстой. Эдийн засаг өслөө ч түүнийг тогтвортой авч явах хүний нөөц байхгүй бол өсөлт байхгүй гэсэн үг. Тийм учраас НҮБ-ын Хүүхдийн сангийн байр суурь бол Монгол Улс хойч үедээ хөрөнгө оруулалт хийснээр ирээдүйн хүний нөөц, тогтвортой хөгжлийнхээ үндэс суурийг тавьж чадна. Үүний тулд ус, ариун цэврийн байгууламж болон бусад нийгмийн чанартай суурь үйлчилгээний хүртээмжийг гэр хороолол, алслагдмал хөдөө орон нутгийн эмзэг, ядуу өрхийн хүүхдүүдэд хүргэх бодлогын шийдвэрүүд гаргах шаардлагатай байна. Түүнчлэн эргэх ашиг өндөртэй салбар болох сургуулийн өмнөх боловсрол, өсвөр үеийн хөгжил зэрэг салбарт хөрөнгө оруулалт хийж, урт хугацаанд гарах үр өгөөжийг нь ойлгох алсын хараатай байх хэрэгтэй. Макро эдийн засгийн өөрчлөн байгуулалт хийгдэх үед буюу төсөв танагдах, тэгш бус байдлыг арилгах нөөцийг хуваарилах үеэр хүүхдэд зарцуулах төсөв хөрөнгийг хамгаалах нь нэн чухал. Мөн эмзэг бүлгийн хүн амын даван туулах чадварыг нэмэгдүүлэх тогтвортой нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох шаардлагатай. Тогтолцоог бий болгох, бэхжүүлэх талаас нь бодох нь зөв зүйтэй. Тогтолцоо сайн бол хүүхдийг аливаа хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалж чадна. Сайн бэлтгэгдсэн, салбар хоорондын зохицуулалт, уялдаа сайтай төрийн үйлчилгээ (хууль сахиулах, шүүх, нийгмийн халамжийн салбарууд) бүхий хүүхэд хамгааллын тогтолцоо нь аливаа хүчирхийллээс ангид өссөн, өв тэгш өсч хүмүүжсэн Монголын нэгэн үеийг гаргаж ирэхэд чухал үүрэгтэй.

Энэ бүх ажлыг хийхэд, цаашлаад

Монголын хүүхэд багагчуудыг өв тэгш өсч, ирээдүйн бүтээлч иргэд болоход нь манай НҮБ-ын Хүүхдийн сан өөрийн бүхий л нөөц бололцоо, хүчин чармайлтаа гарган, Засгийн газартай хамтран ажиллахад бэлэн байгаагаа энэ дашрамд дурдъя. Манай байгууллага Монголын хүүхэд бүрт, тэр дундаа эмзэг бүлгийн хүүхдүүдэд тэгш хүрч ажиллах, улмаар хүүхдийн эрхийг хангадаг, хамгаалдаг бодлогын орчинг бий болгох үндсэн зорилготой. Бид хүүхдийн төлөөх нийгмийн бодлого, тогтолцоо, төсөв зэрэгт нөлөөлж, тогтвортой хөгжлийг бий болгохын зэрэгцээ орон нутгийн

түвшинд хүүхдийн төлөө бодитой үр дүн гаргахын төлөө ажиллаж байна. Ингэхдээ бид хүүхэдтэй холбоотой салбарт дээд зэргийн мэргэжлийн мэдлэгийг оруулж ирж, тоо баримт цуглуулан, түүн дээрээ дүн шинжилгээ хийж, хүүхдэд ээлтэй бодлого, хөтөлбөр, төсөв гаргуулахын төлөө нөлөөллийн ажлуудыг хийж байна. Мөн хүүхдийн асуудлаар үндэсний болон олон улсын зохих оролцогч талуудтай санал солилцох, хамтын ажиллагааны боломжийг судлахад хөрөнгө оруулах нь бидний ажлын нэг хэсэг юм. Үүнээс гадна бид Монголд дэлхийн шинэ санал,

санаачилгуудыг хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг оруулж ирэхийн тулд олон улсын мэдлэгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх болно.

Өнөөдөр Монгол Улс ирээдүйн хөгжлийг нь тодорхойлох улс төрийн шийдвэр гаргах чухал цаг мөчид тулж ирээд байна. Улс орон бүрийн хамгийн чухал баялаг нь түүний ард иргэд, хойч үе, хүүхэд багачууд байдаг. Энэ баялаг дээрээ түшиглэн Монголын гэрэлт ирээдүйг цогцлооход нь НҮБ-ын Хүүхдийн сан өөрийн хувь нэмрийг оруулахад бэлэн байгаагаа илэрхийлье. ■

СУДАЛГАА

Нийгмийн хөгжлийн индекс 2015: ДНБ-ээс давж харах нь

Д.Ончинсүрэн /“Делоитт онч” компанийн захирал /

Хүн төрөлхтөн өнгөрсөн 80 жилийн туршид Дотоодын нийт бүтээгдэхүүнээр эдийн засгийн хөгжлийг хэмжиж ирлээ. Харин нийгмийн хөгжлийг хэмжих хэмжүүр байсангүй. Энэ тухай хэдэн жилийн өмнө Дэлхийн эдийн засгийн форум дээр хэлэлцэж байсныг үндэслэн Харвардын Бизнесийн сургуулийн профессор Майкл Портер “Social Progress Imperative” хэмээх ашгийн бус байгууллагыг санаачлан байгуулж нийгмийн хөгжлийг хэрхэн хэмжих талаар судлах болсон байна. “Делоитт” 2013 оноос эхлэн “Social Progress Imperative” байгууллагатай хамтран ажиллах болсон бөгөөд энэхүү “Нийгмийн хөгжлийн индекс”-ийг хамтран боловсруулж 2014 оны дөрөвдүгээр сарын 3-нд анх удаа олон нийтэд танилцуулсан юм.

Нийгмийн хөгжлийн индекс нь Дэлхийн эдийн засгийн форумд эрхлэн гаргадаг өрсөлдөх чадварын индексээс илүү өргөн хүрээг хамардаг. Тус индексийг боловсруулж танилцуулсан нь улс орнуудын засгийн газар, бизнесийн болон иргэний нийгмийн гишүүд илүү идэвхтэй

хамтран ажиллаж, дотооддоо нэн тулгамдсан асуудлыг тодорхойлон нийгэмдээ хөрөнгө оруулахад тус нэмэр үзүүлэх зорилготой. Энгийнээр хэлбэл улс орны түвшинд нийгмийн болон хүрээлэн буй орчны үзүүлэлтүүдийг нэгтгэн харуулдаг нэгдмэл хэмжүүр юм. Үүнд өндөр болон буурай хөгжилтэй бүхий л орнуудыг хамруулдаг онцлогтой.

Индексийг тооцоолохдоо доорх зарчимд тулгуурлан эмпирик судалгааны үр дүнд гарсан нийт 52 салбарын үзүүлэлтийг тусгадаг:

- Зөвхөн нийгмийн ба байгаль орчны үзүүлэлтийг авч үзнэ.
- Зарцуулсан хөрөнгө, хөдөлмөр бус хүрсэн үр дүн чухал.
- Нэгдмэл бөгөөд бүх улс орнуудыг хамарсан.
- Үр дүнд үндэслэн дүгнэлт хийж сайжруулах арга хэмжээ авах боломжтой.

Үүний үр дүнд зөвхөн нийгмийн болон байгаль орчны хувьд тухайн нийгмийн хөгжлийг харуулдаг цорын ганц хэмжүүр болох Нийгмийн Хөгжлийн Индексийг тооцоолж гаргадаг.

“Делоитт”, “Social Progress Imperative” байгууллага хамтран 2015 онд нийт 133 орныг бүрэн, 28 орныг хэсэгчлэн хамруулж судалсан юм. 2014 онд Монгол улс 132 орноос 89 дүгээрт эрэмбэлэгдэж байсан бөгөөд энэ жил хэдэн алхам урагшилсан эсвэл ухарсныг та дараах судалгааны нүүрээс сонирхож болно. Мөн Монголыг нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр ойролцоо орнуудтай харьцуулсан үзүүлэлтийг харах боломжтой.

Энэхүү индексстэй танилцсанаар Монгол улсын бодлого боловсруулагчид, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагууд улс орны болон байгууллагын хөгжлийн стратегийг боловсруулахад шаардлагатай мэдээлэл олж авна гэдэгт итгэлтэй байна.

XXI зуунд иргэдийн сайн сайхан амьдрал нь зөвхөн эдийн засгийн хөгжлөөс бус илүү олон зүйлсээс хамаардаг болсон. Тэр бүхнийг илэрхийлэх шинэлэг хэмжигдэхүүн байхаар загварчилсан тул нийгмийн хөгжлийг огт өөр, шинэ өнцгөөс үнэлж хэмжих боломжийг олгох болно.

СУДАЛГАА



Нийгмийн хөгжлийн индексийн эрэмбэ: 81/133

Нийгмийн хөгжлийн индексийн оноо: 61.52

Нэг хүнд ноогдох ДНБ-ээр эрэмбэлэхэд: 79/133

Нийгмийн хөгжлийн индекс

Хүний үндсэн хэрэгцээ

Хоол тэжээл ба эмнэлгийн үндсэн үйлчилгээ
Цэвэр ус ба эрүүл ахуй
Байр орон сууц
Хувийн аюулгүй байдал

Амьдрах орчин нөхцөл

Анхдагч боловсролын түвшин
Мэдээлэл авах холбоо харилцаагаар хангагдсан байдал
Эрүүл мэнд
Байгаль орчинд ээлтэй байдал

Боломж

Хувь хүний эрх
Хувь хүний эрх чөлөө ба сонголт
Нийгмийн нээлттэй байдал
Ахисан түвшний боловсрол эзэмших боломж

Нийгмийн хөгжлийн индексийн хамрах хүрээ
Анхдагч болсон индекс – эдийн засгийн үзүүлэлт ороогүй зөвхөн нийгмийн болон байгаль орчны үзүүлэлтүүдээр хэмждэг




-2015 онд 133 орны индексийг тооцоолсон бөгөөд нэмж 28 орны хувьд зарим нэг индексийг гаргасан.

-Дараах гурван асуултад хариулахын тулд нийт 52 үзүүлэлтийг авч үздэг:

1. Тухайн улс хүн амынхаа үндсэн хэрэгцээг хангаж чадаж байна уу?
2. Хүмүүсийг амьжиргаагаар дээшлүүлэхэд шаардлагатай үндсэн нөхцөлүүдээр хангасан байна уу?
3. Нийгэм дэх байр сууриа сайжруулах боломж хүмүүст байгаа юу?

	Оноо	Эрэмбэ	
ХҮНИЙ ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ	58.36	103	
Хоол тэжээл ба эмнэлгийн үндсэн үйлчилгээ	82.99	93	
Хоол тэжээлийн дутагдалтай(хүн амын %)	22.4	113	
Тэжээлийн дутагдалын зэрэг (кал./тэжээлийн дутагдалтай хүмүүс)	173	116	
Эхийн эндэгдэл (нас баралт/100,000 амьд төрөлт)	68	70	
Хүүхдийн эндэгдэл (нас баралт/100,000 амьд төрөлт)	31.8	87	
Халдварт өвчний улмаас нас баралт(нас баралт/100,000)	82.8	74	
Цэвэр ус ба эрүүл ахуй	46.66	106	
Цэвэр усны системд холбогдсон байдал (хүн амын %)	23.6	100	
Орон нутагт цэвэршүүлсэн усаар хангагдсан байдал (хүн амын %)	61.2	113	
Бохир усны системд холбогдсон байдал (хүн амын %)	56.2	98	
Байр орон сууц	34.42	119	
Хямд өртөгтэй байр сууцаар хангагдсан байдал (сэтгэл хангалуун %)	21.7	128	
Цахилгаанаар хангагдсан байдал (хүн амын %)	86.2	86	
Цахилгааны хангалтын чанар (1=муу, 7=сайн)	3.6	87	
Барилга доторх агаарын бохирдлын улмаас нас баралт (нас баралт/100,000)	222.3	132	
Хувийн аюулгүй байдал	69.38	46	
Амьсгал хорлолын түвшин (1= <2/100,000, 5= >20/100,000)	3	77	
Хүч хэрэглэсэн гэмт хэргийн тоо (1=бага, 5=өндөр)	3	61	
Гэмт хэргийн хүлээлт (1=бага, 5=өндөр)	2	2	

	Оноо	Эрэмбэ		Оноо	Эрэмбэ
АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛ	64.49	92	БОЛОМЖ	61.71	39
Авчдагч боловсролын түвшин	97.66	25	Хувь хүний эрх	73.99	35
Насан хүрэгэдийн бичиг үсэг тайлагдсан байдал (15+ насны хүн амын %)	98.4	46	Улс төрийн эрх (1=бүрэн эрхтэй; 7=огт эрхгүй)	1	1
Бага сургуульд хамрагдсан байдал (хүүхдүүдийн %)	97.3	34	Үзэл бодлоо илэрхийлэх эрх (0=бага; 2=өндөр)	1	15
Дунд сургуульд хамрагдсан байдал (хүүхдүүдийн %)	93.5	68	Эвлэлдэн нэгдэх эрх (0=бага; 2=өндөр)	2	1
Ахлах сургуульд хамрагдсан байдал (хүүхдүүдийн %)	121.6	1	Аялах, зорчих эрх (0=бага; 4=өндөр)	4	1
Дунд ба ахлах сургуулийн сурагчдын хүйсийн харьцаа (охиол/хөвгүүд)	1.0	1	Хувийн хөрөнгийн эрх(0=байхгүй; 100=бүрэн)	30	70
Мэдээлэл авах холбоо харилцаагаар хангагдсан байдал	65.95	82	Хувь хүний эрх чөлөө ба Сонголт	64.48	51
Үүрэн холбоо хэрэглэгчид (хэрэглэгчийн тоо/100 хүн)	124.2	1	Сонгох эрх чөлөө (сэтгэл хангалуун %)	67.9	77
Интернет хэрэглэгчид (хүн амын %)	17.7	95	Шашин шүтлэгийн эрх чөлөө (1=мүү; 4=сайн)	3	55
Хэвлэлийн эрх чөлөөний индекс (0=эрх чөлөөтэй, 100=багаг эрх чөлөөгүй)	30.3	67	Эрт гэрлэлт (15-19 насны эмэгтэйчүүдийн %)	0.04	38
Эрүүд мэнд	58.42	113	Хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх боломжтой (эмэгтэйчүүдийн %)	71.7	55
Дундаж наслалт (жилээр)	67.3	94	Авшигал (0=өндөр; 100=бага)	39	62
Халдварт бус өвчний улмаас нас баралт (нас барах магадлал)	32.0	131	Нийгмийн нээлттэй байдал	55.93	53
Хэт тэргэлтэн түвшин (хүн амын %)	16.4	50	Цагаачдыг хүлээн зөвшөөрөх байдал (0=муу; 100=сайн)	31.5	129
Гадаа агаар бохирдлын улмаас нас баралт (нас баралт/100,000)	22.2	56	Ижил хүйстнүүдийг хүлээн зөвшөөрөх байдал (0=муу; 100=сайн)	8.2	95
Амни хорлолтын түвшин (нас баралт/100,000)	12.2	94	Цөөнхийг ялгаварлах, эсрэг хүчирхийлэл үйлдэх (0=бага; 10=их)	4	20
Байгаль орчинд ээлтэй байдал	35.92	123	Шашин шүтлэгийг хүлээн зөвшөөрөх байдал(1=муу; 4=сайн)	4	1
Хүлэмжийн хийн ялгаруулалт (ДНБ ноогдох CO2 тэнцүүлэх нэгж)	1415.8	113	Нийгмээс тусалцаа авах боломж (0=муу; 100=сайн)	94.1	9
Усны хэрэглээг нөөцөд харьцуулбал	4.0	118	Ахисан түвшний боловсрол эзэмших боломж	52.43	49
Шим мандлын төрөл зүйлс ба амьдрах орчин (0=хамгаалдаггүй; 100= сайн хамгаалдаг)	73.3	48	Дээд боловсрол эзэмших хугацаа	0.9	22
			Эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших дундаж хугацаа	10.3	68
			Боловсрол олж авахад ялгаварладаг эсэх. (0=үгүй; 1=их)	0.05	25
			Олон улсад эрэмбэлэгдсэн их дээр сургуулийн тоо	0	76

 Харьцангуй давуу талтай
 Дундаж
 Харьцангуй сул талтай
 n/a Өгөөдөл байхгүй

Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээгээр ойролцоо дараах 15 улстай харьцуулбал:

Украин, Эл Салвадор, Парагвай, Ангол, Шри Ланк, Ямаик, Индонез, Армян, Гватемал, Намиби, Марокко, Гүрж, Босни ба Херцоговина, Свазиланд, Гуяна

Эх сурвалж: "Делойтт онч" ХХК

ЕРТӨНЦ



Цуст баасан гараг

Б.Энхмөнх

Францын нийслэл Парис хотноо 2015 оны арваннэгдүгээр сарын 13-ны орой зохион байгуулалттай цуврал террорист халдлага болсон билээ. Уг халдлагаар террористууд олон нийтийн дунд шууд гал нээх, амиа хорлох бөмбөг тэслэх, мөн барьцаалах зэрэг үйл ажиллагааг бараг нэгэн зэрэг эхэлсэн байна. Төв европын цагаар 21 цаг 20 минутад Франц-Германы хөл бөмбөгийн багийн нөхөрсөг тоглолт “Stade de France” цэнгэлдэхэд болж байх үед цэнгэлдэхийн гадна гурван амиа хорлогч террорист тэсрэх бөмбөг тэсэлснээр эхэлжээ. Ингэснээр олон нийтийн дунд гал нээж эхэлсэн бөгөөд өөр дөрвөн ч газар тэсрэх бөмбөг дэлбэлсэн аж. Хамгийн олон хүний амийг авч одсон халдлага Парисын Батаклан Театрт болсон бөгөөд ойролцоогоор 89 хүн амь үрэгдсэн гэж мэдээлсэн юм. Уг театрт барьцаалагчид шөнийн 00:58 минут

хүртэл цагдаагийн албаныхантай галт мөргөлдөөн хийжээ. Халдлагын улмаас ойролцоогоор 352 хүн эмнэлэгт хүргэгдсэн ба үүний 80 нь хүнд гэмтэл авчээ. Уг халдлагын улмаас нийт 129 хохирогчид амиа алдсан ба халдлагыг үйлдсэн найман этгээд мөн амиа алджээ. Уг халдлагыг Исламын улс террорист бүлэглэл үйлдсэн болохоо мэдэгдээд байгаа юм. Исламын улс халдлагыг Франц улс Сири улсад явуулж буй тус бүлэглэлийн эсрэг үйл ажиллагаанд оролцож байгаагийн шан гэжээ.

Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд энэхүү террорист халдлагыг урьд өмнө тус улсад болж байгаагүй халдлага гэж цохон тэмдэглэв. Энэхүү халдлагын улмаас Олландын засгийн газар хилийн хяналт, цэрэг цагдаагийн хүчээ нэмэгдүүлж үндэсний онцгой байдлыг зарлах болсноо мэдэгдсэн юм. Халдлагыг үйлдэгч террористуудын

нэг “Та нар Сирид юу хийж байгаа юм бэ? Одоо шангаа хүртэцгээх болно. Аллах Акбар!” хэмээн хашгирч байсан хэмээн халдлагын гэрч хэлжээ. Харин бямба гаригийн өглөөнөөс түргэн тусламжийн машин нааш цааш яаран давхиж байсан ба олон зуун амьд үлдэгсдийг нүүлгэн шилжүүлж байв. Францын телевизийн мэдэлснээр Парисын эмнэлгүүд шархагдагсдаар дүүрч өндөр ачаалалтай ажиллаж байна гэжээ.

Парисын цагдаагийн газрын дарга Мишел Кадо хэлэхдээ халдлага үйлдэгчид бүгд амь үрэгдсэн гэж бодож байна гэв. “The Associated Press” агентлагийн мэдээлснээр Парисын прокурорын газар халдлага үйлдсэн найман этгээд үхсэн гэж мэдэгдсэн гэлээ. Тийм боловч халдлагыг үйлдсэн, халдлагад гар бие оролцож хамт төлөвлөсөн нийт хэдэн хүн байгаа нь бүрэн тодорхойгүй байгаа

аж. Харин арваннэгдүгээр сарын 18-ны өдөр Парисын хойд захад орших “Saint-Denis” дүүрэгт уг халдлагыг зохион байгуулсан байх магадлалтай этгээдүүдийн хорогдож байсан газарт Францын тусгай албаныхан тусгай ажиллагаа явуулснаар найман этгээдийг баривчилж, хоёр сэжигтэн газар дээрээ амиа алджээ.

Харин халдлагыг төлөвлөсөн гэх гол сэжигтнээр Бельги улсын иргэн, Франц болон Бельги улсад хэд хэдэн террорист үйл ажиллагаа үйлдсэн жихадист Абдэлхамид Абаоуд гэх этгээдийг нэрлэсэн юм. Тусгай албаныхан Абаоудыг сэжигтнүүдийн байрлаж байсан барилгын гурван давхарт бүгэж байгаа гэж таамаглаж байжээ. Сэжигтнүүдийн утасыг чагнаж Абаоудын садан төрлийн хүн уг газарт байгааг мэдсэний дараагаар ажиллагааг эхлүүлсэн бөгөөд сэжигтнүүд хүчтэй тэмцэл өрнүүлж буудалцаан өрнөснөөр барахгүй нэг эмэгтэй өөрийгөө дэлбэлсэн гэх мэдээлэл байна. Абдэлхамид Абаоуд тусгай ажиллагааны явцад үхсэн гэж мэдээлж байгаа ч Францын албаныхан албан ёсны мэдэгдэл хараахан хийгээгүй байна.

Францын хариу цохилт

Өнгөрсөн ням гарагт буюу арваннэгдүгээр сарын 15-ны өдөр Францын сөнөөгч онгоцууд Исламын улсын гол цэгүүдийн нэг болох Сири улсын Ракка хотод цуврал агаарын цохилт үзүүллээ. Уг агаарын цохилт Парис хотноо халдлага болсноос хоёр өдрийн дараагаар хийсэн бөгөөд Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд Исламын улсын халдлагыг “дайны сэдэлтэй үйлдэл” хэмээн тодорхойлсон юм. Исламын улс Ракка хотыг өөрийн халифатын нийслэл хэмээн нэрийддэг аж. Ням гаригийн агаарын цохилтын гол байнд Исламын улсын удирдлагын төв, эслсүүлэх төв, буу сум хадгалах агуулах болон террорист бүлэглэлийн бэлтгэлийн бааз байсан хэмээн Францын батлах хамгаалахын сайдын хэвлэл мэдээллийн зөвлөх Микаел Сория хэлэв. Агаарын цохилтод 12 онгоц, түүний дотор 10 сөнөөгч онгоц ашигласан бөгөөд бүх зорилтот цэгүүдээ устгаж чадсан гэж Сория



Францын тусгай албаныхан Парисын “Saint Denis” дүүрэгт тусгай ажиллагаа явууллаа

мэдэгдсэн юм.

Харин уг агаарын зохилт үнэн хэрэгтээ ямар үр дүнтэй байсан нь тодорхойгүй юм. Ракка хот доторх жинхэнэ байдлыг мэдэхэд маш хүнд аж. Харин тус хот дотроос “Раккаг чимээгүйгээр алж байна” гэж өөрсдийгөө нэрийдсэн тэмцэгч бүлэг мэдээлэл өгч эхэлжээ. Тэд хэлэхдээ Исламын улс тус хотыг эрхшээлдээ оруулж авснаас хойш тус хот бусад хот суурингаас тусгаарлагдсан бөгөөд энгийн иргэд Исламын улсын дарангуйлал дор байгаа гэв. Тэмцэгч бүлгийнхэн хэлэхдээ тус хот ням гаригт агаарын цохилт өгөхөөс өмнө бэлтгэж эхэлсэн хэмээжээ. Тэдний мэдэгдэж байгаагаар Исламын улсын дайчид Раккад хариу агаарын цохилт өгөхийг таамаглаж байсан ба гол байгууламж, үйл ажиллагааны төв болон зэр зэвсгээ нүүлгэн шилжүүлсэн байсан гэжээ. Агаарын цохилтоор Исламын улсын гол баазууд байсан хотын цэнгэлдэх хүрээлэн зэрэг байгууламжуудыг устгасан ч Исламын улсад төдийлөн хохирол учруулж чадаагүй гэж үзэж байгаа аж. Тэмцэгч бүлэглэлийн мэдэгдсэнээр энгийн иргэд уг цохилтын үр дүнд амь үрэгдээгүй гэж мэдэгдсэн юм.

Харин Сирийн Ерөнхийлөгч Башар ал-Ассад “Францын иргэд болон засгийн газарт эмгэнэл илэрхийлж байна, Парист болсон шиг нөхцөл байдлыг Сирийн иргэд таван жилийн

турш мэдэрч байна” гэжээ.

Парист болсон халдлагад дэлхий нийтээр эмгэнэл илэрхийлж байгаа. Улс орнууд өөрсдийн бэлэг тэмдэг болсон барилгуудыг Франц улсын төрийн далбаан өнгөөр гэрэл тусган чимэглэж байна. Мөн социал ертөнцөөр уг халдлагад эмгэнэл илэрхийлэх хүмүүсийн тоо хэдэн тэрбумд хүрч байгаа бололтой. Фэйсбүүкээр хүн бүр өөрсдийн зургаа Франц улсын төрийн далбайн өнгөнд уусгаж Твиттерээр “Парисын төлөө залбирцгаая” зэрэг “hashtag”-уудыг ашиглаж буй. Социал ертөнцийн эмгэнэл илэрхийлэх давалгаа Монголд ч хүчээ авч зарим франц хэлтнүүд болон сайн дурынхан Францын Элчин сайдын яамны байрны гадаа жагсаж эмгэнэл илэрхийлж байгаа харагдсан. Монгол Улсын Гадаад хэргийн яамны сайд Л.Пүрэвсүрэн Франц улсын Гадаад хэрэг, олон улсын хөжлийн сайд Лоран Фабиуст эмгэнэлийн захидал илгээсэн бөгөөд захидалд амь үрэгдэгсдийн гэр бүл, төрөл төрөгсдөд эмгэнэл илэрхийлж, террорист халдлагыг буруушааж буйгаа илэрхийлжээ.

Гэвч социал ертөнцөд өөр нэг эмгэнэл илэрхийлэгчид гарч иржээ. Тэд Францын болон барууны улсуудын агаарын цохилтоор Сири улсын энгийн иргэд хохирч байна, Парист болсон халдлага тэдний дэргэд өчүүхэн зүйл гэж үзэж байгаа юм. ■